

Together

for tomorrow

Strategic Partner

 BREITLING 

Corporate partner

StoneX  

Partner Organization

Supporting Organization


European Bank
for Reconstruction and Development





 UNITEL


MONGOLIAN PINE NUTS

 VISION
2050
MONGOLIA

 EDB Business
Friendly
Mongolia

ECONOMIC DEVELOPMENT BOARD

Media partner

 LEMON PRESS

 TikTok

 МОНГОЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН
СЭТГҮҮЛЧДИЙН КЛУБ







Logistic Partner







МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ФОРУМ 2025 “МАРГААШИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА”

БИДНИЙ ТУХАЙ

Монголын Эдийн Засгийн Форум нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн өмнө тулгамдаж буй асуудал ба түүний гарц шийдлийн талаар хэлэлцэх үндэсний тэргүүлэх хурал бөгөөд улсын хөгжлийг хурдасгах эрхэм зорилготой билээ.

Монголын Эдийн Засгийн Форум төрийн бус, ашгийн бус, хараат бус байгууллага нь 2010 оноос эхлэн Засгийн Газар, хувийн хэвшил, иргэний нийгэм, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллагуудын төлөөллийг нэгэн дээвэр дор нэгтгэн цуглуулж, нээлттэй, өргөн оролцоотойгоор нэгдсэн ойлголтод хүрэх хэлэлцүүлгийг жил бүр хоёр өдрийн турш өрнүүлдэг уламжлалтай.

Энэ жилийн арга хэмжээ 7 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо Төрийн ордонд болох бөгөөд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн нөөц боломж, гарц шийдлийг тодорхойлж, Засаглал ба биенесийн орчин, Дэд бүтэц ба хөрөнгө оруулалт, Шинэ эдийн засаг, Уул уурхай ба стратегийн нөөц тэргүүтэй сэдвүүдийг хэлэлцэлнэ.

MONGOLIA ECONOMIC FORUM 2025 WELCOME TO MONGOLIA

ABOUT US

The Mongolia Economic Forum (MEF) is the country's premier national platform for discussing pressing economic and social challenges and identifying practical solutions to accelerate Mongolia's development. Established in 2010, MEF is a non-governmental, non-profit, and independent organization that annually brings together representatives from the government, private sector, civil society, academia, and international institutions under one roof. Over two days, the forum facilitates open, inclusive dialogue aimed at building a shared understanding of key issues.

This year's forum will take place on July 8-9 at the Government Palace in Ulaanbaatar, focusing on Mongolia's regional development potential and solutions. Discussions will center on critical topics such as governance and business environment, infrastructure and investment, the new economy, and mining and strategic resources.

*Together
for tomorrow*



МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ФОРУМЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА ЧУЛУУНЫ ГАНХУЯГИЙН ИЛГЭЭСЭН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид өө!

Юуны өмнө бидний урилгыг хүлээн авч, хүрэлцэн ирсэн бүх хүндэт оролцогчиддоо талархал илэрхийлье.

Энэ удаагийн Монголын Эдийн Засгийн Форум нь "Маргаашийн Төлөө Хамтдаа" уриан дор шинэ Засгийн газар байгуулагдсан энэ цагт зохион байгуулагдаж байгаагаараа онцлог юм. Монгол Улс эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиг баримжаагаа дотооддоо болон олон улсад зарлаж, цаашдын хөгжлийг хурдасгах талаар санал, бодлоо танилцуулан хэлэлцүүлэх анхны томоохон олон талын оролцоог хангасан арга хэмжээ болж байна.

Форумын зорилго нь төр засгийн төлөөлөл олон улсын зочид төлөөлөгчид, хувийн хэвшил, эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллага, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид өөр хоорондоо бодлогын хэлэлцүүлэг өрнүүлж, санаа бодлоо уралдуулан хөгжлийн гарц, шийдэл гаргах боломжийг олгох энэ үед шинэ Засгийн газар төсвийн тодотгол, ирээдүйн төлөвлөгөөгөө хэлэлцсэн үе тохиож байна.

2025 оны Монголын Эдийн Засгийн Форум нь ирэх он жилүүдэд биеллээ олох хөгжлийн бодлогыг эрэмбэлж, улс орны тогтвортой хөгжлийг бодитой харж, шийдэлтэй бүтээлч хэлэлцүүлгүүд өрнүүлнэ. Форум нь хөрөнгө оруулагчдад танилцах, итгэлцэх, харилцан ашигтай хамтын ажиллагаа хөгжүүлэх, бизнесийн өргөн боломжийг олгох болно. Хамгийн гол нь Монгол Улс бол ардчилсан улс - сонгуулийн үр дүн яаж ч гарч ирсэн бодлогын үргэлжлэл, төрийн залгамж халаа тогтвортой байдгийг сүүлийн 34 жил бид нотолж чадсан гэдгээ тод томруунаар зарлах сайхан боломжийг олгож байна.

Хүнийхээ хөгжлийг дээдэлсэн Монголыг хамтдаа бүтээх Монголын Эдийн Засгийн Форум 2024 "Go Mongolia" уриан дор өрнөж өнгөрсөн хугацаанд Монгол Улсын нэгдсэн дүр төрх, онцлог,

*Together
for tomorrow*

мөн чанарыг олон улсад амжилттай сурталчилж чадсан бол энэ удаад "Маргаашийн Төлөө Хамтдаа" уриан дор бид үргэлж нээлттэй, хүчтэй, нэгдмэл үндэстэн хэвээр байх болно гэдгээ зарлаж байгаагаа онцгойлж байна. Бид бизнес, эдийн засгаа ардчилсан зарчмаар цааш хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Өнөөдрийн олон улсын ээдрээтэй, амаргүй нөхцөл байдалд Монгол Улс гадаад харилцаа, худалдаа, эдийн засгийн зөв бодлогоо тодорхойлж, түүнийгээ амжилттай хэрэгжүүлэх нь амин чухал асуудал болоод байна. Инфляцаа хазаарлаж, эдийн засгийн өсөлтийг хангасан, төрийн үр ашгийг дээшлүүлсэн, хувийн хэвшлээ дэмжсэн, гадаадын хөрөнгө оруулагчдыг олноор нь татах бодлого бидэнд шаардлагатай байгаа.

Энэ цаг үед Монголын эдийн засаг өсөлтөө хадгалж, хүнийхээ хөгжлийг гол цөмөө болгосон тогтвортой хөгжил болгон хувиргах нь нэн тэргүүний үйл хэрэг мөн билээ. Улс орны эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал өмнөх жилийнхтэй адил дүр зурагтай харагдаж байгаа хэдий ч гадаад хүчин зүйл буюу дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн тогтворгүй, савалгаатай байдал, дэлхийн өнцөг булан бүрд гарч буй зэвсэгт мөргөлдөөн, дайны нөхцөл байдал, уур амьсгалын хурдацтай өөрчлөлт, түүнийг дагасан олон эрсдлийг зөв даван туулж, хүн төрөлхтний бүтээж буй технологийн шилжилт, хиймэл оюун ухааны хөгжлийг бид маш соргогоор мэдэрч, боломжийг шүүрч авахыг цаг үе биднээс шаардаж байна.

Энэ удаагийн зуны форумын үндсэн хөтөлбөрөөс гадна MEF Youth буюу Залуусын Чуулган, Элчин сайд нарын дугуй ширээний хэлэлцүүлэг, COP17, J.P. Morgan Манлайлагчдын дугуй ширээд дагалдаж байгаагаараа онцлогтой.

Энэхүү арга хэмжээг зохион байгуулахад дэмжин ажилласан Засгийн газарт, үргэлжлүүлэн дэмжин ажиллаж байгаа хувийн хэвшил, мэргэжлийн холбоодын нөхөддөө дахин дахин талархал илэрхийлье. Хамтдаа үр дүнтэй шийдэл олох, өөрийн туршлага, мэдлэг, үзэл бодлоо харамгүй хуваалцахаар цугларсан бүх зочиддоо гүн талархал илэрхийлье.

Та бүхний оролцоо Монголын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах болно.

Форумын дараа хүндэт зочид Та бүхэн маань Монгол Наадамдаа өргөнөөр оролцож, Монгол түмний өв соёл, ёс заншил, нүүдэлчин ахуй, түүх дурсгалтай танилцахыг хүсье. Манай сайхан улсад зочилсон энэ цаг мөчийг бид хамгийн сайхан хамтын дурсамжаар дүүргэхийг хичээн ажиллах болно.

Монгол Улсаа хамтдаа хөгжүүлэхийн төлөө зөвхөн урагшаа тууштай хамтран алхъя. Зүтгүүлье. Азийн Чоно айсуй.

Ингээд Монголын Эдийн Засгийн Форумыг нээхийг Монгол Улсын Ерөнхий Сайд, Монголын Эдийн Засгийн Форумыг санаачлагчдын нэг Гомбожавын Занданшатарас хүсье!

Сайхан Наадаарай.

Чулууны ГАНХУЯГ Монголын Эдийн Засгийн Форумын УЗ-ийн дарга

*Together
for tomorrow*



WELCOME MESSAGE FROM GANHUYAG CHULUUN HUTAGT, CHAIRMAN OF THE MONGOLIA ECONOMIC FORUM

Distinguished guests and participants,

First and foremost, I would like to extend my sincere gratitude to all our esteemed participants for accepting our invitation and being here today.

This year's Mongolia Economic Forum, under the theme "Together for Tomorrow", is unique in that it is being held at a time when a new Government has just been formed. It serves as the first major public event where it can announce its economic and social development policy directions both domestically and internationally, while presenting ideas and proposals to accelerate future growth.

The purpose of the Forum is to provide a platform for government representatives, international guests, the private sector, researchers, civil society, and both domestic and foreign investors to engage in policy dialogue, exchange ideas, and identify solutions and pathways for development. This Forum takes place at a time when the new Government is discussing its budget amendments and future plans.

The Mongolia Economic Forum 2024, held under the theme "GO MONGOLIA," successfully promoted Mongolia's unified image, unique identity, and essence to the world. This year, with the theme "Together for Tomorrow" we highlight that Mongolia remains an open, strong, and united nation. We aspire to advance our business and economy on the basis of good governance and strong democratic principles.

In today's complex and challenging global environment, it is vital for Mongolia to define and suc-

*Together
for tomorrow*

cessfully implement sound foreign, trade, and economic policies. We need policies that curb inflation, ensure economic growth, enhance government efficiency, support the private sector, and attract foreign investors. We need policies that curb inflation, ensure economic growth, improve government efficiency, support the private sector, and attract large numbers of foreign investors.

At this time, it is imperative for Mongolia to sustain economic growth with human development at its center. Although the current state of the economy appears similar to last year, external factors such as global economic volatility, armed conflicts and wars, and rapid climate change with its accompanying risks demand that we navigate wisely. We must also be keenly aware of — and seize — the opportunities brought about by rapid technological shifts and the development of artificial intelligence. In addition to this year's forum program, it is distinguished by side events such as the MEF Youth Forum, the Ambassadors' Roundtable, COP17, and the J.P. Morgan Leadership Roundtable.

I would like to once again express my deep appreciation to successive Governments that have supported the organization of this event, as well as to the private sector and professional associations that continue to stand by us. I am also profoundly grateful to all our guests who have gathered here to generously share their experiences, knowledge, and perspectives, and to work together to find effective solutions.

Your participation will make a valuable contribution to Mongolia's development.

After the Forum, I warmly invite all our distinguished guests to actively participate in Mongolia's unique Naadam Festival to experience our rich heritage, traditions, nomadic way of life, and historical monuments. We will strive to ensure that your time in our beautiful country leaves you filled with the best shared memories.

Let us move forward together with unwavering determination to develop Mongolia. The Wolf of Asia is rising.

Now, I invite the Prime Minister of Mongolia, one of the initiators of the Mongolia Economic Forum, Zandanshatar Gombojav, to officially open the Forum.

Enjoy the Naadam Festival.

Ganhuyag Chuluun Hutagt
Chairman
Mongolia Economic Forum

*Together
for tomorrow*

МЭНДЧИЛГЭЭ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР

Мөнх хөх тэнгэрийн орон манай сайхан улсад морилон саатаж, бидний санаачлан зохион байгуулж буй "Монголын Эдийн Засгийн Форум-2025"-д дэлхийн өнцөг булан бүрээс хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт зочид төлөөлөгчид, бодлого боловсруулагчид, хөрөнгө оруулагчид, бизнес эрхлэгчид, баялаг бүтээгчид Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Энэ удаагийн Форум нь "Маргаашийн төлөө хамтдаа" уриа дор зохион байгуулагдаж байгаа бөгөөд харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бизнесийн таатай орчныг бий болгох чиглэсэн олон бодлого, санал санаачилга гаргах зорилготой билээ.

Геополитикийн нэн эгзэгтэй цаг үед дэлхийн улс орнууд эдийн засгийн тогтвортой байдлаа хадгалах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүс нутаг болон олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийг урьд урьдаас анхаарч байна.

Монгол Улс ч харилцан ашигтай хөрөнгө оруулалтыг бүх талаар дэмжих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнесийн орчныг сайжруулахад онцгой анхаарч байна.

Манай улсын эдийн засаг сүүлийн 4 жилд дунджаар 5 хувиар өсөж, эдийн засгийн тогтвортой байдал хадгалагдаж, гадаад валютын нөөц болон өрийн тогтвортой байдлыг чанд мөрдөж, Монгол Улсын зээлжих зэрэглэл сүүлийн 10 жилийн хамгийн сайн үзүүлэлттэй байна.

Мөнх хөх тэнгэрийн орон Монгол Улс нь өргөн уудам газар нутагтай, үзэсгэлэнт байгальтай, асар их байгалийн баялагтай, өсөн үржиж, урган төлждөг мал аж ахуй, газар тариалангийн арвин баялагтай, дэлхийд өрсөлдөх чадвартай залуу үе, азийн ардчиллын баянбүрд болсон улс орон гэдгийг Та бүхэн мэднэ. Монгол Улсын хамгийн том баялаг бол эрч хүчтэй, мөрөөдөлтэй шинэ залуу үе юм. Тэд бол бидний ирээдүй, Монгол Улсын хөгжлийн түлхүүр юм.

*Together
for tomorrow*

Тиймээс арвин их нөөц боломж, эрүүл саруул монгол хүн, ардчилсан засаглалдаа тулгуурлан Хүчирхэг Монгол Улс дахин цогцлоон хөгжүүлэх болно.

Энэ хүрээнд хөрөнгө оруулагчдад ээлтэй, харилцан ашигтай, ил тод, найдвартай, хариуцлагатай бизнесийн орчныг цогцлоох нь Монгол Улсын Засгийн газрын эн тэргүүний зорилт юм.

Энэ хүрээнд Засгийн газраас эдийн засгийн бааз сууриа тэлэх мега төслүүдийг хэрэгжүүлж, хөрөнгө оруулагчид, баялаг бүтээгчдээ дэмжих, тэдний эрх ашгийг нь хамгаалах, татвар, нийгмийн даатгал болон бусад бизнесийн орчны бүтцийн цогц шинэчлэлийг эрчимжүүлж байна.

Монгол Улс нь “энхийг эрхэмлэсэн, нээлттэй, олон тулгуурт” гадаад бодлогыг тууштай баримталж, сайн хөрш, найдвартай түнш, итгэл даах хамтрагч гэдгээ улам баталгаажуулж байна.

Монгол улс ардчилсан засаглалаа улам төгөлдөршүүлж, төрийн бодлогын тогтвортой байдлыг хангах нь монголчууд бидний үнэт зүйл юм.

Энэ удаагийн “Монголын Эдийн Засгийн Форум-2025” нь эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалтын шинэ боломжийг нээж, харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Мөнх хөх тэнгэрийн орон манай сайхан улсад хүрэлцэн ирсэн эрхэм хүндэт Та бүхэнд эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Форумын үйл ажиллагаанд амжилт хүсье!

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР**

*Together
for tomorrow*

WELCOME MESSAGE FROM GOMBOJAV ZANDANSHATAR, THE PRIME MINISTER OF MONGOLIA

Welcome message from Zandanshatar Gombojav, the Prime Minister of Mongolia
Welcome to Mongolia, the country of the eternal blue sky!

I sincerely thank all the distinguished guests, government leaders, investors, entrepreneurs, and wealth creators from around the world who have gathered here in our beautiful country for the “Mongolian Economic Forum 2025.”

This forum is held under the theme “Together for Tomorrow”, with the goal of developing new policies and ideas to enhance cooperation, attract more investment, and improve the business environment across Mongolia.

In today’s complex global landscape, countries worldwide are focused on maintaining economic stability, encouraging investment, and strengthening regional and international partnerships. Mongolia shares this commitment—valuing mutual investment, protecting the interests of investors, and making it easier to do business.

Over the past four years, our economy has grown by an average of 5 percent. We have maintained stability, carefully managed our foreign exchange reserves and debt, and Mongolia’s credit rating has been the best it’s been in the last decade.

As you know, Mongolia is a vast country blessed with beautiful landscapes, abundant natural resources, thriving livestock, and a growing agricultural sector. We have a young, competitive generation, and Mongolia is recognized as a model of democracy in Asia.

*Together
for tomorrow*

Our greatest treasure is our energetic and ambitious youth. They are the future—and the driving force—of Mongolia’s development.

Therefore, a modernization of Mongolia will be built and developed upon its rich resources, healthy and vibrant people, and steadfast commitment to democratic governance.

In this context, the Government of Mongolia’s highest priority is to cultivate an investor-friendly environment—one that is transparent, trustworthy, mutually beneficial, and accountable.

The government is working on major projects to strengthen our economy, support investors and entrepreneurs, protect their interests, and improve our tax and social systems.

Mongolia remains committed to a peaceful, open foreign policy. We aim to be a good neighbor, a reliable partner, and a trusted friend to countries in the world.

We also continue to improve our democratic governance and uphold stable policies—values that are at the core of what it means to be Mongolian.

I believe that this forum will open new opportunities for our economy, trade, and investment, and will foster mutually beneficial partnerships between Mongolia and the world.

To all our guests visiting our beautiful land—the land of the eternal blue sky—I wish you good health, happiness, and prosperity.

May the forum be productive and inspiring!

ZANDANSHATAR GOMBOJAV
PRIME MINISTER OF MONGOLIA

*Together
for tomorrow*



ӨДӨР 1

DAY 1

Нэгдсэн хуралдаан 1

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ИТГЭЛИЙГ ДААХ НЬ

Сэдвийг онцлохын ач холбогдол

Дэлхийн эдийн засагт томоохон өөрчлөлт, тодорхой бус байдал давамгайлж байгаа энэ үед хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээх нь улс орнуудын хувьд маш чухал болж байна. Геополитикийн хурцадмал байдал, худалдааны тогтолцооны өөрчлөлт, макро эдийн засгийн бодлогын дахин тохируулгаас үүдэж дэлхий даяар эдийн засгийн бодлогын тодорхойгүй байдал 2025 оны эхээр өндөр хэвээр байна. Ийм үед хөрөнгө оруулагчид бодлогын тогтвортой байдал, институцийн зарчимтай байдал, төрийн зохицуулалтын урьдчилан таамаглах боломж зэрэг хүчин зүйлсэд илүү ач холбогдол өгч өөрсдийн хөрөнгийн хуваарилалтын стратегиа тодорхойлж байна.

Энэхүү өөрчлөгдөж буй хөрөнгө оруулалтын орчин нь хөгжиж буй орнуудад сорилт болоод боломжийг авчирч байна. Монгол Улсын хувьд өөрийн давуу талыг итгэл даахуйц, дүрэм журам бүхий, ирээдүй рүү чиглэсэн хөрөнгө оруулалтын орчинтой улс гэдгээ тодорхой илэрхийлэх нь илүү чухал болж байна. Ашигтай хөрөнгө хуваарилалт хийхэд болгоомжтой хандлага давамгайлж, нягт няхуур шинжилгээ, шалгуур улам бүр чухал болж буй орчинд тогтвортой байдал, ил тод байдал, урт хугацааны хамтын ажиллагааг санал болгож чадах улс орнууд дэлхийн эдийн засгийн орон зайгаа бэхжүүлж байна.

Монгол Улс хариуцлагатай, тогтвортой, харилцан ашигтай үр дүнд суурилсан хөрөнгө оруулагчидтай урт хугацааны түншлэлийг бэхжүүлэхийг зорьж байна. Шинэ хөрөнгө оруулалт татах, шаардлагатай нөхцөлд хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, одоогийн хөрөнгө оруулагчдын оролцоог хадгалах нь үүний салшгүй нэг хэсэг юм. Одоо хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд бодлогын урьдчилан таамаглах боломжийг сайжруулах, институцийн чадавхыг бэхжүүлэх, тууштай, ил тод хэрэгжилтээр хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Эдгээр зорилтуудыг Засгийн газрын бүх шатны байгууллагын харилцан уялдаанд тулгуурласан, оролцогч талуудтай тогтвортой харилцааг хангах "нэг цонхны бодлого"-ын хүрээнд хэрэгжүүлж байна. Монгол Улсын туршлага нь бодлогын уялдаа, институцийн итгэлцэл, салбар хоорондын хамтын ажиллагаа зэрэг нь дэлхийн эдийн засгийн мөчлөгөөс үл хамааран тогтвортой хөрөнгө оруулалтын орчныг бүрдүүлэхэд онцгой ач холбогдолтойг харуулж байна.

Хэлэлцүүлгийн зорилго

Дэлхийн эдийн засгийн хуваагдал, капиталын урсгалын өөрчлөлт, геополитикийн нөхцөл байдал улам бүр төвөгтэй болж буй өнөөгийн нөхцөлд энэхүү хэлэлцүүлэг нь Монгол Улсын Засгийн газрыг олон улсын эдийн засгийн тогтвортой, ил тод, ирээдүйд чиглэсэн түнш орон гэдгийг таниулах зорилготой.

Энэхүү хэлэлцүүлгийн үндсэн зорилго нь бодлогын урьдчилан таамаглах боломж, эрх зүйн тодорхой байдал, институцийн чадавхыг бэхжүүлэхэд чиглэсэн Монгол Улсын Ерөнхий сайдын түүштай байр суурийг олон нийтэд хүргэх явдал төдийгүй дэлхийн өнөөгийн нөхцөл байдалд хөрөнгө оруулагчдын итгэлийг бэхжүүлэхэд хамгийн чухал хүчин зүйлсийн нэг юм.

Монгол Улсын Ерөнхий сайд нь өнгөрсөн он жилүүдэд бий болсон эдийн засгийн тогтворгүй байдал болон хөрөнгө оруулагчдын болгоомжлол зэргээс авсан сургамжийг эргэн харахын сацуу эдгээр түршлага нь Засгийн газар бүхэлдээ эдийн засгийн засаглал, хөрөнгө оруулалтыг дэмжих бодлогод чиглэсэн, илүү харилцан уялдаатай байсан талаар өгүүлэх болно.

"Ирээдүйн төлөө хамтдаа" уриатайгаар зохион байгуулагдаж буй Монголын эдийн засгийн форум 2025-ын үндсэн сэдвийн хүрээнд явагдах энэхүү хэлэлцүүлэг нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын стратеги нь зөвхөн хөрөнгө татахад чиглэгдээгүй, харин урт хугацааны бөгөөд харилцан итгэлцэлд суурилсан түншлэлийг төлөвшүүлэхэд төвлөрч байгааг онцлон харуулна. Дэлхийн хөрөнгийн зах зээл дэх хандлагын өөрчлөлт болон хөрөнгө оруулагчдын хүлээлтийн хүрээнд Монгол Улсын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлон авч үзэх энэхүү хэлэлцүүлэг нь манай улсыг найдвартай, хамтын ажиллагаанд суурилсан, ирээдүйг харсан хөгжлийн бодлого бүхий оролцогч улс хэмээн танилцуулах зорилготой юм

Хүлээгдэж буй үр дүн

"Fireside Chat" буюу ил тод, нээлтэй хэлэлцүүлэг нь Монгол Улс тогтвортой, ил тод, урьдчилан таамаглах боломжтой бодлогын орчинг бүрдүүлэхэд түүштай хүчин чармайлт гаргаж буйг дахин нотолж, урт хугацааны хөрөнгө оруулалтын түншлэлийн суурийг бэхжүүлэх зорилготой. Ерөнхий сайд энэхүү хэлэлцүүлгийн хүрээнд эдийн засгийн засаглал, институцийн шинэчлэл, хөрөнгө оруулагчидтай харилцах харилцааны чиглэлээр Засгийн газрын тэргүүлэх зорилтуудыг илэн далангүй, ирээдүйг харсан байдлаар хуваалцах болно.

Энэ хэлэлцүүлэг нь олон улсад Монгол Улс бодлогын уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн тодорхой байдлыг бэхжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр бодит алхмууд хийж байгааг тодорхой мессежээр илэрхийлэх зорилготой. Ингэснээр гадаадын шууд хөрөнгө оруулалтыг зөвхөн санхүүгийн эх үүсвэр төдийгөөр бус харин харилцан итгэлцэл, урт хугацааны нийцэл, тогтвортой хөгжлийн зорилтод суурилсан хамтын хүчин чармайлтын хэлбэр гэж харуулахыг зорьж байна.

Эцэст нь уг хэлэлцүүлэг нь Монгол Улсыг дэлхийн эдийн засгийн сорилтод хариу өгч чадахуйц, хариуцлагатай, найдвартай, урт хугацаанд чиглэсэн түнш хэмээх байр суурийг бататгах зорилготой бөгөөд хөрөнгө оруулагчидтай хамтран илүү уян хатан, тэгш хүртээмжтэй, ирээдүйд чиглэсэн эдийн засгийг хөгжүүлэхийг зорьж буйг илтгэнэ.

Together
for tomorrow

Planery 1:

SECURING INVESTOR CONFIDENCE IN MONGOLIA

Importance of the topic

In a global economy defined by structural shifts and heightened uncertainty, securing investor confidence is both timely and essential. As of early 2025, global indicators of economic policy uncertainty remain elevated, reflecting a convergence of geopolitical tensions, evolving trade frameworks, and macroeconomic recalibrations. These dynamics are prompting investors to re-evaluate capital allocation strategies, with a growing focus on policy stability, institutional integrity, and regulatory predictability.

This shifting investment landscape presents both challenges and openings for emerging economies. For Mongolia, it underscores the importance of clearly articulating its value proposition as a reliable, rules-based, and forward-oriented investment destination. In an environment marked by cautious capital and heightened due diligence, countries that can provide consistency, transparency, and long-term engagement stand to strengthen their global economic position.

Mongolia is committed to fostering enduring partnerships with investors who prioritize responsible, sustainable, and mutually beneficial outcomes. Attracting new capital, rebuilding trust where needed, and maintaining existing investors are all integral to this approach. Current efforts focus on enhancing policy predictability, strengthening institutional capacity, and reinforcing confidence through consistent and transparent implementation.

These priorities are being pursued through a whole-of-government approach, ensuring alignment across agencies and sustained engagement with stakeholders. Mongolia's experience underscores the importance of coordinated policymaking, institutional credibility, and cross-sector collaboration in creating an investment environment that endures across global economic cycles.

Purpose of discussion

Against the backdrop of global economic fragmentation, shifting capital flows, and rising geopolitical complexity, the session will position the Government of Mongolia as a stable, transparent, and forward-leaning partner in the international economy.

A core objective is to communicate the Prime Minister's commitment to policy predictability, legal clarity, and institutional strengthening, factors that are central to investor confidence in today's global landscape.

The Prime Minister will reflect on lessons learned from past periods of volatility and investor hesitation, while outlining how these experiences have informed a more coordinated, whole-of-government approach to economic governance and investment facilitation. Anchored in the overarching theme of the Mongolia Economic Forum 2025, "Together for Tomorrow," the discussion will highlight that the

Together
for tomorrow

country's investment strategy is not limited to capital inflows, but focused on cultivating long-term, trust-based partnerships.

By framing Mongolia's trajectory within the broader shifts in global capital markets and investor expectations, the session aims to present Mongolia as a credible, cooperative, and future-oriented actor committed to shared prosperity.

Expected outcome from the discussion

The Fireside Chat is expected to reinforce Mongolia's commitment to providing a stable, transparent, and predictable policy environment, an essential foundation for long-term investment partnerships. Through a candid and forward-looking discussion, the Prime Minister will convey the government's priorities in economic governance, institutional reform, and investor engagement.

The session aims to send a clear signal to the international community that Mongolia is taking tangible steps to enhance policy coherence, strengthen legal certainty, and promote cross-sector collaboration. In doing so, it will position foreign direct investment not merely as a financial inflow but as a shared endeavor grounded in mutual trust, long-term alignment, and sustainable development objectives.

Ultimately, the dialogue aims to support the repositioning of Mongolia as a responsible, credible, and forward-looking partner in a complex global environment, committed to collaborating with investors to build a more resilient, inclusive, and future-ready economy.



МОДЕРАТОР

**МАИК
ВАЛЕРИО**

Олон улсын сурвалжлагч,
CNN

Маик Валерио нь найман удаагийн Эмми шагналт, CNN-ийн Сөүл хотод байрлах олон улсын төвийн сурвалжлагч юм. Солонгосын хойг болон Ази, Номхон далайн бүсийн улс төр, соёл, нийгмийн томоохон үйл явдлыг сурвалжилдаг тэрээр Өмнөд Солонгосын 2024 оны цэргийн дэглэмийн хямрал, Jeju Air-ийн осол, ОХУ-ын Хойд Солонгостой хийсэн дээд хэмжээний уулзалтууд зэрэг онцлох чухал үйл явдлыг олон нийтийн хүртээл болгосон юм.

CNN-д ажиллахаасаа өмнө тэрээр Вашингтон хот дахь WUSA9 телевизэд улс төр, хууль сахиулах байгууллагын чиглэлээр сурвалжлагч, Цагаан ордон, Хууль зүйн яам, Тагнуулын Ерөнхий Газар, сонгуулийн аюулгүй байдлын талаар мэдээ мэдээллийг амжилттай сурвалжилж байсан. Түүний сурвалжилгууд нь Дэлхийн II дайны Америк цэргүүдийн Таравад орхигдсон түүхийг өгүүлсэн баримтат кино болох "Fallen and Forgotten"-д хүргэсэн.

Тэрээр Жорж Вашингтоны Их Сургуулийг сэтгүүл зүй, олон нийтийн харилцаагаар бакалавр зэрэгтэй.



MODERATOR

**MIKE
VALERIO**

International Correspondent,
CNN

Mike Valerio is an eight-time Emmy Award-winning journalist and CNN international correspondent based in Seoul. Covering the Korean Peninsula and Asia Pacific, Mike reports on major political, cultural, and social stories shaping the region. He led CNN's coverage of South Korea's 2024 martial law crisis, the Jeju Air crash, and Russia's summit with North Korea.

Before CNN, Mike was a political and law enforcement reporter at WUSA9 in Washington, DC, extensively covering the White House, DOJ, FBI, and election security. His investigative work produced the multi-year documentary series "Fallen and Forgotten," on WWII U.S. servicemen still buried in Tarawa.

He holds a bachelor's degree in Journalism & Mass Communication from The George Washington University.



ПАНЕЛИСТ

**ГОМБОЖАВЫН
ЗАНДАНШАТАР**

Монгол Улсын Ерөнхий сайд,
Хамтран даргалагч, Монголын
Эдийн Засгийн Форум-2025

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нь төр, санхүү, гадаад харилцаа, институцын шинэчлэлийн чиглэлээр 30 гаруй жил ажилласан, ардчиллын шинэчлэл, олон нийтийн оролцоог дэмжигч туршлагатай улс төрч юм.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар 1987-1992 онд ОХУ-ын Байгалийн Эдийн Засаг, Эрх Зүйн Улсын Сургуулийг Санхүү-ээлийн эдийн засагч мэргэжлээр төгссөн бөгөөд Эдийн засгийн ухааны магистр зэрэгтэй. 2013-2015 онд АНУ-ын Стэнфордын их сургуулийн Хөгжил, ардчилал, хуулийн засаглалын хүрээлэнд зочин судлаачаар ажилласан бөгөөд энэ хугацаанд олж авсан мэдлэг туршлага нь Монгол Улсад зөвлөлдөх ардчиллыг хөгжүүлэх, иргэдийн оролцоог сайжруулах шинэтгэлийн үндэс болсон.

Тэрбээр 1992-1995 онд Худалдаа, үйлдвэрлэлийн дээд сургуулийн багш, 1995-1998 онд Монголын Хөдөө аж ахуйн банканд Эдийн засагч, Зээл, мөнгөний бодлогын газрын захирал, Бүтцийн өөрчлөлтийн менежер, 1998-2000 онд Монголбанкны бүрэн эрхт төлөөлөгч, Эрх хүлээн авагчийн багийн гишүүн, 2000-2003 онд "Хаан" банкны дэд захирал, 2003-2004 онд Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд зэрэг банк санхүү болон төрийн байгууллагуудад ажиллаж байв.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нь 2005-2010 онд Монгол Ардын Намын дэргэдэх Монголын Ардчилсан Социалист Залуучуудын Холбоо (МАСЗХ)-ны Удирдах зөвлөлийн гишүүн, дэд Ерөнхийлөгч, Ерөнхийлөгчөөр ажиллаж байхдаа тус байгууллагын үзэл баримтлал, бүтэц, зорилго, үйл ажиллагаанд эрс шинэчлэлийг хийсэн юм. Эдүгээ "Нийгмийн Ардчилал – Монголын Залуучуудын Холбоо" (НАМЗХ) улс орон даяар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Тэрбээр 2004-2012, 2016-2024 онд Улсын Их Хурлын гишүүнээр дөрвөн удаа сонгогдож, 2009-2012 онд Гадаад харилцааны сайд, 2012-2013 онд МАН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, 2017-2019 онд Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, 2019-2020, 2020-2024 онд Улсын Их Хурлын даргаар сонгогдсон. Улмаар 2024-2025 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллаж, 2025 оноос 6 дугаар сарын 13-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдаар томилогдон ажиллаж байна.

Монголын Эдийн Засгийн Форумын хамтран үүсгэн байгуулсан Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нь 1994-2025 онд төр, эдийн засаг, ардчиллын сэдвээр 15 гаруй ном, орчуулгын бүтээлийг туурвисан бөгөөд ардчиллын оролцоог өргөжүүлэх, хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээрх манлайлагч юм.



PANELIST

ZANDANSHATAR GOMBOJAV

Prime Minister of Mongolia,
Co-Chairman, Mongolia Economic
Forum-2025

H.E. Zandanshatar Gombojav, the Prime Minister of Mongolia, founding member of Mongolia Economic Forum has built a distinguished career in public service, finance, and democratic governance spanning over three decades. He holds a BSc in Finance and Credit Economics from the State University of Natural Resources and Law, and a Master's Degree in Economics. He was also a Visiting Scholar at Stanford University's Center on Democracy, Development, and the Rule of Law (2013–2015), where he deepened his engagement with deliberative democracy and institutional innovation.

H.E. Zandanshatar Gombojav began his professional journey as a lecturer at the Institute of Trade and Industry (1992–1995) before transitioning to the banking sector, where he held various senior roles at the Agricultural Bank of Mongolia and the Central Bank of Mongolia (1995–2000). He later served as Deputy Director of Khan Bank (2000–2003) and as Deputy Minister of Food and Agriculture of Mongolia (2003–2004).

From 2005 to 2010, H.E. Zandanshatar Gombojav led the Democratic Socialist Youth Union of Mongolia under the Mongolian People's Party (MPP), serving as its Vice President and President. This period laid the foundations for the expansion and development of Mongolia's youth engagement in politics and democratic development.

He has been elected four times to the State Great Hural (Parliament) of Mongolia in 2004, 2008, 2016, and 2020, and has held several key national leadership roles, including Minister of Foreign Affairs (2009–2012), Secretary General of the MPP (2012–2013), and Minister and Chief Cabinet Secretary of the Government of Mongolia (2017–2019). He served two-terms as Chairman of the State Great Hural (Parliament) of Mongolia (2019–2020; 2020–2024), during which he was instrumental in institutional reforms, increasing transparency, public engagement, strengthening parliamentary and governmental check and balance and the constitutional amendments. Prior to his current appointment as the Prime Minister of Mongolia on 13 June, 2025, he served as Chief of Staff to the President of Mongolia (2024–2025).

He is an author and translator, having published and translated over 15 books on governance, economics, and democratic development between 1994 and 2025. He continues to advocate for transparent, inclusive, and participatory governance in Mongolia and globally.

*Together
for tomorrow*

Салбар хуралдаан 1:

БИЗНЕСТ ЭЭЛТЭЙ МОНГОЛ

Сэдвийг онцлохын ач холбогдол

Монгол Улсын Засгийн газраас E-Government зэрэг цахим засаглалын санаачилгуудыг өрнүүлж бизнесийг бүртгэх, зөвшөөрөл олгох зэрэг ажлуудыг хялбарчилж эхэлсэн бол хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх, авлигыг бууруулах чиглэлээр эрх зүйн цогц шинэчлэлийг өрнүүлж байна. Гэвч урьдчилан таамаглахад бэрх хууль, эрх зүйн зохицуулалтын өөрчлөлтүүд, лиценз, зөвшөөрөл авахад тулгардаг удаан, төвөгтэй процесс, арбитрын шүүхийн маргаан шийдвэрлэх болон гэрээ хэрэгжүүлэх явцын тодорхойгүй байдал зэрэг бэрхшээлүүд байсаар байна. Эдгээр сорилтыг олон талаас нэгтгэн дүгнэх, бизнесийн орчныг сайжруулах, бизнес эхлүүлэхэд тулгарч буй шат дамжлагыг багасгах, хөрөнгө оруулалт, эдийн засгийн төрөлжилт, инновацыг дэмжих оновчтой бодлогыг тодорхойлох шаардлагатай байна.

Хэлэлцүүлгийн зорилго

Бизнесийн орчны боломж, сорилтыг ил тод хэлэлцэж, эдийн засгийн төрөлжилт, тогтвортой өсөлтийг дэмжих бодлого, шийдлийг хамтран тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулалтын таатай нөхцлийг сайжруулж, бизнесийн орчны эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлох, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэнэ. Түүнчлэн, засаглал, зохицуулалтын шинэчлэлийн бизнесийн орчинд үзүүлж буй нөлөөг үнэлэх, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулагчдад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх боломжит гарцыг хэлэлцэхэд оршино.

Хүлээгдэж буй үр дүн

Бизнесийн орчны эрсдэл, боломжийг тодорхойлж, салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах бодлого, аргачлалыг оновчтой болгох, хөрөнгө оруулалтын орчны тогтвортой төрөлжсөн, инновацад суурилсан эдийн засгийн хөгжлийг дэмжих санал санаачилга гарна.

*Together
for tomorrow*

Sub-session 1:

BUSINESS FRIENDLY MONGOLIA

Importance of the topic

Countries that have successfully attracted investment typically reduce bureaucratic barriers and implement effective programs to protect investors. Most developed nations stand out for their strong implementation of international agreements and reliable legal frameworks that uphold property rights. In contrast, judicial delays and legal ambiguities undermine investor confidence and limit any country's ability to attract sustainable investment.

Some countries, such as Georgia, have significantly improved their scores in the Ease of Doing Business Index within a short time by undertaking comprehensive reforms in business regulation and judicial efficiency. International experience shows that good governance and accessible, efficient dispute resolution mechanisms form the foundation of a healthy and stable business environment. In Mongolia, digital governance initiatives such as E-Government have begun to streamline procedures for business registration and licensing. At the same time, comprehensive legal reforms are underway to strengthen the rule of law and reduce corruption. Recent changes in tax and social insurance systems, aimed at reducing the burden on enterprises and employees, mark a positive step toward a more business-friendly environment.

However, challenges remain. These include unpredictable legal and regulatory changes, protracted and complex licensing procedures, and uncertainty in arbitration processes and contract enforcement. Addressing these issues through a coordinated and evidence-based approach is essential for shaping effective policies that support investment, economic diversification, and innovation.

Purpose of discussion

The objective is to foster open dialogue on the opportunities and challenges within the business environment, and to collaboratively identify policies and solutions that support economic diversification and sustainable growth. This includes improving conditions for foreign investment, identifying ways to mitigate risks within the business environment, and strengthening public-private sector cooperation. In addition, the discussion will focus on assessing the impact of recent governance and regulatory reforms on the business climate, identifying the key challenges and systemic issues faced by investors currently operating in Mongolia, and exploring practical solutions to address these obstacles.

Expected outcome from the discussion

The aim is to identify both the risks and opportunities within the business environment and to refine policies and approaches that enhance intersectoral coordination and collaboration. These efforts will support the development of a stable investment climate and promote diversified, innovation-driven economic growth through targeted proposals and strategic initiatives.

*Together
for tomorrow*



МОДЕРАТОР

**ПҮРЭВЖАВЫН
ОТГОНТУЯА**

МҮОНТВ-ийн сэтгүүлч

П.Отгонтуяа нь Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизэд 10 гаруй жил сэтгүүлчээр ажилласан туршлагатай. Тэрээр бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй бөгөөд санхүүгийн зах зээл, тогтвортой хөгжил зэрэг чиглэлээр мэргэшсэн.

Нийгэмд тулгамдсан асуудлуудыг хөндөж, бодитой хэлэлцүүлэг өрнүүлэхэд хэвлэл мэдээллийн салбарын чиг үүргийг тодорхойлоход анхааран ажилладаг. Отгонтуяа өдгөө нийгэмд ач холбогдолтой, цаг үеийн сэдвийг хөндсөн ярилцлагын долоо хоног тутмын нэвтрүүлэг хөтлөн явуулж байна.

*Together
for tomorrow*



МОДЕРАТОР

**OTGONTUYA
PUREVJAV**

Journalist, Mongolian
National Broadcaster (MNB)

Otgontuya Purevjav is a journalist with more than 10 years of experience at the Mongolian National Broadcaster. She holds an MBA and specializes in financial markets and sustainable development. Committed to fostering informed public dialogue, she uses her platform to highlight critical issues and encourage thoughtful discussion. Otgontuya currently hosts a weekly interview program that explores socially important and timely topics.



ПАНЕЛИСТ

**НЯМ-ОСОРЫН
УЧРАЛ**

Улсын Их Хурлын гишүүн, Тэргүүн
Шадар сайд бөгөөд Эдийн Засаг
Хөгжлийн сайд,
Хамтран даргалагч, Монголын Эдийн
Засгийн Форум-2025

Их Засаг Их сургууль, Их Британийн Букингхамын Их сургууль, Лимкоквинг технологийн Их сургууль, ОХУ-ын ШУА-ын Сибирийн салбарын Монгол, Түвд, Будда судлалын институтыг тус тус төгссөн. Доктор (Ph.D)



PANELIST

UCHRAL NYAM-OSOR

Deputy Prime Minister and Minister of Economy and Development, Member of the State Great Hural (Parliament) of Mongolia, Co-Chairman, Mongolia Economic Forum-2025

Uchral Nyam-Osor serves as Deputy Prime Minister and Minister of Economy and Development of Mongolia. He is also a Member of the State Great Hural (Parliament). Uchral holds degrees from Ikh Zasag University, the University of Buckingham and Limkokwing University of Creative Technology in the United Kingdom, as well as from the Institute of Mongolian, Tibetan and Buddhist Studies under the Siberian Branch of the Russian Academy of Sciences. He holds a Ph.D.



ПАНЕЛИСТ

ОДОНГИЙН ЦОГТГЭРЭЛ

Улсын Их Хурлын гишүүн, УИХ дахь АН-ын бүлгийн дарга

1999-2012 онд ТЭСО ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 2012-2015 онд Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, 2015-2019 онд ТЭСО группийн ерөнхийлөгчөөр ажилласан.

2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр хоёр дахь удаагаа сонгогдон ажиллаж байгаа, УИХ дахь Ардчилсан намын бүлгийн дарга.

Физикч-Эдийн засагч мэргэжилтэй.



PANELIST

TSOGTGEREL ODON

Member of Parliament, Leader of the Democratic Party Caucus in the State Great Hural (Parliament) of Mongolia.

Tsogtgerel Odon currently serves as a Member of Parliament and the Leader of the Democratic Party caucus in the State Great Hural. He was re-elected to Parliament in 2020, having previously served as a Member from 2012 to 2016.

From 1999 to 2012, he was the Chief Executive Officer of TESO LLC. Between 2012 and 2015, he served as Senior Advisor to the President of Mongolia. He also held key leadership roles within the TESO Group as a Board Member and later as President from 2012 to 2019.

Tsogtgerel holds a degree in Physics and Economics and is currently a doctoral candidate in Management Studies.



ПАНЕЛИСТ

БАТСУУРИЙН ДАВААДАЛАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын зөвлөх

Б.Даваадалай нь Монгол Улсын Их сургуулийн Эдийн Засгийн сургуулийг Банкны эдийн засгийн мэргэжлээр төгсөж, АНУ-ын Нью Йорк хотын Колумбын Их сургуульд Эдийн засгийн ухааны магистрын зэрэг хамгаалсан. Одоогоор Монгол Улсын Их сургуулийн Бизнесийн сургуулийн докторантур. Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газарт эдийн засагч, АНУ-ын Вашингтон хотод байрлах Дэлхийн банкны төв оффист Зүүн Өмнөд Ази, Номхон далайн бүс нутгийн багт зөвлөх, Дэлхийн банкинд эдийн засагч, Сангийн сайдын зөвлөхөөр тус тус ажилласан туршлагатай.



ПАНЕЛИСТ

BATSUURI DAVAADALAI

Economic Policy Advisor to the President
of Mongolia

Davaadalai Batsuuri earned his Bachelor's Degree in Banking and Finance at the National University of Mongolia (NUM), School of Economics. He earned also his master's degree in Applied Economics from the Columbia University of the New York City, US. Davaadalai Batsuuri is currently a PhD candidate at the NUM. He has served as an Economist at the Monetary Policy Department of the Central Bank of Mongolia, and as a consultant at the department of East Asia and Pacific Region (EAP) of the World Bank HQ in Washington DC, US. He has also worked as an economist at the World Bank Office in Mongolia, and as an advisor to Minister of Finance of the Government of Mongolia



ПАНЕЛИСТ

ЖОРЖ КЕРН

Гүйцэтгэх захирал, Breitling

Жорж Керн нь Швейцарын тансаг зэрэглэлийн цаг үйлдвэрлэгч Breitling компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж, компанийн дижитал шинэчлэл, тогтвортой хөгжлийн стратегийн бодлогыг удирдан ажиллаж байна. Тэрээр Richemont болон IWC Schaffhausen зэрэг тансаг хэрэглээний брэнд үйлдвэрлэдэг компаниудад 20 гаруй жил удирдах алба хашсан бизнесийн арвин туршлагатай юм.

Жорж Керн Францын Страсбург хотод Улс төр судлал, Швейцарын Сэнт-Галлены Их Сургуульд Бизнесийн удирдлагаар суралцаж, Kraft Foods Switzerland болон TAG Heuer зэрэг байгууллагад ажиллаж байжээ. 2000 онд тэрээр Richemont группт ажиллаж, IWC Schaffhausen, A. Lange & Söhne, Jaeger-LeCoultre зэрэг брэндүүдийг нэгтгэн удирдсан. 2002 онд 36 насандаа Richemont-ийн түүхэн дэх хамгийн залуу Гүйцэтгэх захирал болж, IWC Schaffhausen брэндийг удирдаж байв.

2017 онд Breitling компанийн Гүйцэтгэх захирлаар томилогдсон тэрээр тус компанийн хувь эзэмшигч бөгөөд "орчин үеийн тансаг брэнд" болгон хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Мөн Дэлхийн Эдийн Засгийн Чуулга уулзалтын Залуучуудын удирдагч, Цюрих хот дахь Global Shapers санаачилгын анхны куратор, Швейцар-Америкийн Худалдааны Танхимын ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байжээ.



PANELIST GEORGES KERN

Chief Executive Officer, Breitling

Georges Kern is the CEO of Swiss luxury watchmaker Breitling, where he leads the brand's strategic transformation with a focus on digital innovation and sustainability. With over 20 years of executive experience at top firms including Richemont and IWC Schaffhausen, Kern is recognized for his expertise in luxury branding and global market positioning.

He studied Political Science in Strasbourg and earned a degree in Business Administration from the University of St. Gallen. He began his career in FMCG at Kraft Foods before moving into the watch industry with TAG Heuer. In 2000, he joined Richemont and played a key role in integrating luxury watch brands. At age 36, he became the youngest CEO within Richemont, leading IWC Schaffhausen.

In 2017, he was appointed CEO and shareholder of Breitling SA, with the mission to evolve the brand into a global leader in "neo-luxury" watchmaking. Kern was a World Economic Forum Young Global Leader (2005–2010), the Founding Curator of the Global Shapers Zurich hub, and in 2020, was appointed to the Board of the Swiss-American Chamber of Commerce.



ПАНЕЛИСТ БААТАРЖАВЫН ЛХАГВАЖАВ

Монголын Үндэсний Худалдаа Аж
Үйлдвэрийн Танхимын Удирдах
Зөвлөлийн Дарга бөгөөд Ерөнхийлөгч

Б.Лхагважав нь Урбанек ХХК-ийг үүсгэн байгуулагч, захирал, Монголын гимнастикийн холбооны Ерөнхийлөгч, 2004 онд МҮХАҮТ-ын Удирдах Зөвлөлийн гишүүн, дарга бөгөөд, Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх, Монгол Банкны Хяналтын зөвлөлийн гишүүнээр тус тус ажиллаж байсан.

Тэрээр Бүгд Найрамдах Польш Улсын Техникийн Их сургуулийн электроник инженер, магистр, Монгол Улсын Их сургуулийн эрхзүйч бакалавр, эдийн засгийн ухааны доктор зэрэгтэй.



ПАНЕЛИСТ

ЛХАГВАЖАВ БААТАРЖАВ

Chairman and President of the
Mongolian National Chamber of
Commerce and Industry

Lkhagvajav Baatarjav is the Founder and Director of Urbanek LLC and currently serves as President of the Mongolian Gymnastics Federation. His extensive career includes serving as a Board Member and Chairman of the Mongolian National Chamber of Commerce and Industry (MNCCI) beginning in 2004, as well as later holding the position of President. He has also served as Economic Policy Advisor to the Prime Minister and as a Member of the Supervisory Board of the Bank of Mongolia.

Lkhagvajav holds a Master's degree in Electronic Engineering from the Technical University of the Republic of Poland, a Bachelor's degree in Law from the National University of Mongolia, and a Doctorate in Economics.



ПАНЕЛИСТ

ДАШДОРЖИЙН ЗОРИГТ

Монгол Улсын Эдийн Засгийн
Хөгжлийн Зөвлөлийн үүсгэн
байгуулагч, гүйцэтгэх захирал

Д.Зоригт нь 2025 оны 2 дугаар сард байгуулагдсан Монгол Улсын Эдийн Засгийн Хөгжлийн Зөвлөлийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал юм. Тус байгууллага нь улсын эдийн засгийн урт хугацааны стратеги, бодлогын ялдаа холбоо, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэдэг.

Д.Зоригт нь 2008–2012 онд Уул уурхай, эрчим хүчний сайдаар ажиллах хугацаандаа түүхэнд томоохонд тооцогдох зэс, алт, нүүрс болон эрчим хүчний төслүүдийг төр, хувийн хэвшлийн оролцоотойгоор эхлүүлж, Монгол Улсыг дэлхийн хамгийн хурдацтай өсөж буй эдийн засаг бүхий улсуудын нэг болгож, 2011 онд 17.3 хувийн ДНБ-ий өсөлт гаргахад голлох хувь нэмрээ оруулсан юм. Тэрээр Монгол Улсын уул уурхай, эрчим хүчний салбарын мэргэжилтэн, улс төрч юм. 2009–2012 онд Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байв.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг түүштай дэмждэг тэрээр Монголд анхны арилжааны салхин цахилгаан станцын төслийг олон улсын банк санхүүгийн байгууллагуудаар санхүүжүүлэн амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

Мөн төрийн өмчит стратегийн ордуудыг хариуцсан "Эрдэнэс Монгол" ХХК-ийн анхны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан бөгөөд тус компани нь өнөөдөр улсын төсөв болон үндэсний хөрөнгө оруулалтын сангийн хамгийн том хувь нэмэр оруулагч болоод байна.

Түүнчлэн тэрээр Аж үйлдвэрийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Сангийн яамны Олон улсын хөгжлийн туслалцааны хэлтсийн дарга зэрэг 14 жилийн турш төрийн албанд ахлах удирдах албан тушаал хашиж байв. Гадаад харилцааны яамаас ажлын гараагаа эхэлж, Стратегийн төлөвлөлт, зохицуулалтын газрын дэд захирал, мөн НҮБ дахь Монгол Улсын Байнгын төлөөлөгчийн газрын нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажилласан.

2015–2024 онд хувийн хэвшилд ажиллах хугацаандаа тэрээр харилцаа холбоо, IPTV үйлчилгээ үзүүлэгч, зэсийн катод үйлдвэрлэгч, олон улсын сүлжээ дэлгүүрийн франчайз зэрэг компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байв. Мөн ЕвроАзийн эрсдэлийн зөвлөх үйлчилгээний компаниа үүсгэн байгуулан удирджээ.

Тэрээр дипломат, төрийн албаны туршлагатай мэргэжилтнүүдтэй хамтран байгуулсан бодлогын судалгааны Монголын Хөгжлийн Стратегийн Хүрээлэнгийн идэвхтэй гишүүн бөгөөд Монгол Улсын бус нутгийн болон хөгжлийн бодлогын асуудлуудаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмэр оруулж ирсэн. Мөн ахынхаа дурсгалд зориулан байгуулсан "Бадраа шударга ёсны сан"-гаар дамжуулан Монголын тэргүүлэх их дээд сургуулиудын 200 гаруй оюутанд тэтгэлэг болон менторшип хөтөлбөрийг олгосон байдаг. Д. Зоригт нь Японы Кюсюүгийн их сургуульд хууль зүйн ухааны доктор (LLD), магистр (LLM), Австралийн Үндэсний их сургуульд Олон улсын харилцааны магистр, ОХУ-ын Москва хотын Олон улсын харилцааны улсын дээд сургуульд (МГИМО) улс төр судлалын магистр зэрэг боловсрол эзэмшсэн. Мөн Монголын гадаад бодлого, эдийн засгийн хөгжил, бүс нутгийн аюулгүй байдал зэрэг сэдвээр 30 гаруй нийтлэл туурвижээ.



ПАНЕЛИСТ

ZORIGT DASHDORJ

Founder and Chief Executive Officer,
Economic Development Council of
Mongolia

Zorigt Dashdorj is the Founder and Chief Executive Officer of the Economic Development Council of Mongolia, established in February 2025 to strengthen long-term economic strategy, policy coordination, and the investment environment.

From 2008 to 2012, he served as Minister of Mining and Energy, advancing major copper, gold, coal, and energy projects through public-private partnerships that contributed to Mongolia achieving 17.3% GDP growth in 2011, one of the highest in the world. He was also elected as a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia, serving from 2009 to 2012. Earlier, Zorigt was the first CEO of Erdenes Mongol LLC, overseeing strategic state-owned mineral assets that remain key contributors to the national budget and sovereign wealth fund.

He also played a vital role in financing and launching Mongolia's first commercial wind power project, underscoring his commitment to private investment. Over his 14-year public service career, he held senior positions including Director of the Industrial Policy and Planning Department, Head of the International Development Assistance Division at the Ministry of Finance, Deputy Director of Strategic Planning at the Ministry of Foreign Affairs, and First Secretary at Mongolia's Permanent Mission to the UN.

Between 2015 and 2024, he served on boards across telecommunications, copper cathode production, and international retail franchises, and founded a Eurasian risk advisory firm. He is an active member of the Mongolian Development Strategy Institute, fostering public dialogue on regional and development policy. Through the Badraa Justice Fund, established in memory of his brother, he has supported over 200 university students with scholarships and mentorship.

Zorigt holds an LLD and LLM in Law from Kyushu University (Japan), a Master's in International Relations from the Australian National University, and a Master's in Political Science from MGIMO (Russia). He has authored over 30 publications on Mongolia's foreign policy, economic development, and regional security.

Салбар хуралдаан 2:

ОЛОН УЛСААС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТАТАХ НЬ

Сэдвийг онцлохын ач холбогдол

Олон улсын улс төр, эдийн засаг, нийгэм, технологийн орчин хурдан өөрчлөгдөж байгаа энэ үед гадаадын шууд хөрөнгө оруулалт нь нээлттэй жижиг эдийн засагтай улс орнуудын хувьд томоохон сорилт болж байна. Нөгөө талаас Монгол Улсын эдийн засаг тогтвортой, хүртээмжтэй, төрөлжиж тэлэх шаардлагатай тулгарч байна. Эдийн засгийг төрөлжүүлэх, шинэ технологи, мэдлэгийг нэвтрүүлэх, ажлын байр бий болгох, дэд бүтцийг сайжруулахад гадаадын шууд хөрөнгө оруулалт чухал үүрэг, ач холбогдолтой. Улс орнууд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах чиглэлээр олон төрлийн арга хэмжээ авч ажиллаж байна. Монгол улсын хувьд хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, хөрөнгө оруулалтыг татах хөшүүргийг бий болгох чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлуудыг танилцуулж, хэлэлцүүлэг явуулах нь цаг үеэ олсон чухал арга хэмжээ болно.

Хэлэлцүүлгийн зорилго

- Энэ панел хэлэлцүүлэг нь Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж, саад бэрхшээл, түүнийг шийдвэрлэх гарцуудыг тодорхойлох зорилготой.
- Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг татах бодит боломжуудыг хэлэлцэх
- Гадаадын хөрөнгө оруулалтын эрхзүйн орчны шинэчлэл, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн талаар мэдээлэл өгөх
- Гадаадын хөрөнгө оруулагчдын өмнө тулгарч буй асуудлууд, түүний шийдлийг хэлэлцэх
- Бодлого боловсруулагчид, хувийн хэвшил, гадаадын хөрөнгө оруулагчдын хооронд итгэлцлийг бэхжүүлэх
- Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах боломжуудын тухай хэлэлцэх

Хэлэлцүүлгээс хүлээгдэж буй үр дүн

- Монгол Улсын Засгийн газрын хөрөнгө оруулалтын талаарх бодлогыг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах
- Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл болон эрхзүйн орчны шинэчлэлийн талаар мэдээлэл солилцох
- Гадаадын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах бодлогын зөвлөмжүүдийг гаргах
- Хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татах боломжуудыг тодорхойлох

Sub-session 2:

ATTRACTING GLOBAL INVESTMENT & CAPITAL MARKETS

Importance of the topic

In this rapidly changing environment of geopolitics, economics, society, and technology, foreign direct investment (FDI) poses a significant challenge for small open economies. On the other hand, Mongolia's economy needs to be stable, inclusive, and diversified. Foreign direct investment plays an important role and significance in diversifying the economy, introducing new technologies and knowledge, creating jobs, and improving infrastructure. Countries are taking a variety of measures to attract foreign direct investment. For Mongolia, it would be a timely and important event to present and discuss actions taken by the government to improve the investment environment and create incentives to attract investment.

Purpose of discussion

- The aim of this panel discussion is to discuss opportunities to increase global investment into Mongolia, challenges and hurdles that foreign investors face and solutions to overcome these challenges, which includes the following:
 - Discuss specific opportunities to attract global investment into Mongolia
 - Discuss about legislative reform for Mongolia's investment environment, namely amendments to the Draft Foreign Investment Law.
 - Discuss challenges and hurdles that foreign investor face
 - Come up with recommendations for improvement of investment climate
 - Discuss about opportunities to attract investments from capital markets

Expected outcome from the discussion

- Promote the investment policies of the Government of Mongolia to domestic and foreign investors, the private sector, the media, and the public.
- Exchange information on Mongolia's Foreign Investment Law and legal environment reforms
- Make policy recommendations to improve the foreign investment environment
- Identify investment opportunities from the capital market



МОДЕРАТОР

ЭНХБААТАРЫН ЗОЛБЯАР

Capital Markets Mongolia (CMM)
компанийн Гүйцэтгэх захирал,
үүсгэн байгуулагч

Э.Золбаяр нь судалгаа, зөвлөх үйлчилгээний Capital Markets Mongolia (CMM) компанийн Гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагч. CMM нь гадаадын хөрөнгө оруулагчдыг Монголтой холбох зорилготой Сингапур, Нью-Йорк, Лондон зэрэг дэлхийн гол санхүүгийн төвүүдэд Монголын Хөрөнгө Оруулалтын Форумыг зохион байгуулдаг билээ.

Мөн Монголын тэргүүлэгч бизнес, санхүүгийн медиа болох Lemon Press-ийн үүсгэн байгуулагчдын нэг. Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны Удирдах зөвлөлийн гишүүн.

Тэрээр АНУ-ын Нью-Йоркийн Их Сургуулийн (NYU) эдийн засгийн магистр хамгаалсан.



MODERATOR

ZOLBAYAR ENKHBAYAR

Chief Executive Officer, Capital Markets
Mongolia (CMM)

Zolbayar Enkhbaatar is the Founder & CEO of Capital Markets Mongolia (CMM), a research and advisory firm. CMM closely work with foreign investors as the firm organizes Mongolia Investment Forum in Singapore, New York, and London.

Zolbayar is also a co-founder of Lemon Press, a leading financial media company specializing in data, news, analytics, and market insights in Mongolia.

He also serves as a board member of the Mongolian Association of Securities Dealers. He earned a master's degree in economics from New York University.



ПАНЕЛИСТ

ТОГМИДЫН ДОРЖХАНД

Улсын Их Хурлын гишүүн,
Шадар сайд, ХҮН намын дарга

Т.Доржханд нь УИХ-ын гишүүнээр хоёр дахь удаагаа сонгогдон ажиллаж байна. Тэрээр Сангийн яаманд газрын дарга, Америкийн Нэгдсэн Улс дахь ОУВС-гийн Ази, Номхон далайн бүсийн гүйцэтгэх захирлын зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай.

2024 оноос 2025 оны зургаадугаар сар хүртэл Засгийн газрын Шадар сайд бөгөөд Эрчим хүчний үндэсний хорооны даргаар, 2025 оны зургаадугаар сараас Шадар сайдаар ажиллаж байна.

Монгол Улсын Их Сургуульд санхүү, эдийн засгийн бакалавр, Япон улсын Хитоцүбаши Их сургуульд төрийн бодлогын магистр.Мөн мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрийн магистрт Кембрижийн Харвард Кеннедигийн сургууль болон Их Британийн Оксфорд дахь Бизнесийн сургуулиудыг дүүргэжээ.



PANELIST

DORJKHAND TOGMID

Deputy Prime Minister, and Chairman of the Hun Party, Member of the State Great Hural (Parliament) of Mongolia

Dorjkhand Togmid is serving his second term as a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia. He has previously held senior positions including Director-General at the Ministry of Finance and Advisor to the Executive Director for the Asia and Pacific region at the International Monetary Fund (IMF) in Washington, D.C.

From 2024 until June 2025, he served as Deputy Prime Minister and Chair of the National Energy Committee. Since June 2025, he has continued in office as Deputy Prime Minister of Mongolia.

Dorjkhand holds a degree in finance and economics from the National University of Mongolia and a master's degree in public policy from Hitotsubashi University in Japan. He also completed executive training programs at the Harvard Kennedy School and the Saïd Business School at the University of Oxford.



ПАНЕЛИСТ

ТҮНДЭВИЙН ЖАМБААЖАМЦ

Санхүүгийн зохицуулах
хорооны дарга

МУИС, Хууль зүйн сургуулийг Олон улсын эрхзүйч мэргэжлээр төгссөн. Санхүү, эдийн засгийн их сургуулийн Бизнесийн удирдлагын магистр.

2006 онд Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт, шалгалтын газрын мэргэжилтнээр ажлын гараагаа эхэлсэн бөгөөд өнөөдрийг хүртэл тасралтгүй ажиллах хугацаандаа Үнэт цаасны газрын ахлах хянан шалгагч, Хөрөнгийн зах зээлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Үнэт цаасны газрын дарга, Хяналт шалгалт, зохицуулалтын газрын орлогч дарга, Ажлын албаны даргаар ажиллаж байгаад 2025 оноос Санхүүгийн зохицуулах хорооны даргаар ажиллаж байна.



PANELIST

**JAMBAAJAMTS
TUNDEV**

Chairman of the Financial
Regulatory Commission

He holds a Bachelor degree in Law from the National University of Mongolia and a Master's degree in Business Administration from the University of Finance and Economics.

He began his career in 2006 as a specialist in the Supervision Department of the Financial Regulatory Commission, and since then has continuously served in various positions, including Senior Inspector of the Securities Department, Head of the Capital Market Policy and Planning Division, Head of the Securities Department, Deputy Director of the Supervision Department, and Chief Executive. Since 2025, he has been serving as the Chairman of the Financial Regulatory Commission.



ПАНЕЛИСТ

**ХУАН ПАБЛО
ГАРМЕНДИА**

Ахлах шинжээч, хөгжиж буй зах
зээлийн үнэт цаас, StoneX Group Inc.

Хуан Пабло Гармендиа нь Лондон хотод төвтэй StoneX Group Inc-д хөгжиж буй зах зээлийн үнэт цаас хариуцсан ахлах шинжээчээр ажиллаж байна. Тэрээр өндөр өгөөжтэй, онцгой нөхцөлтэй үнэт цаасны шинжээчээр болон төрийн болон хувийн хэвшлийн зээлжих эрх дээр төвлөрөн ажилладаг.

GML Capital-д ахлах зээлийн шинжээчээр ажиллах хугацаандаа нарийн үнэлгээний загвар, бүтцийн шинэчлэлд суурилсан стратегийн зах зээлийн үзүүлэлтүүдийг тогтмол даван биелүүлж байв.

Тэрээр Banco de Mexico-д мөнгөний бодлого, санхүүгийн тогтвортой байдлын асуудлаар зөвлөх, мөн финтек үйлчилгээний бодлогыг анх боловсруулжээ. Мөн REMEX-д санхүүгийн шинжээчээр ажиллаж, зээлийн дахин санхүүжилт болон бусад хөрөнгө оруулалтын төслүүдийг удирддаг. Түүнчлэн Хуан Пабло нь Мексикт CAN Group нэртэй үл хөдлөх хөрөнгийн төслүүд хэрэгжүүлдэг старт-ап компанийг хамтран үүсгэн байгуулсан.

Тэрээр Лондонгийн Бизнесийн Сургуульд MBA, Мексик хотын ITAM Их сургуулийн эдийн засаг, эрх зүйн хос мэргэжилтэй бөгөөд Лондонгийн Эдийн Засгийн сургууль, Шанхайн Tongji Их сургуульд мэргэшсэн.



PANELIST

**Juan Pablo
Garmendia**

Senior Emerging Markets Analyst,
StoneX Group Inc.

Juan Pablo Garmendia is a Senior Emerging Markets Analyst at StoneX Group Inc., based in London. With over a decade of experience, he specializes in sovereign and corporate credit across high-yield, special situations, and distressed EM assets. Previously, he was a Senior Credit Analyst at GML Capital, where his mandates consistently outperformed benchmarks through rigorous valuation models and restructuring strategies.

His career spans Banco de Mexico, where he advised on monetary policy and financial stability and helped shape Mexico's pioneering FinTech regulations. He also served as a financial analyst at PEMEX, overseeing large-scale debt refinancing and capital projects. An entrepreneur, Juan Pablo co-founded CAN Group, a real estate start-up delivering high-return retail projects in Mexico.

He holds an MBA from London Business School, a dual degree in Economics and Law from ITAM in Mexico City, and completed programs at the London School of Economics and Tongji University in Shanghai. Fluent in Spanish and English, he also speaks Portuguese.



ПАНЕЛИСТ

АЛАН ЧАН

J.P. Morgan банкны Өрийн Хөрөнгийн Зах зээл, Хонг Конг, Тайвань, Монгол, Макао-г хариуцсан хэлтэс болон Ази (Японоос бусад)-ийн орнуудын Зээлжих зэрэглэлийн зөвлөх үйлчилгээний газрын дарга

Алан Чан нь 2011 оноос J.P. Morgan-д ажиллаж байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газар, Монголын Хөгжлийн Банк, Голомт банк зэрэг байгууллагуудын бонд гаргах ажилд идэвхтэй оролцож, удирдан зохион байгуулж байсан.

J.P. Morgan-д ажиллахаасаа өмнө Алан Чан нь Fitch Ratings агентлагт Дэд захирлаар ажиллаж байжээ. Тэрээр Chartered Financial Analyst (CFA)-ийн зэрэгтэй бөгөөд Их Британийн Экзетерийн Их Сургуульд Санхүүгийн Шинжилгээ, Сангийн Менежментийн чиглэлээр магистрын зэрэг хамгаалсан.



PANELIST

ALAN CHAN

Head of Debt Capital Markets, Hong Kong, Taiwan, Mongolia and Macau and Ratings Advisory, Asia ex-Japan.

Alan Chan joined J.P. Morgan in 2011 and has been involved and led the bonds issuances by the Mongolia government, Development Bank of Mongolia and Golomt Bank etc.

Before he joined J.P.Morgan, he was the Associate Director at Fitch Ratings. He has the Chartered Financial Analyst (CFA) qualification and a Master of Science of Financial Analysis and Fund Management at the University of Exeter.



ПАНЕЛИСТ

БААСАНДАВААГИЙН ДӨЛГӨӨН

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-н
Гүйцэтгэх Захирлын үүргийг түр орлон
гүйцэтгэгч

Б.Дөлгөөн нь “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2025 оны нэгдүгээр сараас хойш томилогдон ажиллаж байна. Б.Дөлгөөн нь санхүүгийн зах зээл, эдийн засаг тэр дундаа хөгжлийн эдийн засгийн чиглэлээр 15 жил ажилласан туршлагатай. Тэрээр өмнө нь Ерөнхий сайдын дэргэдэх Эдийн засгийн бодлогын зөвлөлийг ахалж ажиллаж байсан. “Шинэ Сэргэлтийн Бодлогын Хурдасгуур Төв”-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байхдаа улсын эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж буй хүчин зүйлсийг шийдвэрлэхэд төвлөрч, суурь судалгааны ажлууд гүйцэтгэж байв. Б.Дөлгөөн нь төрийн албаны удирдах түвшинд Үндэсний Хөгжлийн Газрын дэд захирал, Эдийн засаг, хөгжлийн сайдын зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай. Тэрээр АНУ-ын Харвардын Их Сургуулийг Олон улсын хөгжлийн эдийн засгийн магистр (MPA/ID), Коннектикат коллежийг Математик, Эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй тус тус төгссөн.



PANELIST

**DULGUUN
BAASANDAVAA**

Interim Chief Executive Officer of the
Mongolian Stock Exchange

Dulguun Baasandavaa is the Interim Chief Executive Officer of the Mongolian Stock Exchange, appointed in January 2025. He brings over 15 years of experience in financial markets, economic policy, and development strategy. Prior to this role, he headed the Economic Policy Council under the leadership of the Prime Minister. He has also served as the Executive Director of the New Recovery Policy Accelerator Center, where he led national growth diagnostics and addressed binding constraints to Mongolia's economic development. His public sector leadership includes serving as Deputy Director of the National Development Agency and Advisor to the Minister of Economy and Development. Mr. Baasandavaa holds a Master in Public Administration in International Development (MPA/ID) from Harvard University and a BA in Economics and Mathematics from Connecticut College.

Салбар хуралдаан 3:

ТОДОРХОЙГҮЙ БАЙДАЛТАЙ НҮҮР ТУЛАХ НЬ

ОЛОН УЛСЫН ТОГТВОРГҮЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫГ ДАВАН ТУУЛАХ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛҮҮД

Дэлхийн улс орнуудын зах зээлийн уялдаа, холбоо хамаарал өсөн нэмэгдэж байгаа энэ үед геополитикийн зөрчилдөөн, олон улсын худалдааны бодлогод гарч буй өөрчлөлтүүд, дэлхийн нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, эрчим хүчний зах зээлийн хэлбэлзэл, инфляцын дарамт зэргээс үүдэж дэлхий дахинаа тогтворгүй нөхцөл байдал улам нэмэгдэж байна. Үүний улмаас Монгол Улс болон дэлхийн бусад хөгжиж буй орнуудад дам нөлөө үзүүлж, улмаар гадаад шоконд эмзэг болгож макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад хүндрэл учруулж байна. Эдгээр динамикаас үүдэлтэй тогтворгүй байдал улам газар авч, дэлхийн улс орнуудын бодлого тодорхойлогчдод дунд болон урт хугацааны шийдвэр гаргахад бэрхшээлийг үүсгэж байна.

Монгол Улсын түүхий эдийн экспорт, гадаад эрэлтээс хараат эдийн засаг нь дэлхийн зах зээлийн тогтворгүй байдалд эмзэг хэвээр байна. Энэхүү нөхцөл байдалд эдийн засгийн тогтвортой байдлыг хангахын тулд төсөв болон мөнгөний бодлогын уялдааг хангах замаар инфляцыг барих, нийгмийн халамжийн хөтөлбөрийг зорилтот бүлэгт чиглүүлэх, төсвийн орон зайг хадгалж, өрийн удирдлагын зохистой арга хэмжээг авч бодлогын нөөцийг нэмэгдүүлэх нь зүйтэй юм.

Хэлэлцүүлгийн зорилго

Хэлэлцүүлгийн зорилго нь Монгол болон бусад ижил төстэй улс орнуудад олон улсын тогтворгүй нөхцөл байдал хэрхэн нөлөөлж байгаа талаар санаа бодлоо солилцож, үүсэж болох эрсдэлүүдийг даван туулах, түүнээс сэргийлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг сайжруулах, хадгалан үлдэх талаар хэлэлцүүлэг өрнүүлэхэд оршино.

Хэлэлцүүлгээс хүлээгдэж буй үр дүн

Хэлэлцүүлгийн үр дүнд, тааварлахад бэрх, тогтворгүй нөхцөл байдал үүсээд байгаа энэ цаг үед тулгарч болох гол сорилтууд, авах хариу арга хэмжээний талаар нэгдсэн байр суурь ойлголтыг бий болгож макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих бодлогын зөвлөмжүүдийг хүргэх, Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээний талаарх мэдээллийг хүргүүлсэн байна.

Sub-session 3:

NAVIGATING GLOBAL UNCERTAINTIES AND MACROECONOMIC FACTORS

NAVIGATING GLOBAL UNCERTAINTIES & MACROECONOMIC FACTORS

Amid growing interconnectedness in global markets, escalating geopolitical tensions, shifts in international trade policies, global supply chain disruptions, energy market volatility and inflationary pressures are contributing to heightened global uncertainties. These developments are having significant spillover effects on developing economies, including Mongolia, making them more vulnerable to external shocks and complicating efforts to maintain macroeconomic stability.

These dynamics are fueling the uncertainties and making it challenging for decision makers around the world to plan their policies for the medium and long term.

As a country highly reliant on commodity exports and external demand, Mongolia remains particularly vulnerable to fluctuations in global markets. Ensuring stability under these conditions calls for coordinated monetary and fiscal policies to manage inflation, targeted support for vulnerable groups, and prudent debt management to preserve fiscal space and build policy buffers.

Purpose of discussion

The purpose of this session is to facilitate a comprehensive exchange of views and insights on the impact of global uncertainties on Mongolia and other similar economies. It aims to foster a dialogue on identifying potential risks, strategies to overcome and prevent these challenges, and to explore effective policy options that can enhance, sustain, and strengthen macroeconomic stability and resilience.

Expected outcome from the discussion

The discussion is expected to build a shared understanding among stakeholders of the key challenges accompanied by actionable recommendations that support sustained macroeconomic stability and inclusive growth during times of global uncertainties. In addition, the session will serve as a platform for the Government of Mongolia to present the measures it is undertaking to mitigate emerging risks and ensure economic resilience.



МОДЕРАТОР ДАМБАДАРЖААГИЙН ЖАРГАЛСАЙХАН

Эдийн засагч, Нийтлэлч

Д.Жаргалсайхан нь "The Defacto Gazette" болон "The Defacto Institute"-ийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал. Тэрээр эдийн засаг, улс төрийн бодлогын шүүмж-нийтлэл бичдэг ба "DeFacto ярилцлага", "Дефакто Тойм" долоо хоногийн Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хамгийн чухал үйл явдалд дүгнэлт өгдөг нэвтрүүлгийн хөтлөгч, эдийн засагч, хараат бус нийтлэлч юм.

Д.Жаргалсайхан нь санхүүгийн зах зээлээр мэргэшсэн эдийн засагч мэргэжилтэй.



MODERATOR

JARGALSAIKHAN DAMBADARJAA

Economist, Independent editor at
"The Defacto Gazette", Defacto Institute"

Jargalsaikhan Dambadarjaa (known as Jargal DeFacto) is an independent economist and media representative of Mongolia. He is a Mongolian political and economic observer, columnist, and host of TV's Defacto Debate, Defacto Review, and Defacto Interview, weekly television interviews on VTV in Mongolia, featuring distinguished Mongolian, English and Russian-speaking guests from across the globe. Jargal also hosts Radio DeFacto, a radio talk show aired daily at 6:30pm on Business Radio 98.9FM.

He is a founder of The Defacto Institute, an independent research think tank that also publishes the 'The Defacto Gazette', a weekly analytical newspaper covering the politics and economics of Mongolia—in English, Japanese, and Mongolian. Its Mongolian edition is shared with readers every Wednesday, while the English and Japanese editions are sent to readers every Tuesday via email.

Since 2009, Jargalsaikhan has been writing weekly articles on the current economic, political and social issues in the country, which are printed in Mongolian and English daily newspapers. He contributes to public opinion formation in the country through a range of formal and social media.



ПАНЕЛИСТ

РЭНЧИНБЯМБЫН СЭДДОРЖ

Улсын Их Хурлын гишүүн, Эдийн
Засгийн байнгын хорооны дарга

Р.Сэддорж нь 2004-2007 онд Улсын Их Хурлын гишүүний бие төлөөлөгч, 2006-2008 онд, МҮБХ-ны аймаг цэргийн цолтой бөхчүүдийн зөвлөлийн ахлагч, 2009-2010 онд "Таван толгой" ХК-ийн санхүү хариуцсан дэд захирал, 2012-2024 онд Өмнөговь аймгийн ИТХ-ын төлөөлөгч, тэргүүлэгч, 2013 онд Өмнөговь аймгийн Засаг даргын уул уурхай, байгаль орчин, дэд бүтэц хариуцсан орлогч даргаар ажиллаж байсан.

Мөн 2013-2020 онд "Таван толгой" ХК-ийн гүйцэтгэх захирал, 2020-2024 онд Өмнөговь аймгийн Засаг даргаар ажиллаж байв. Тэрээр 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон бөгөөд Эдийн засгийн байнгын хорооны даргаар ажиллаж байна.

"Хан-Уул" дээд сургуулийг Бизнесийн эдийн засагч, хэрэглээний математикч мэргэжлээр төгссөн. Удирдлагын академийн Нийгмийн ухааны магистр.



PANELIST

SEDDORJ RENCINBYAMBA

Member of the State Great Hural (Parliament) of Mongolia, Chair of the Standing Committee on the Economy

Seddorj Renchinbyamba has served as the Governor of Umnugovi Province from 2020-2024. Prior to that, he served as Chief Executive Officer of Tavan Tolgoi JSC from 2013 to 2020. In 2013, he was appointed Deputy Governor of Umnugovi Province, overseeing the mining, environment, and infrastructure sectors.

From 2012 to 2024, Seddorj was an elected member and presidium member of the Citizens' Representative Khural of Umnugovi Province. Earlier in his career, he served as Deputy Director for Finance at Tavan Tolgoi JSC (2009-2010), and from 2004 to 2007, he worked as the official representative to a Member of Parliament.

Seddorj also served as the Head of the Provincial Military-Titled Wrestlers under the Mongolian National Wrestling Federation.

He holds a degree in Business Economics and Applied Mathematics from Khan-Uul Institute and a Master's degree in Social Sciences from the Academy of Governance.



ПАНЕЛИСТ

БОЛДЫН ЖАВХЛАН

Улсын Их Хурлын гишүүн,
Сангийн сайд

Б.Жавхлан нь эдийн засагч мэргэжилтэй. Монгол Улсын их сургуулийн Эдийн засгийн сургууль, АНУ-ын Индианагийн Их Сургуульд тус тус суралцсан. 1997 онд Монголбанкны хянан шалгагчаас ажлын гараагаа эхэлсэн бөгөөд Худалдаа хөгжлийн банкны дэд захирал, Монголбанкны тэргүүн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байгаад 2016 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон.

2020-2021 онд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга, 2021 оноос Сангийн сайдаар ажиллаж байна.



PANELIST

BOLD JAVKHLAN

Minister of Finance, Member of the State Great Hural (Parliament) of Mongolia

Bold Javkhlán is a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia and currently serves as the Minister of Finance.

He began his career at the Bank of Mongolia, where he worked as a bank examiner from 1997 to 1999. He then served as the Bank of Mongolia's plenipotentiary representative and receiver at Khan Bank between 1999 and 2000, before returning as a senior examiner from 2000 to 2004. He went on to serve as Director of Operations (2004–2006) and later as Deputy CEO (2006–2007) at Trade and Development Bank of Mongolia. From 2010 to 2016, he served as First Deputy Governor of the Bank of Mongolia.

He was first elected to Parliament in 2016 and has since been elected three consecutive times. From 2016 to 2020, he chaired the Subcommittee on Local Governance, and from 2020 to 2021, he served as Chair of the Standing Committee on Budget. Since 2022, he has been serving as Minister of Finance.

Javkhlán holds a degree in Banking Economics from the National University of Mongolia and completed additional studies at the University of California, Riverside, and Indiana University in the United States.



ПАНЕЛИСТ

БЯДРАНГИЙН ЛХАГВАСҮРЭН

Монголбанкны Ерөнхийлөгч

Б.Лхагвасүрэн нь Монголбанкны Дэд ерөнхийлөгч, Хадгаламжийн даатгалын корпорацийн Гүйцэтгэх захирал, Монголын Банкны холбооны Дэд ерөнхийлөгч, Монголбанкны Хяналт шалгалтын газрын захирал, Бүртгэл тооцоо, мэдээллийн технологийн газрын захирал, мөнгөний бодлогын газарт ахлах эдийн засагч, Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнээр ажилласан туршлагатай. Мөн Дэлхийн банкны Вашингтон дахь Зүүн хойд Ази, Номхон далайн орнуудын санхүүгийн салбарт зөвлөхөөр ажиллаж байсан.

Монгол Улсын Их Сургуульд эдийн засагч мэргэжлээр суралцсан. Бакалавр зэрэгтэй. АНУ-ын Колумбын их сургуулийн олон улсын эдийн засгийн харилцааны магистрын зэрэгтэй.



PANELIST

**LKHAGVASUREN
BYADRAN**

Governor of the Bank of Mongolia

Lkhagvasuren Byadran is the Governor of the Bank of Mongolia. He brings over two decades of experience in banking and finance, having previously served as Deputy Governor of the Bank of Mongolia, Executive Director of the Deposit Insurance Corporation, Vice President of the Mongolian Bankers Association, Director of the Supervision Department, Director of the Accounting, Settlement and IT Department, and Senior Economist at the Monetary Policy Department. He also served as a member of the Financial Regulatory Commission and was a financial sector advisor for Northeast Asia and the Pacific at the World Bank in Washington, D.C.

Lkhagvasuren holds a bachelor's degree in Economics from the National University of Mongolia and a master's degree in International Economic Relations from Columbia University in the United States.



ПАНЕЛИСТ

**РИЧАРД Л.
БУАНГАН**

Америкийн Нэгдсэн Улсаас Монгол
Улсад суугаа Элчин сайд

АНУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайд Ричард Л.Буанган нь АНУ-ын Гадаад Хэргийн яамны ахлах дипломат албаны ажилтан бөгөөд Иерусалим дахь АНУ-ын Ерөнхий консулын газрын Олон нийтийн харилцааны ажилтан, Бээжин дэх АНУ-ын Элчин сайдын яамны Хэвлэлийн атташе, мөн Парис, Абиджан хотуудад Вашингтон хот дахь төв байгууллагад Глобал олон нийтийн харилцааны товчооны үйл ажиллагаа хариуцсан төрийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч, мөн дэд төрийн нарийн бичгийн дарга, Зүүн Ази, Номхон далайн хэрэг эрхлэх товчоонд Олон нийтийн дипломатын болон бүс нутгийн аюулгүй байдлын бодлого хариуцсан дэд төрийн нарийн бичгийн дарга, Төрийн нарийн бичгийн дарга Майкл Р. Помпеогийн Гүйцэтгэх туслахын албыг тус тус хашиж байжээ. Элчин сайд Буанган нь Гадаад хэргийн яамны олон шагнал, хүндэтгэл хүртсэн юм.

Элчин сайд Ричард Л.Буанган нь Сан Диего хотод төрж өссөн бөгөөд Техасын Остин дахь St. Edward's их сургуульд Улс төр судлал, Эдийн засгийн чиглэлээр бакалаврын зэрэг хамгаалсан. Тэрээр франц, испани, хятад хэлтэй.



PANELIST

**H.E. RICHARD L.
BUANGAN**

Ambassador of the United States of
America to Mongolia

H.E. Richard L. Buangan is the U.S. Ambassador to Mongolia, currently serving in Ulaanbaatar. A career member of the Senior Foreign Service, he joined the U.S. Department of State in 1999. His overseas assignments have included Public Affairs Officer in Jerusalem, Press Attaché in Beijing, and postings in Paris and Abidjan.

He has held senior roles in Washington, D.C., including Acting Assistant Secretary and Principal Deputy Assistant Secretary in the Bureau of Global Public Affairs, Deputy Assistant Secretary for Public Diplomacy and Regional Security Policy in the Bureau of East Asian and Pacific Affairs, and Executive Assistant to Secretary of State Michael R. Pompeo. Ambassador Buangan is a recipient of numerous State Department awards.

Born in San Diego, he holds a B.A. in Political Science and Economics from St. Edward's University, and speaks French, Spanish, and Mandarin.



ПАНЕЛИСТ

**ИНА
МАРЧЮЛЁНИТЕ**

Европын Холбооноос Монгол Улсад
суугаа Элчин сайд

Ина Марчюлėните нь Европын холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайдаар ажиллаж байна. Тэрээр 2020-2024 онд Бүгд Найрамдах Ардчилсан Лоас Улсад Европын холбооны Элчин сайдаар ажиллаж байжээ. Европын холбооны дипломатын албанд элсэхийн өмнө хатагтай Марчюлėните нь 2015-2020 онд Бүгд Найрамдах Литва Улсын Элчин сайдаар БНХАУ-д томилогдон ажиллаж байсан бөгөөд үүнтэй зэрэгцэн Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Тайланд, Вьетнам, Мьянмар улсуудын бүрэн эрхт төлөөлөгчөөр ажиллаж байв. Мөн 2003-2010 онд Бүгд Найрамдах Литва Улсын Элчин сайдаар, ЮНЕСКО-д Байнгын төлөөлөгчөөр ажиллаж, 2007-2010 онд ЮНЕСКО-гийн Захирлуудын Зөвлөлийн дэд ерөнхийлөгчөөр, ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны даргаар ажиллаж байжээ. Түүнчлэн 1999-2003 онд Бүгд Найрамдах Литва Улсын Соёлын дэд сайдаар ажилласан юм.

Ина Марчюлėните нь Вильнюсын Их сургуульд Литва хэл, уран зохиолын чиглэлээр суралцаж төгссөн бөгөөд 2004-2005 онд Францын Олон улсын харилцаа, дипломатын судалгааны төвд олон улсын харилцаа, дипломат албаны чиглэлээр докторын сургалт дүүргэсэн.

Тэрээр дөрвөн хэлээр (англи, франц, литва, орос) чөлөөтэй ярьдаг бөгөөд урлаг, соёл, соёлын бодлого, өв соёлын талаар олон ном орчуулж, олон нийтэд зориулсан нийтлэлүүд бичиж байсан туршлагатай.



PANELIST

INA MARČIULIONYTĖ

Ambassador of European Union to
Mongolia

Ina Marčiulionytė is the Ambassador of the European Union to Mongolia, a role she assumed after serving as the EU Ambassador to the Lao People's Democratic Republic from 2020 to 2024. Before joining the European Union diplomatic service, Ms. Marčiulionytė served as the Ambassador of Lithuania to the People's Republic of China, also accredited for Mongolia, the Republic of Korea, Thailand, Vietnam, and Myanmar between 2015 and 2020. Previously, she was the Ambassador and the Permanent Delegate of Lithuania to UNESCO from 2003 to 2010, where she also served as Vice-President of UNESCO's Executive Board (2007-2010) and a Chairperson of UNESCO World Heritage Committee. She served as Vice-Minister of Culture of Lithuania from 1999 to 2003. Ms. Marčiulionytė graduated from Vilnius University, with a degree in Lithuanian language and literature. She completed her PhD course in Centre d'Etudes Diplomatiques et Stratégiques, France on international relations and diplomacy (2004-2005). She worked as a correspondent and editor for various Lithuanian newspapers and magazines. As a founding member of the Open Society Fund Lithuania in 1991, Ms. Marčiulionytė was in the vanguard of the efforts to foster democracy in the newly independent Lithuania.

She speaks four languages (English, French, Lithuanian and Russian) and has translated several books and written numerous articles on arts and culture, cultural policy and heritage.



ПАНЕЛИСТ

АЛЬБЕРТ ФРАНСИС ПАРК

Ерөнхий эдийн засагч,
Азийн Хөгжлийн Банк (ADB)

Альберт Ф. Парк нь Азийн Хөгжлийн Банкны Ерөнхий эдийн засагч, Эдийн засгийн судалгаа, хөгжлийн нөлөөллийн газрын Ерөнхий захирлаар ажилладаг. Тэрээр эдийн засаг, хөгжлийн чиг хандлагын талаар АХБ-ыг төлөөлөн байр суурийг илэрхийлж, гол судалгааны бүтээлүүд болон бүс нутгийн хамтын ажиллагааны санаачилгуудыг удирдан чиглүүлдэг.

Хөгжлийн эдийн засагчийн хувьд 20 гаруй жилийн ажлын туршлагатай бөгөөд Хятадын эдийн засгийн талаар өргөн хүрээнд судалсан хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч юм. Тэрээр ядуурал, тэгш бус байдал, бичил санхүү, хөдөлмөрийн зах зээл, гадаадын хөрөнгө оруулалт зэрэг олон асуудлаар бодлогын судалгааны ажил хийсэн.

Альберт Ф Парк нь Гонконгийн ШУТИС-ийн профессор бөгөөд шинээр гарч буй зах зээлийн судалгааны институт болон Эдийн засгийн бодлогын төвийг үүсгэн байгуулагч, захирал, Оксфордын болон Мичиганы Их сургуульд багшилж байжээ. Альберт Ф Парк нь Харвардын Их сургуулийн бакалавр, Стэнфордын Их сургуулийн эдийн засгийн доктор.



PANELIST

ALBERT FRANCIS PARK

Chief Economist,
Asian Development Bank (ADB)

Albert F. Park is Chief Economist of the Asian Development Bank and Director General of its Economic Research and Development Impact Department. He serves as the Bank's chief spokesperson on economic trends and development, guiding ADB's flagship publications and regional cooperation initiatives.

With over two decades of experience as a development economist, he is widely recognized for his expertise on China's economy and has contributed to policy on poverty, inequality, microfinance, labor markets, and foreign investment. Mr. Park was Chair Professor at HKUST, founding director of its Institute for Emerging Market Studies and Center for Economic Policy, and previously taught at Oxford and Michigan. A U.S. national, he holds a bachelor's degree from Harvard and a PhD from Stanford.

Үндсэн хуралдаан 2: ХОТЖИЛТ, ХОТ ТӨЛӨВЛӨЛТ

Сэдвийг онцлохын ач холбогдол

Хот төлөвлөлт ба хотжилт нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын суурь үндэс болдог. Улс орон хурдацтайгаар хотжиж буй энэ үед Улаанбаатар хот нь Монголын газар зүйн болон эдийн засгийн төв болоод байна. Нийт хүн амын талаас илүү хувийг багтаасан нийслэл хот нь улсын дотоодын нийт бүтээгдэхүүний ихэнхийг бүрдүүлж байгаа бөгөөд хотын үр ашигтай, хүртээмжтэй үйл ажиллагаа, амьдрах орчны таатай нөхцөл, цаашдын өсөлтийг дэмжих чадамж нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдал, нийгмийн уялдаа холбоо, байгаль орчны тогтвортой хөгжилтэй шууд холбоотой юм.

Энэхүү ухаалаг, ногоон, иргэн төвтэй "Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө-2040" нь үндэсний шинэчлэлийн алсын харааг тодорхойлж байна. Тус стратегийн баримт бичиг нь зөвхөн дэд бүтцийн хөгжлөөр хязгаарлагдахгүй бөгөөд эдийн засгийн төрөлжилт, нийгмийн хүртээмж, байгаль орчны хариуцлагыг давхар хөндөж буй. Төлөвлөгөөний гол агуулгын нэг нь олон төвт хөгжлийн зарчим бөгөөд энэ нь хотын төвд ирэх ачааллыг бууруулах, нийтийн үйлчилгээний хүртээмжийг тэгш хуваарилах, орон нутгийн эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэгдэж байна. Энэ бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд дэвшүүлсэн 24 томоохон төсөл нь хотын дэд бүтцийг шинэчлэх, холболтыг сайжруулах, амьдрах орчны чанарыг дээшлүүлэх юм. Энэ бүхэн нь Монголын ард түмний үнэт зүйлс, боломж, өвөрмөц онцлогийг илэрхийлэх нийслэл хотыг бий болгоно.

Хэлэлцүүлгийн зорилго

"Хот төлөвлөлт ба Хотжилт" сэдэвт хэлэлцүүлэг нь хот төлөвлөлт Монгол Улсын тогтвортой ирээдүйг тодорхойлох хөшүүргийг хэрхэн бүрдүүлэхийг нээн хэлэлцэх талбар болох юм. Энэхүү арга хэмжээнд хот байгуулалт, төлөвлөлтийн мэргэжилтнүүд, бодлого тодорхойлогчид, хувийн хэвшлийн төлөөлөл болон иргэний нийгмийн оролцогчид оролцож, "Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө-2040"-ийн хэрэгжилт, дэвшил, тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцэнэ. Хэлэлцүүлгийн гол сэдвийн нэг нь "20 минутын хот" хэмээх концепц бөгөөд энэ нь иргэд боловсрол, эрүүл мэнд, ажил эрхлэлт, амралт чөлөөт цаг зэрэг зайлшгүй үйлчилгээ, үйлчилгээнд 20 минутын дотор явган эсвэл дугуйгаар хүрэх боломжтой хотын загвар юм. Энэхүү хэтийн төлөв нь замын түгжрэлийг бууруулах, олон нийтийн эрүүл мэндийг сайжруулж, илүү хүртээмжтэй, эв нэгдэлтэй нийгмийг бүрдүүлэх боломжийг олгоно.

Мөн хэлэлцүүлгийн чухал нэг хэсэг нь боловсролын салбар дахь стратегийн хөрөнгө оруулалт бөгөөд энэ хүрээнд шинэ орон сууцны бүсүүдтэй уялдуулан сургууль, боловсролын төвүүдийг байгуулах, хүн амын өсөлттэй дүйцэх хэмжээний боловсролын дэд бүтцийг бий болгох асуудлыг онцолно. Мөн зөвхөн дэд бүтцээр хязгаарлалгүйгээр иргэдийн хотын соёл, төлөвлөлтийн талаарх мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх талаар ярилцаж, иргэдийн оролцоотой хөгжлийг дэмжих тухай ярилцах юм. Энэ утгаараа боловсролыг зөвхөн үйлчилгээ бус, тогтвортой, хүртээмжтэй хотын ирээдүйг бүтээх хүчирхэг хөдөлгөгч хүч болгоно.

Хүлээгдэж буй үр дүн

Энэхүү хэлэлцүүлгийн зорилго нь "Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө-2040"-ийн стратегийн зорилтууд үндэсний хөгжлийн зорилготой хэрхэн уялдаж буйг олон талт оролцогчдод ойлгуулж хамтын мэдлэг ойлголтыг бий болгоход оршино. Үүний хүрээнд "20 минутын хот" хэмээх дэлхийн шилдэг жишгийг Монголын нөхцөлд нийцүүлэн хэрхэн хэрэгжүүлэх боломжийн талаар үнэтэй туршлага, мэдлэгийг солилцох хүлээлттэй байна. Мөн хэлэлцүүлгээр хотын хөгжил, эдийн засгийн боломж, нийтийн үйлчилгээ, ялангуяа боловсролын салбар хоорондын уялдаа холбоог гүнзгийрүүлэн авч үзнэ. Салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих, санал солилцох энэхүү платформоор дамжуулан хэрэгжүүлэх бодитой стратеги, засаглалын арга замуудад санал нэгдэж, цаашид тогтвортой, хүртээмжтэй, уян хатан, ирээдүйг чиглэсэн нийслэл-ийг цогцлоох үндэс суурийг тавих юм. Энэ нь Монгол Улсын хөгжил дэвшил, иргэдийн сайн сайхан амьдралын баталгаа болох юм.

Plenary 2: URBAN TRANSFORMATION

Importance of the topic

Urban planning and urbanization are foundational to Mongolia's long-term development vision. As the country continues to urbanize rapidly, Ulaanbaatar has emerged as both the geographic and economic core of the nation, contributing a significant share of national GDP and hosting nearly half of the population. The city's ability to function efficiently, remain livable, and support future growth is directly tied to Mongolia's broader economic resilience, social cohesion, and environmental sustainability.

Central to this national transformation is the Ulaanbaatar Master Plan 2040, which outlines a vision for a smart, green, and citizen-centered capital city. This strategic framework not only addresses physical infrastructure but also lays the groundwork for economic diversification, social inclusion, and ecological stewardship. A key element of the plan is the emphasis on polycentric development—the creation of multiple urban hubs to ease pressure on the city center, distribute public services more evenly, and foster localized economic growth. This approach is further supported by the implementation of 24 mega projects, designed to modernize infrastructure, improve connectivity, and enhance urban livability. Together, these efforts aim to build a capital city that truly reflects the potential, identity, and values of the Mongolian people.

Purpose of discussion

The "Urban planning and Urbanisation" panel discussion serves as a platform to examine how urban planning can serve as a key driver of Mongolia's sustainable future. It will bring together urban development experts, policymakers, private sector leaders, and civil society actors to reflect on the progress and implementation of the Ulaanbaatar Master Plan 2040. One of the central themes to be explored is Mongolia's adoption of the "20-Minute City" concept—an urban model where essential services such as education, healthcare, employment, and recreation are accessible within a 20-minute walk or bicycle ride. This vision holds the promise of reducing congestion, enhancing public health, and building stronger, more inclusive communities.

Another critical focus of the panel is the strategic investment in education as part of urban planning. This includes the construction of schools and learning centers aligned with new residential zones, ensuring that educational infrastructure keeps pace with population growth. Beyond physical infrastructure, the panel will also explore the importance of cultivating civic awareness and urban

literacy—empowering citizens to actively participate in the planning and development of their communities. Through this lens, education becomes not only a public service, but a transformative force in shaping sustainable and inclusive urban futures.

Expected outcome from the discussion

With the aim to foster a deeper, collective understanding of the strategic priorities behind the Ulaanbaatar Master Plan 2040 and its alignment with national development goals. It is expected that participants will gain valuable insights into how Mongolia can effectively integrate the 20-Minute City concept into its urban planning framework, adapting global best practices to the local context.

Furthermore, the discussion will seek to reinforce the connection between urban development, economic opportunity, and public services—particularly education—as key pillars of a livable and equitable city. By encouraging dialogue and collaboration across sectors, the panel aspires to build consensus on actionable strategies for implementation and governance. Ultimately, the session will contribute to building a future-ready capital city—one that is efficient, inclusive, and resilient, and which serves as a dynamic engine for national prosperity and social well-being.



МОДЕРАТОР АМАРСАЙХАНЫ УНДРАЛ

Гүйцэтгэх захирал, ТэнГэр ТВ

Ажил хэрэгч мэдээ, мэдээллийн ТэнГэр ТВ-ийн Гүйцэтгэх захирал тэрээр бизнес, технологи, хувь хүний хөгжлийн чиглэлээр төрөлжсөн контент үйлдвэрлэгч Unread Media-г үүсгэн байгуулагчдын нэг. МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль, Бельгийн Льевений их сургуулийг дүүргэсэн. Дэлхийн Эдийн Засгийн Форумын дэргэдэх Глобал Шэйпэрс нийгэмлэгийн гишүүн бөгөөд байгууллагаа төлөөлөн 2017 оны Давосын чуулга уулзалтад оролцож байв.



MODERATOR

**UNDRAL
AMARSAIKHAN**

Chief Executive Officer, TenGer TV

Undral Amarsaikhan is the Chief Executive Officer of TenGer TV and co-founder of Unread Media, a hybrid media company focused on empowering the next generation through distinct storytelling and experiences. She holds degrees from KU Leuven in Belgium and the National University of Mongolia.

Undral is a member of Global Shapers Ulaanbaatar Hub, a youth initiative by the World Economic Forum. In 2017, she was selected to join the Annual Meeting of the World Economic Forum in Davos, Switzerland, as one of the 50 youth representatives from around the world.



ПАНЕЛИСТ

**ГАНЗОРИГИЙН
ЛУВСАНЖАМЦ**

Улсын Их Хурлын гишүүн

Г.Лувсанжамц нь архитектор, хот төлөвлөгч мэргэжилтэй бөгөөд Япон Улсын хот байгуулалтын зөвлөх үйлчилгээний компанид олон улсын төслүүдийг хариуцан ажиллаж байсан туршлагатай. Өнгөрсөн жил Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож, Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлын асуудлыг шийдэхээр хууль тогтоох түвшинд бодлогын шинэчлэлийг эхлүүлэн ажиллаж байна.

Нэг жилийн хугацаанд Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040-ийн ажлын хэсэгт ажиллаж, нийтийн тээвэрт суурилсан хот байгуулалт, 20 минутын хотыг бий болгох үзэл баримтлалыг боловсруулж дуусаад байна. Мөн нийслэл төдийгүй улсын хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах үндэсний дулаалгын бодлого, дулаалгыг эрчимжүүлэх хүртээмжтэй ногоон санхүүжилтын тогтолцоог бий болгох Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн чуулганд өргөн барьж батлуулсан.



PANELIST

LUVSANJAMTS GANZORIG

Member of the State Great Hural
(Parliament) of Mongolia

Luvsanjamts Ganzorig is an architect and urban planner by profession, with experience overseeing international projects at an urban development consulting company in Japan. Last year, he was elected as a Member of the State Great Hural and has since initiated policy reforms at the legislative level aimed at addressing traffic congestion and air pollution in Ulaanbaatar.

Within a year, he participated in the working group for Ulaanbaatar's General Development Plan 2040, completing the concept for transit-oriented urban development and establishing the vision for a "20-minute city." Furthermore, to reduce air pollution not only in the capital but nationwide, he submitted to the plenary session of Parliament a draft resolution to create a national insulation policy and an accessible green financing mechanism to accelerate insulation efforts — which was subsequently adopted.



ПАНЕЛИСТ

ХИШГЭЭГИЙН НЯМБААТАР

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын төлөөлөгч, Нийслэлийн Засаг
дарга бөгөөд Улаанбаатар хотын
захирагч

Х.Нямбаатар нь Орхон Их сургуульд багш, Монголын Өмгөөлөгчдийн холбоонд өмгөөлөгч, Сонгинохайрхан дүүрэгт хуулийн зөвлөх, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байсан.

Улсын Их Хурлын гишүүнээр 2016 оноос хойш хоёр удаа сонгогдсон. Хууль зүйн байнгын хорооны дарга, Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдаар ажиллаж байв. Тэрээр 2023 оноос Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаар сонгогдон ажиллаж байна. 2024 онд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөр сонгогдсон.

Х.Нямбаатар нь Орхон Их сургуулийн Эрх зүйч мэргэжлээр бакалавр, Боловсрол судлал мэргэжлээр магистр, Хууль Сахиулахын Их сургуулийн Цагдаагийн академийг Хууль зүйн ухаан магистр, Удирдлагын Академийн Төрийн удирдлагийн докторант, Хууль Сахиулахын Их сургуулийн Хууль зүйн ухааны докторант.



PANELIST

**NYAMBAATAR
KHISHGEE**

Member of the Citizens' Representatives Hural of the Capital City, Governor of the Capital City and Mayor of Ulaanbaatar

Nyambaatar Khishgee has extensive experience in law, local governance, and legislative leadership. From 2000 to 2007, he taught at Orkhon University, and between 2005 and 2009 worked as a lawyer with the Mongolian Bar Association. He then served as legal advisor (2009) and later as Head of the State Administration and Management Department (2009–2012) of Songinokhairkhan District. From 2012 to 2016, he was elected Chairman of the Citizens' Representatives Hural of Songinokhairkhan District.

Nyambaatar was elected three times as Member of the State Great Hural (Parliament) between 2016 and 2023, serving as Chair of the Standing Committee on Legal Affairs (2019–2020) and as Minister of Justice and Internal Affairs (2020–2023). In 2023, he was elected Governor of the Capital City and Mayor of Ulaanbaatar, and in 2024 also became a Member of the Citizens' Representatives Hural of the Capital City.

He holds a bachelor's degree in law and a master's in education from Orkhon University, as well as a master's in law from the Law Enforcement University's Police Academy. He holds a PhD in Public Administration at the Academy of Governance and in Law at the Law Enforcement University.



ПАНЕЛИСТ

**АЛЬБЕРТ ФРАНСИС
ПАРК**

Ерөнхий эдийн засагч,
Азийн Хөгжлийн Банк (ADB)

Альберт Ф. Парк нь Азийн Хөгжлийн Банкны Ерөнхий эдийн засагч, Эдийн засгийн судалгаа, хөгжлийн нөлөөллийн газрын Ерөнхий захирлаар ажилладаг. Тэрээр эдийн засаг, хөгжлийн чиг хандлагын талаар АХБ-ыг төлөөлөн байр суурийг илэрхийлж, гол судалгааны бүтээлүүд болон бүс нутгийн хамтын ажиллагааны санаачилгуудыг удирдан чиглүүлдэг.

Хөгжлийн эдийн засагчийн хувьд 20 гаруй жилийн ажлын туршлагатай бөгөөд Хятадын эдийн засгийн талаар өргөн хүрээнд судалсан хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч юм. Тэрээр ядуурал, тэгш бус байдал, бичил санхүү, хөдөлмөрийн зах зээл, гадаадын хөрөнгө оруулалт зэрэг олон асуудлаар бодлогын судалгааны ажил хийсэн.

Альберт Ф Парк нь Гонконгийн ШУТИС-ийн профессор бөгөөд шинээр гарч буй зах зээлийн судалгааны институт болон Эдийн засгийн бодлогын төвийг үүсгэн байгуулагч, захирал, Оксфордын болон Мичиганы Их сургуульд багшилж байжээ. Альберт Ф Парк нь Харвардын Их сургуулийн бакалавр, Стэнфордын Их сургуулийн эдийн засгийн доктор.



PANELIST

ALBERT FRANCIS PARK

Chief Economist,
Asian Development Bank (ADB)

Albert F. Park is Chief Economist of the Asian Development Bank and Director General of its Economic Research and Development Impact Department. He serves as the Bank's chief spokesperson on economic trends and development, guiding ADB's flagship publications and regional cooperation initiatives.

With over two decades of experience as a development economist, he is widely recognized for his expertise on China's economy and has contributed to policy on poverty, inequality, microfinance, labor markets, and foreign investment. Mr. Park was Chair Professor at HKUST, founding director of its Institute for Emerging Market Studies and Center for Economic Policy, and previously taught at Oxford and Michigan. A U.S. national, he holds a bachelor's degree from Harvard and a PhD from Stanford.



ПАНЕЛИСТ

ЭММА ТОМАС

Их Британийн экспортын даатгалын агентлаг (UKEF)-ийн Дэлхийн бизнесийн эх үүсвэрийг хамтран удирдагч, дарга

Эмма Томас нь Их Британийн экспортын даатгалын агентлаг болох UK Export Finance (UKEF)-ийн Дэлхийн бизнесийн эх үүсвэрийг хамтран удирдагч бөгөөд Америк, Африк, Зүүн Европ, Төв Азийн бүс нутгуудад шинэ бизнес хөгжүүлэлтийг удирдаж, 13 улсад Их Британийн Элчин сайдын яам, Дээд комиссын газарт байрлаж буй UKEF-ийн багийг хариуцан ажилладаг.

Өмнө нь тэрээр UKEF-д Корпорацийн стратеги ба нөлөөллийн хэлтсийн даргаар ажиллаж, стратегийн эрсдэлийн удирдлага, жилийн төлөвлөлт, мөн санхүүжилтийн эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх ажлыг удирдсан. Мөн Их Британийн Олон улсын худалдааны яаманд ажиллаж, Засгийн газрын нүүрсний болон бусад шатдаг түлшний төслүүдийг дэмжихийг зогсоох бодлогыг тэргүүлэн хэрэгжүүлсэн туршлагатай. Түүнчлэн Бизнес, Эрчим хүч, Аж үйлдвэрийн стратеги яам болон Шүүхийн яаманд бодлого боловсруулах чиглэлээр ажиллаж байжээ. Дэлхийн хөгжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллахдаа Сомали Улсад Их Британийн санхүүжилттэй хөтөлбөрүүдийг удирдаж, мөн Лаос Улсад олон улсын төрийн бус байгууллагад ажиллаж байсан.

Тэрээр SOAS-оос Хүний эрх, мөргөлдөөн ба хөгжлийн чиглэлээр магистр зэрэг хамгаалж, түүний судалгааны ажил нь Сомали дахь үйлчилгээний хүргэлт ба төрийн хууль ёсны байдлын асуудалд чиглэсэн байна.

Эмма Томас Лондонгийн Их Сургуулийн (UCL) Урлаг судлал ба Испани хэлний бакалавр.

2020 онд түүнийг McKinsey-ийн Ирээдүйн удирдагч эмэгтэйгээр тодруулж салбартаа манлайлан ажиллаж буйг нь үнэлсэн. Тэрбээр тогтвортой санхүүжилтийг ашиглан нийгмийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, бусдыг дэмжиж эерэг өөрчлөлт хийх урам зоригийг өгөх хүсэл эрмэлзэлтэй нэгэн юм.

2024 оны долдугаар сард Эмма Томас Уганда болон Гондурас улсад UKEF-ийн төлөөлөгчдийн багийг удирдан нисэх буудал, боомт, усан цахилгаан станц, эмнэлэг, метро зэрэг дэд бүтцийн төслүүдийн санхүүжилтийг судалж, хоёр улсад 2-5 тэрбум фунт стерлингийн санхүүгийн боломжуудыг эрэлхийлжээ. Эмма Томасын ажил нь төрийн өндөр түвшний бодлогыг боловсруулж хөгжлийн санхүүжилтийн бодит туршлагатай хослуулдаг бөгөөд тэрээр UKEF-ийн удирдах албаны гарамгай оновчтой шийдлүүдийг санаачилдаг байна.



PANELIST

EMMA THOMAS

Co-Head of Global Business Origination
at UK Export Finance (UKEF)

Emma Thomas is the Co-Head of Global Business Origination at UK Export Finance (UKEF), the UK's export credit agency. She leads new business development across the Americas, Africa, Eastern Europe, and Central Asia, managing a network of UKEF staff embedded in British Embassies and High Commissions in 13 countries.

Previously, she was Head of Corporate Strategy & Impact at UKEF, overseeing strategic risk management, annual planning, and leading initiatives to measure the impact of UKEF's financing across economic, social, and environmental dimensions. Emma has also worked at the Department for International Trade, playing a key role in leading policy to end UK government support for fossil fuel projects. She held policy roles at the Department for Business, Energy & Industrial Strategy and the Ministry of Justice. Additionally, she worked for a development consultancy managing UK-funded programs in Somalia and spent time living and working in Laos for an international NGO.

Emma holds an MSc in Violence, Conflict & Development from SOAS, where her thesis focused on service delivery and state legitimacy in Somalia. She also earned a BA in Art History & Spanish from University College London (UCL).

In 2020, she was recognized as a McKinsey Next Generation Woman Leader, reflecting her influence and leadership. Emma is known for her passion for addressing complex societal challenges through sustainable finance and empowering others to deliver positive change.

Most recently, in mid-July 2024, Emma led UKEF delegations to Guatemala and Honduras, working on financing infrastructure projects such as airports, ports, dams, hospitals, and metros, exploring financing capacities ranging from £2 to £5 billion in those countries.

Emma's career blends high-level government policy roles with hands-on development finance experience, bringing both analytical rigor and real-world impact to her leadership at UKEF.

Together
for tomorrow



ПАНЕЛИСТ

ПОЛ ДАЙСОН

Их Британийн Тээврийн яамны (DfT)
мэдлийн "Crossrail International"
компанийн Гүйцэтгэх захирал

Пол Даисон нь Их Британийн Тээврийн яамны (DfT) мэдлийн "Crossrail International" компанийн Гүйцэтгэх захирал бөгөөд тусгай зориулалтын тээврийн дэд бүтцийн зөвлөх үйлчилгээний байгууллагыг үүсгэн байгуулж, удирдан ажилладаг.

Тэрбээр 30 гаруй жилийн турш дэлхийн дэд бүтцийн салбарт ажилласан, иргэний барилгын олон улсын мэргэшсэн инженер ба Америк, Их Британи, Европ, Ойрхи Дорнод, Ази, Номхон далайн бүс нутагт олон талт оролцогчтой, томоохон дэд бүтцийн багц, хөтөлбөр, төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх, баталгаажуулах чиглэлээр туршлагатай. Сүүлийн жилүүдэд Пол Даисон нь баталгаажуулалт, байгууллагын бүтцийн шинэчлэл, төслийн удирдлагын алба (РМО), эрсдэл, гэрээний болон дижитал зөвлөх үйлчилгээний чиглэлээр дагнан ажиллаж байна. Crossrail International-д ажиллахаасаа өмнө НКА компанийн түнш, Дэлхийн зөвлөх хорооны гишүүн, Европын зөвлөх үйлчилгээ хариуцсан захирлаар ажиллаж байв. Мөн АЕСОМ компанид Хөтөлбөрийн зөвлөх үйлчилгээ хариуцсан захирал, Turner & Townsend компанид ажиллахдаа Лондонд дэд бүтцийн төслийн удирдлагын нэгжийг үүсгэн байгуулж, тус компанийн Их Британийн дэд бүтцийн зөвлөлийн гишүүнээр ажиллажээ.

Тэрээр карьерынхаа эхэнд Travers Morgan/Capita Symonds компанид ажиллаж, Малайз дахь ус хангамж, хөнгөн галт тэрэг (LRT) зэрэг томоохон дэд бүтцийн төслүүдэд оролцож, Их Британи, Европ, Өмнөд Африк дахь Хувийн хэвшлийн оролцоот төслүүдийн (PPP) санхүүжүүлэгч талуудад зөвлөх үйлчилгээ үзүүлж байв.

Пол Даисон нь Шеффилд Халламын Их Сургуулийг Иргэний барилгын инженерийн чиглэлээр дүүргэсэн бөгөөд Иргэний барилгын инженерүүдийн институтын гишүүн юм.

Together
for tomorrow



PANELIST

PAUL DYSON

Chief Executive Officer of Crossrail International, responsible to the company's shareholder, the UK Government's Department for Transport (DfT)

Paul Dyson is Chief Executive Officer of Crossrail International, responsible to the company's shareholder, the UK Government's Department for Transport (DfT), for the establishment and running of the specialist transport infrastructure advisory practice.

A chartered civil engineer with over 30 years of experience in global infrastructure, Paul has extensive experience in setting up, running and assuring large-scale, multi-stakeholder infrastructure portfolios, programmes and projects throughout the Americas, UK, Europe, Middle East, Asia and Oceania. More recently, Paul has specialised in providing assurance, transformational change, project management office (PMO), risk, commercial and digital consultancy services.

Prior to joining Crossrail International, Paul was Partner, Global Advisory Board Member and Head of Advisory, Europe for HKA. He also served as Director of Programme Advisory at AECOM, and spent nine years at Turner & Townsend where he established the company's infrastructure project management business in London and served on the company's UK Infrastructure Board.

Paul commenced his career at Travers Morgan/Capita Symonds, where he undertook a wide variety of consultancy roles in the infrastructure sector from large-scale water supply and light rail transit (LRT) systems in Malaysia, to advisory roles to funders for PPP deals in the UK, Europe and South Africa.

Paul holds a BEng (with commendation) in Civil Engineering from Sheffield Hallam University and is a Member of the Institution of Civil Engineers.

Салбар хуралдаан 4:

ТЭЭВЭР ЛОГИСТИКИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Сэдвийг онцлохын ач холбогдол

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050", дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр "Шинэ сэргэлтийн бодлого", Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зам, тээврийн салбар нь хөгжлийн тэргүүлэх салбаруудын нэг бөгөөд эдийн засгийн өсөлтийг дэмжигч, хөгжлийг хурдасгагч, бүс нутгийн интеграцид холбогч салбар мөн болохыг тодотгосон. Монгол Улс Ази, Европыг холбосон газар зүйн давуу талаа ашиглан тээвэр, худалдаа, үйлчилгээний зангилаа "Транзит Улс" болох зорилтыг тавьж, бүс нутгийн хамтын ажиллагааны үйл ажиллагаанд нэгдэж, идэвхтэй оролцогч байхыг эрмэлзэж байна. Иймд бүс нутгийн интеграцид тодорхой хувь нэмэр оруулахуйц, транзит тээвэр, логикийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг хэрэгжүүлэн ажиллах нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чухал ач холбогдолтой юм.

Хэлэлцүүлгийн зорилго

"Тээвэр логикийн хөрөнгө оруулалт" сэдэвт хуралдааны зорилго нь тээвэр, логикийн салбарт тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хөгжлийн хязгаарлагдмал байдал, эрсдэлийг бууруулах боломж, шийдвэрлэх арга замыг хэлэлцэж, салбарын хөгжилд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх боломжийг эрэлхийлэхэд чиглэнэ.

Монгол Улс өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн ам цөөнтэй, зах зээл жижигтэй, суурин газрууд алслагдмал тархан суурьшсан нь тээвэр, логистикийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг үлэмж нэмэгдүүлдэг, эрс тэрс уур амьсгал нь дэд бүтцийн засвар арчлалтын зардлыг ихээр шаарддаг зэргээр тээвэр, логистикийн хөгжил өндөр орнуудтай харьцуулахад ялгаатай, хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах чадвар сул байдаг. Гэхдээ тээвэр, логистикийн салбар нь бүс нутгийн интеграцид нэгдсэнээр эдийн засгийн өндөр үр ашигтайгаар өргөжин тэлэх бүрэн боломжтой юм. Энэхүү хуралдаанаар тээвэр, логистикийн олон улсын холболт, түүнд чиглэсэн бодлогын зорилго, зорилт, томоохон бүтээн байгуулалтын төслүүдийн талаар мэдээлэл өгч, хамтын ажиллагааны боломжуудыг нээлттэй хэлэлцэх юм.

Хүлээгдэж буй үр дүн

Монгол Улсын тээвэр, логистикийн салбарт хэрэгжүүлэхээр зорьж буй бодлого, бүтээн байгуулалтын төслүүд нь бүс нутгийн зах зээлд чиглэсэн, эдийн засгийн үр ашиг өндөр байх боломжийн талаар тодорхой ойлголт, мэдээллийг өгнө.

Sub-session 1:

REGIONAL DEVELOPMENT AND INVESTMENT IN TRANSPORTATION AND LOGISTICS

Importance of the topic

The long-term development policy of Mongolia, "Vision-2050," the medium-term development program "New Revival Policy," and the Government of Mongolia's Action Plan for 2024-2028 highlight the transport sector as one of the priority sectors for development, emphasizing its role in supporting economic growth, accelerating development, and connecting regional integration. Leveraging the geographical advantage of connecting Asia and Europe, the country aims to become a "Transit Country," a hub for transport, trade, and services, and actively participate in regional cooperation mechanisms.

Therefore, it is crucial to implement large-scale projects aimed at enhancing transit transport and logistics capacity, which will significantly contribute to economic growth, increase trade, and attract investment.

Purpose of discussion

The purpose of the panel discussion on the topic "Investment in Transport and Connectivity" is to identify the key issues in the transport and logistics sector, discuss opportunities for reducing development limitations and risks, and explore solutions to address these challenges. The conference will also focus on increasing both domestic and foreign investment in the sector, as well as seeking opportunities to introduce new forms of investment.

Mongolia, with its vast territory, small population, limited market, and dispersed settlements, faces significant challenges in increasing investments in transport and logistics infrastructure. The harsh climate also requires high maintenance and repair costs for infrastructure. As a result, compared to developed countries, the transport and logistics sector in Mongolia has distinct differences and struggles to attract the interest of investors. However, the sector has great potential to expand with high economic efficiency through regional integration. This conference will provide information on international transport and logistics connectivity, policy objectives and goals in this area, and major infrastructure projects, while also facilitating open discussions on cooperation opportunities.

Expected outcome from the discussion

One of the primary outcomes of the panel discussion is to provide investors with a clear and comprehensive understanding of Mongolia's transport and logistics policies and infrastructure projects currently under consideration. These initiatives are strategically oriented toward regional markets and offer strong potential for economic returns. The panel discussion aims to present a unified perspective to stakeholders seeking investment opportunities.



МОДЕРАТОР ДЭМБЭРЭЛИЙН ИРМҮҮН

Ерөнхий сайдын Зөвлөх асан

Д.Ирмүүн нь Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөхөөр ажиллаж байсан. Тэрээр яамд, төрийн агентлагууд болон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд нийт 14 жилийн турш төрийн албан тушаал хашиж ирсэн туршлагатай.

Тэрээр "Эрдэнэс Оюу Толгой" компанийн гүйцэтгэх захирлын зөвлөх, Гадаадын хөрөнгө оруулалт, худалдааны агентлагийн дэд дарга, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хятад дахь төслийн ахлах, Сангийн яамны шинжээчээр ажиллаж байсан.



MODERATOR

IRMUUN DEMBEREL

Former Economic Policy Adviser to the
Prime Minister of Mongolia

Irmuun Demberel, has served as an Economic policy adviser to the Prime Minister of Mongolia.

He has been holding public servants post for 14 years in various ministries and government agencies and state owned enterprises in Mongolia.

He served as an Adviser to the CEO of Erdenes Oyu Tolgoi, Deputy Director of Foreign investment and trade agency, Senior programme officer at the United Nations China and specialist in the Ministry of Finance.



ПАНЕЛИСТ

ХҮРЭЛБААТАРЫН БУЛГАНТУЯА

Улсын Их Хурлын дэд дарга

Х.Булгантуяа Улсын Их Хурлын дэд дарга, Монгол Улсын Их Хурлын гишүүн юм. Тэрээр Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороог даргалж байгаа ба УИХ дахь МАН-ын бүлгийн дэд даргаар ажиллаж байсан. УИХ-ын гишүүнээр сонгогдохоосоо өмнө 2016-2020 онд Монгол Улсын Сангийн дэд сайд, 2013-2016 онд Монгол Ардын Намын намын бүтэц, олон улсын харилцаа, төрийн бус байгууллагуудыг хариуцсан нарийн бичгийн даргаар ажиллаж байсан. Мөн Дэлхийн банкны санхүүжилттэй хөгжиж буй улсуудад хэрэгжүүлж буй төсвийн санхүүгийн удирдлагыг дээшлүүлэх төслүүдэд төслийн зөвлөх төслийн удирдагч (Зүүн Тимор, Палестинд), Оюутолгой ХХК-ийн төслийн менежер, Бизнес стратегийн ахлах зөвлөх, Петровис ХХК-ийн Бизнес хөгжлийн хэлтсийн даргаар тус тус ажиллаж байсан. Австралид ахлах сургуулиа төгсөөд БНХАУ-ын Дундад Хятадын Шинжлэх Ухааны Их Сургуульд Эдийн засгийн бакалавр, АНУ-ын Йелийн их сургуульд Олон улсын эдийн засаг, хөгжлийн эдийн засгийн магистрын зэргийг хамгаалсан. Хүрэлбаатарын Булгантуяа нь Монгол Ардын Намын Удирдах зөвлөлийн гишүүн ба эмэгтэйчүүд, залуучуудын олон байгууллагын гишүүн, удирдлагаар ажилладаг.




PANELIST

**BULGANTUYA
KHURELBAATAR**

The State Great Khural (Parliament) of
Mongolia

Bulgantuya Khurelbaatar is a Deputy Chairwoman and Member of the State Great Hural (Parliament) of Mongolia. She was elected into the State Great Hural in 2020 and was a Deputy Chairwoman of the Mongolian People's Party Caucus of the Parliament. Bulgantuya Khurelbaatar served as a Minister of Labour and Social Protection and Minister of Mongolia, and Chair of the National Commission of Border Port Recovery and Vice Minister of Finance of Mongolia. Prior to joining Ministry of Finance, she served as a Secretary of Mongolian People's Party in charge of party structure, international relations and non-government institutions. She has worked in the private sector as Director of the Business Development Department of Petrovis LLC, Project Manager and Commercial Principal Advisor at Oyu Tolgoi LLC. She has worked internationally as a public financial management consultant. She obtained a B.A in Economics from Huazhong University of Science and Technology, PRC and an M.A in International and Development Economics from Yale University, USA. Bulgantuya Khurelbaatar serves as an Executive board member of the Mongolian People's Party and President of the Social Democratic Women's Union of Mongolia, the women's organisation of the Mongolian People's Party.



ПАНЕЛИСТ

**САЙНБУЯНГИЙН
АМАРСАЙХАН**

Улсын Их Хурлын гишүүн,
Шадар сайд

С.Амарсайхан нь Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Монгол Улсаас БНХАУ-д суугаа Элчин сайдын яамны консулын ажилтан, атташегаар ажилласан туршлагатай. Мөн Монгол Улсын Шинжлэх ухаан, мэдээлэл технологийн төвийн ажилтан, Америкийн Худалдаа хөгжлийн компанид гадаад худалдааны менежер, Оюуны ундраа группийн ерөнхийлөгч, төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байсан. АНУ-ын Калифорни мужийн Престо хотын институт, Саут-вест / Southwest/ их сургуульд хуулийн магистрын зэргийг хамгаалсан.

Шадар сайдын хувиар тэрээр тогтвортой хөгжлийн шийдэл болсон бүсчилсэн хөгжлийн бодлого, Евроазийн эдийн засгийн коридорын нэг тулгуур болсон эдийн засгийн тусгай бүсүүд, чөлөөт бүсүүдийн хөгжил, хөдөө аж ахуйн салбарын шинэ шатны реформ, үндэсний ондоошил болон уламжлалыг хадгалах "Шинэ хоршоо"-ны тогтолцоо, Стандарт хэмжил зүйн шинэтгэл, Үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг бэхүүлэх хүрээнд Онцгой байдлын байгууллагын чадавхыг бэхжүүлэх асуудлуудыг үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэл, бодлого болгон хэрэгжүүлж ирсэн. Мөн тэрээр "Бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо", "Шинэ хоршоо", "Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хороо"-ны даргаар ажиллаж байна



PANELIST

AMARSAIKHAN SAINBUYAN

Deputy Prime Minister, Member of the
State Great Hural (Parliament) of
Mongolia

Amarsaikhan Sainbuyan is a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia, a Member of the Government, and the Deputy Prime Minister of Mongolia. He has accumulated extensive professional experience in both public administration and international diplomacy. His previous positions include Chairman and Member of the Citizens' Representative Hural of the Capital City, Governor of the Capital City, and Mayor of Ulaanbaatar. He has also served as Consular Officer and Attaché at the Embassy of Mongolia in the People's Republic of China.

In addition, Amarsaikhan has held key roles in the private sector, including as an employee of the National Center for Science and Technology of Mongolia, Foreign Trade Manager at the American Trade and Development Company, President, and Chairman of the Board of Directors of Oyun Undraa Group.

He obtained his master's degree in law from Southwest University and Preston Institute in the State of California, United States. He is proficient in English, Chinese, and Russian. As Deputy Prime Minister, Amarsaikhan has prioritized the advancement of sustainable development policies, particularly through the implementation of regional development strategies. His efforts focus on the development of special economic zones and free zones that serve as pivotal hubs within the Eurasian Economic Corridor, comprehensive reforms in the agricultural sector, preservation and promotion of national identity and cultural heritage through the "New Cooperative" system, and modernization of the national standards and metrology framework. Furthermore, he has actively contributed to enhancing the national disaster resilience capacity by strengthening the institutional capabilities of emergency management organizations.

Currently, he serves as the Chairperson of the National Committee for Regional Development, the New Cooperative Initiative, and the National Committee on Climate Change.

*Together
for tomorrow*



ПАНЕЛИСТ

САНДАГДОРЖИЙН БАТБОЛД

Зам Тээврийн Төрийн нарийн
бичгийн дарга

Зам, тээврийн Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нь Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Хяналт шалгалтын хэлтсийн дарга, Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Тээврийн үйлчилгээний төвийн Хяналт шалгалтын албаны даргаар ажилласан туршлагатай. Мөн Зам, тээврийн яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын Ахлах мэргэжилтэн, "ПОК" ХХК-ийн Замын хөдөлгөөний дүрмийн багш, "СКА" ХХ-ийн захирлаар ажиллаж байсан.

Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр техникийн хяналтын үзлэг оношлогооны төв байгуулах төслийг хэрэгжүүлсэн, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулж "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөл", Нэгдсэн үндэсний байгууллагын Ази Номхон далайн нийгэм эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хүрээнд замын хөдөлгөөний аюулгүй байдлын "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажигчлагч байгууллага"-ыг байгуулах санаачлагыг гаргасан.

Автотээврийн болон агаарын харилцааны олон улсын харилцааг өргөжүүлэхэд анхаарч автотээврийн харилцааны хэлэлцээрийг 17 улстай, агаарын харилцааны хэлэлцээрийг 49 улстай байгуулаад байна. Энэ хүрээнд монголын тээвэрчид 2017 оны байдлаар олон улсын авто тээвэрлэлтэд 1 хувьтай оролцож байсан бол одоогоор 40 хувьд хүрээд байна.

*Together
for tomorrow*



PANELIST

BATBOLD SANDAGDORJ

State Secretary at Ministry of Road and Transport

State Secretary of the Ministry of Road and Transport, S. Batbold, has experience serving as the Head of the Road Transport Policy Implementation and Coordination Department at the Ministry of Road and Transport, Head of the Inspection Division at the Road Transport Agency (a government implementing agency), and Head of the Inspection Department at the Transport Service Center of the Ministry of Road, Transport, and Tourism. He has also worked as a Senior Specialist at the Strategic Policy and Planning Department of the Ministry of Road and Transport, a traffic rules instructor at "POK" LLC, and Director of "SKA" LLC.

He implemented a project to establish a technical inspection and diagnostics center aimed at improving road traffic safety in Mongolia, and organized efforts to enhance the legal framework for road traffic safety. He initiated the establishment of the "National Council for Road Traffic Safety" and the "Road Traffic Safety Observer Organization" within the framework of the United Nations Economic and Social Commission for Asia and the Pacific (UN ESCAP).

He has worked to expand international relations in both road and air transport, concluding road transport agreements with 17 countries and air transport agreements with 49 countries. As a result, Mongolian transport operators, who accounted for only 1% of international road transport in 2017, now account for 40%.



ПАНЕЛИСТ

БИЛЛИ КЬЮЛИ

StoneX Group Inc-ийн Азийг хариуцсан зээлийн хэлтсийн захирал

Билли Кьюли нь санхүүгийн үйлчилгээний салбарт арвин туршлагатай, 10 гаруй жил хөрөнгийн зах зээл болон хөгжиж буй зах зээлд төвлөрөн ажилласан. Тэрээр Bank of America Merrill Lynch-д ажлын гараагаа эхлүүлж Лондонд Mitsubishi UFJ Trust International-д арилжааны болон байгууллагын хөрөнгө оруулагчидтай харилцаа хөгжүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг удирдаж байсан. Сингапурт шилжин суурьшсаны дараа Mitsubishi UFJ-д ажиллаж, улмаар StoneX компанид удирдах албан тушаал хашиж, хөрөнгийн зах зээлд мөн дэд бүтэц болон хөрөнгө босголтын төслүүдийг удирдан ажилласан.

Nasdaq-д бүртгэлтэй, Fortune 500-ийн жагсаалтад 2023 онд 59-д эрэмбэлэгдсэн StoneX компанийн Азийг хариуцсан зээлийн хэлтсийн захирал Билли нь Ази, Номхон далайн бүс нутгийн санхүүгийн үйл ажиллагаа болон стратегийг удирдан чиглүүлж байна.



PANELIST

BILLY KEWLEY

Head of Asia Credit at StoneX Group Inc., to its Board of Directors for the 2025 term.

Billy Kewley is a seasoned financial services professional with a decade of experience, primarily focused in capital and emerging markets. He began his career at Bank of America Merrill Lynch before joining Mitsubishi UFJ Trust International in London, where he played a key role in trading operations and institutional client engagement. After relocating to Singapore, he worked at Mitsubishi UFJ and later moved into a leadership role at StoneX, focusing on capital markets while also being involved in infrastructure and capital raising projects.

As Head of Asia Credit at StoneX, a Nasdaq-listed Fortune 500 company ranked No. 59 in 2023, Billy oversees financial operations and strategy in the Asia-Pacific region.



ПАНЕЛИСТ

ЖЕЙКОБ ПУТЕНПАРАМБИЛ

Үүсгэн байгуулагч,
Гүйцэтгэх захирал, Redhill

Жейкоб Путенпарамбил нь харилцаа холбооны сүлжээ байгууллага болох Redhill компанийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирал бөгөөд 20 гаруй жилийн туршлагатай нийтлэлч, зохиолч, энтрепренер юм. Тэрээр Сингапур дахь төв оффис болон Солонгос, Малайз, Индонез, Австрали, Тайланд, Энэтхэг, Хятад, Япон, Вьетнам, Филиппин, Шри Ланка, Камбож зэрэг 18 улсад байрлах 21 салбарын 150 гаруй мэргэжилтнийг удирддаг. Тус компани нь Дубай, Эстони, Малайз зэрэг улсын Засгийн газруудтай хөрөнгө оруулалтын чиглэлээр хамтран ажиллаж байсан.

Redhill-ийг үүсгэн байгуулахаас өмнө тэрээр MUrgency болон Burson-Marsteller Middle East компанид ажиллаж байсан бөгөөд "du" сэтгүүлийн ерөнхий редактор, "LinuxWorld" болон "NetworkWorld" сэтгүүлийн редактор, "Gulf Business" сэтгүүлийн орлогч эрхлэгчээр ажиллаж байв.

Тэрээр Лондонгийн Middlesex University-ийн Харилцаа холбооны магистр, London School of Economics-ийн ОУХ-ны бакалавр, Делигийн St. Stephen's College-ийн Эдийн засгийн бакалавр.



PANELIST

**JACOB
PUTHENPARAMBIL**

Founder & CEO, Redhill

Jacob Puthenparambil is the founder and CEO of Redhill, a regional communications network headquartered in Singapore. A communications expert, author, and serial entrepreneur, Jacob leads a team of over 150 professionals across 18 countries and 21 cities in Asia-Pacific, the Middle East, Europe, and the US. Redhill has successfully supported investment promotion initiatives for various governments including Dubai, Estonia, and Malaysia.

Prior to founding Redhill, Jacob held senior roles at MUrgency and Burson-Marsteller, and served as Editor in Chief of du magazine. He holds an MA in Communications from Middlesex University, a BSc in International Relations from LSE, and a BA in Economics from St. Stephen's College.



ПАНЕЛИСТ

**ГЭРЭЛТИЙН
ТЭЛМЭН**

Гүйцэтгэх захирал,
Монгол Шуудан ХК

Г.Тэлмэн нь Монгол Шуудан ХК-ийн гүйцэтгэх захирал бөгөөд 2025 оноос Монгол Улсын Их Хурлаас Монголбанк (Төв банк)-ны Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилогдсон.

Монгол Шуудангийн гүйцэтгэх захирлаар ажиллахаасаа өмнө тэрээр санхүү, технологийн салбарт хэд хэдэн албан тушаал хашиж байсан. Тэрээр Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Дэд Ерөнхийлөгч бөгөөд Ард Кредит ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байв. Мөн 2016-2020 онд Монгол Шуудангийн дэд захирал, түүнээс өмнө 2014-2016 онд мэдээллийн технологи, цахим худалдаа, хүргэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг МЕС Partners LLC-ийн хамтран үүсгэн байгуулагч, үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажилласан туршлагатай.

Г.Тэлмэн нь Монголын финтекийн холбоо, Улаанбаатар хотын Худалдааны танхим, Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж, санхүү, бизнесийн салбарын хөгжилд чухал хувь нэмэр оруулж байсан.

Тэрээр БНСУ-ын SungKyunKwan Их сургуулийн Бизнесийн сургуулиас удирдлагын ухааны магистрын зэрэг, Монгол Улсын Их сургуулийн Олон улсын харилцааны сургуулиас олон улсын эдийн засгийн харилцааны бакалаврын зэрэг тус тус хамгаалсан.



PANELIST

TELMEN GERELT

Chief Executive Officer of
Mongol Post JSC

Telmen Gerelt is the Chief Executive Officer of Mongol Post JSC, and he was appointed as a member of the Supervisory Board of the Bank of Mongolia (Central Bank) by the Mongolian Parliament on 16 January 2025.

Before taking on the role of CEO at Mongol Post, Telmen held several prominent positions in both the financial and technology sectors. He was a Senior Executive at Ard Financial Group, where he served as the Vice President of Ard Financial Group JSC and the CEO of Ard Credit N BFI JSC. His earlier leadership experience includes being the Deputy CEO of Mongol Post JSC from 2016 to 2020 and the Co-Founder and Chief Operating Officer (COO) of MEC Partners LLC from 2014 to 2016, a company specializing in IT, E-Commerce, and Delivery.

Telmen's career also includes significant experience in the corporation, having held management positions with international corporations in Mongolia and South Korea (Republic of Korea).

In addition to his executive roles, he has contributed significantly to the development of Mongolia's financial and business sectors. He has served as a Board Member of the Mongolian Fintech Association, Ulaanbaatar City Chamber of Commerce, and the Mongolian Non-Bank Financial Institutions' Association.

Telmen is highly educated, holding a Master of Science in Management from the Business School of SungKyunKwan University in South Korea. He is also a graduate of the National University of Mongolia, where he earned his bachelor's degree in International Economic Relations from the School of Foreign Services.

Салбар хуралдаан 5:

УРТ ХУГАЦААНЫ БАЯЛГИЙН УДИРДЛАГА

Сэдвийг онцлохын ач холбогдол

Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээх чухал ач холбогдолтой юм. Монгол Улс газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг төвлөрүүлэх, үр ашигтай хөрөнгө оруулалт хийх боломж бүрдэж Монгол Улсын иргэн бүр баялгийн үр өгөөжийг тэгш шударга хүртэх боломжийг эхлүүлсэн тул энэхүү хэлэлцүүлэг нь цаг үеэ олсон чухал арга хэмжээ болж байна.

Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд уул уурхайн олборлолт, ашигт малтмалын боловсруулах салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгаас 499.5 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр баталсан бөгөөд 2024 оны гүйцэтгэлээр Хуримтлалын сангийн Монгол банк дахь төрийн сангийн дансанд 495.6 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Сангийн орлого жил бүр нэмэгдэж, 2030 он гэхэд сангийн нийт хөрөнгө 3.0 их наяд төгрөгт хүрэх төсөөлөл байна.

Монгол банкнаас 2024 онд ипотекийн зээлийн санхүүжилтэд 1,208.0 тэрбум төгрөгийг банкнуудад олгосон бөгөөд энэхүү санхүүжилтийн 39.8 хувийг Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгө эзэлж байна. Энэ хүрээнд нийт 10,422 иргэн, үүнээс Хуримтлалын сангийн эх үүсвэрээр 4,183 иргэн (нийслэлд 2,099, орон нутагт 2,084 иргэн) ипотекийн зээлд хамрагдсан. Ингэснээр иргэдийн зээлийн хүсэлтийг шийдвэрлэх хугацаа 3-6 сараар наашилж, ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо нэмэгдсэн зэрэг эерэг үр дүнгүүд гарч эхэлсэн.

Түүнчлэн Хуримтлалын сангийн мөнгөн хөрөнгийг Монгол банк дахь дансанд байрших хугацаанд бодлогын хүүгээр, хөтөлбөрийн хүрээнд хөрөнгө оруулснаас хойш хугацаанд хөрөнгө оруулалтын хүүгээр тус тус тооцож, 2024 онд хүүгийн орлогод 4.9 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд төвлөрүүлсэн байна.

Үндэсний баялгийн сангийн 2025 оны төсвийн тухай хуулиар Хуримтлалын санд 507.1 тэрбум төгрөг, хүүгийн орлогоор 55.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр, Хуримтлалын сангийн хөрөнгийг санхүү, хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах замаар арвижуулах хэмжээг 562.1 тэрбум төгрөг байхаар тус тус хуульчилсан нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 12 орчим хувиар өссөн байна.

Хэлэлцүүлгийн зорилго

Үндэсний баялгийн сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор хуримтлуулах, хуримтлагдсан хөрөнгийг олон улсын зах зээлийн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар өнөөгийн үнэ цэнийг өсгөх, арвижуулах зориулалт бүхий төрөлжсөн гурван сантай.

Хуримтлалын сан нь газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо үеийн Монгол Улсын иргэн бүрд тэгш, шударга хүртээх зорилгоор иргэний эрүүл мэнд, боловсрол, орон сууцны зориулалтаар дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий сан юм.

Иргэн бүр эрүүл мэндийн үйлчилгээнд хүртээмжтэй хамрагдаж, чанартай боловсрол эзэмшиж, орон сууц худалдан авах санхүүгийн эх үүсвэртэй болсноор өөрийн болон гэр бүлийн ирээдүйгээ өөрчлөх, цаашлаад эх орныхоо хөгжилд чухал хувь нэмэр оруулах суурь болох тул Монгол Улсын Засгийн газраас тус сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, арвижуулах нь чухал байна.

Хүлээгдэж буй үр дүн

Сангийн хөрөнгийн удирдлагын зорилго нь Санд газрын хэвлийн баялгийн үр өгөөжөөс хуримтлагдсан хөрөнгийг хөрөнгө оруулалт хийх замаар үнэ цэнийг хадгалах, арвижуулахад оршино. Тус хэлэлцүүлгээр цаашид дараах шийдлүүдийг тодорхойлохыг зорино. Үүнд: Төрөлжсөн сангуудын бодлогыг уялдуулж, хэрэгжилтийг хангахад мэргэжлийн дэмжлэг үзүүлэхэд анхаарах.

Хуримтлалын сангийн хөрөнгийг оновчтой, зохистой хөрөнгө оруулалтад оруулах, өгөөжийг иргэдэд хүртээмжтэй зарцуулахад анхаарах.

Үндэсний баялгийн сангийн талаарх ойлголтыг иргэдэд сурталчлан таниулах.

Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлж, засаглалын зохистой зарчмуудыг нэвтрүүлэх.

Төрөлжсөн сангуудын хөрөнгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх зэрэг болно.

Sub-Session 2:

LONG-TERM WEALTH MANAGEMENT

Importance of the topic

The state policy for the use of natural resources is based on a long-term development policy, ensuring the right of every citizen of the present and future generations to live in a healthy and safe environment, and distributing the benefits of subsoil resources equally and fairly in the National Resources Fund. This discussion is a timely and important event, as Mongolia has begun to concentrate the benefits of subsoil resources and make efficient investments, allowing every citizen of Mongolia to enjoy the benefits of resources equally and fairly.

The 2024 Budget Law of the National Wealth Fund approved the allocation of 499.5 billion tugriks from dividends of state-owned and state-owned legal entities in the mining and mineral processing sectors to the Provident Fund, and as of 2024, 495.6 billion tugriks were concentrated in the Provident Fund's treasury account at the Bank of Mongolia. The fund's income is expected to increase annually, and the fund's total assets are expected to reach 3.0 trillion tugriks by 2030.

The Bank of Mongolia allocated 1,208.0 billion tugriks to banks for mortgage loan financing in 2024, and 39.8 percent of this financing was provided by the Provident Fund. Within this framework, a total of 10,422 citizens, of which 4,183 citizens (2,099 in the capital and 2,084 citizens in rural areas) received mortgage loans through the Provident Fund. This has led to positive results, such as faster processing times for citizens' loan applications and an increase in the number of citizens receiving mortgage loans.

In addition, the provident fund's cash is calculated as policy interest during the period it is held in the account at the Bank of Mongolia and as investment interest during the period after it is invested within the program, and in 2024, 4.9 billion tugriks in interest income was deposited into the provident fund.

The 2025 National Wealth Fund Budget Law legislated the allocation of 507.1 billion tugriks to the Provident Fund, 55.0 billion tugriks from interest income, and the amount of enrichment of the Provident Fund through investment in financial and investment instruments to be 562.1 billion tugriks, an increase of about 12 percent compared to the previous year's performance.

Purpose of discussion

The National Wealth Fund has three specialized funds, each of which is intended to accumulate the benefits of subsoil resources in order to ensure equal and fair distribution of benefits to all future citizens, to increase and enrich the current value by investing the accumulated funds in international market financial instruments.

The Provident Fund is a fund designed to provide support for citizens' health, education, and housing in order to ensure equal and fair distribution of benefits of subsoil resources to all current citizens of Mongolia.

It is important for the Government of Mongolia to increase and enrich the assets of the Fund, as it will provide every citizen with access to health services, quality education, and financial resources to purchase housing, which will change the future of themselves and their families, and further contribute significantly to the development of their country.

Expected outcome from the discussion

The purpose of this discussion is to preserve and enhance the value of the assets accumulated from the benefits of subsoil resources by investing them. The following solutions will be identified in the future through the discussion. These include:

Focus on coordinating the policies of diversified funds and providing professional support for their implementation.

Focus on investing the assets of the savings fund in rational and appropriate ways and spending the returns in a way that is accessible to citizens.

Promote and familiarize citizens with the concept of the National Wealth Fund.

Initiate cooperation with international organizations and introduce good governance principles.

Implement integrated management of the assets of diversified funds, etc.



МОДЕРАТОР ГАНБОЛДЫН БАЙГАЛЬ

"Ийгл Ньюс" ТВ-ийн тоймч.

Тэрээр сэтгүүлзүйн салбарт 10 гаруй жил ажилласан туршлагатай, бизнес, эдийн засаг, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн. Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй. Г.Байгаль нь дата өгөгдөлд тулгуурлан эдийн засгийн мэдээллийг үзэгчдэд энгийн, ойлгомжтой хүргэж, зан төлөвийн эдийн засаг, тайлбарлалт сэтгүүлзүй зэрэг төрлөөр мэдээлэл бэлтгэдэг.

Тэрээр "Ийгл Ньюс" ТВ-д эдийн засгийн тойм бэлтгэхийн зэрэгцээ "Үндэсний тойм" сэтгүүл, "Ийгл FM 91.1" радиод контент нийлүүлдэг. Монголын эдийн засгийн сэтгүүлчдийн клубын гишүүн.



MODERATOR

**BAIGAL
GANBOLD**

Commentator, Eagle News TV

Baigal Ganbold is a commentator at Eagle News TV with over 10 years of experience in journalism, specializing in business, economics, and finance. She holds a master's degree in business administration. Baigal is known for delivering economic information to viewers in a clear and accessible way by leveraging data-driven analysis, and she regularly produces content in areas such as behavioral economics and explanatory journalism.

In addition to preparing economic commentaries for Eagle News TV, she contributes content to Undesnii Toim magazine and Eagle FM 91.1 radio. She is also a member of the Mongolian Economic Journalists' Club.



ПАНЕЛИСТ

**САНДАГИЙН
БЯМБАЦОГТ**

Улсын Их Хурлын гишүүн, Монгол
Улсын сайд бөгөөд Засгийн Газрын
Хэрэг Эрхлэх газрын дарга

С.Бямбацогт нь Засгийн газрын залгамж чанарыг алдагдуулахгүй хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг үнэлэх, дүгнэх, сайжруулах ажлыг үргэлжлүүлэн, энэ хүрээнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. Тэрээр Улсын Их Хурлын гишүүнээр 2008 оноос хойш 5 удаа улиран сонгогдсон даацтай, иргэдийн итгэл даасан улс төрч. Улсын Их Хурлын гишүүнээр ажиллаж байх хугацаандаа Монгол Улсын Засгийн газрын гишүүн, сайдаар 4 дэх удаагаа томилогдон ажиллаж байгаа бөгөөд өмнө нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Зам тээврийн хөгжлийн сайд, Батлан хамгаалахын сайдаар тус тус ажиллаж байсан. С.Бямбацогт нь Санхүү Эдийн Засгийн дээд сургууль, Нидерланд Улсын Маастрихтын Их сургуулийг эдийн засагч мэргэжлээр, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн эдийн засаг, эрх зүйн өргөн мэдлэгтэй төрийн түшээ юм.



PANELIST

BYAMBATSOGT SANDAG

Member of the State Great Hural
(Parliament) of Mongolia, Minister of
Mongolia and Chief Cabinet Secretary

Byambatsogt Sandag is currently focused on ensuring policy continuity in government, evaluating, improving, and upholding decisions without disruption. In this capacity, he places special emphasis on implementing the Law on the National Wealth Fund.

Byambatsogt is a seasoned and trusted politician, elected five consecutive times as a Member of the State Great Hural since 2008. Over his parliamentary career, he has been appointed as a member of the Government and Minister of Mongolia for the fourth time. Previously, he served as Minister of Justice and Internal Affairs, Minister of Road and Transport Development, and Minister of Defense.

He holds degrees in economics from the Institute of Finance and Economics and Maastricht University in the Netherlands, as well as a law degree from the School of Law at the National University of Mongolia, bringing a broad background in both economics and law to his work in public service.



ПАНЕЛИСТ

ТИЛЕУХАНЫ АУБАКИР

Улсын Их Хурлын гишүүн, Гэр бүл,
Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайд

Т.Аубакир нь 2000-2005 онд Сэлэнгэ аймгийн "Сэлэнгэ тариа" ХХК-ийн дэд захирал, 2006-2015 онд "Тариан цацал" ХХК-ийн захирал, 2015-2016 онд Гаалийн ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газрын дарга, 2017-2019 онд Гаалийн ерөнхий газрын харьяа Буянт-Ухаа дахь гаалийн газрын орлогч даргаар тус тус ажиллаж байна.

2008-2015 онд Баян-Өлгий аймгийн НАМЗХ-ны даргаар, 2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр хоёр дахь удаагаа сонгогдоод байна. 2025 оноос Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын сайдаар томилогдон ажиллаж байна.

Тэрээр "Отгонтэнгэр" дээд сургуулийг олон улсын эрх зүйч мэргэжлээр төгссөн.



PANELIST

AUBAKIR TILEUKHAN

Minister of Family, Labour and Social Protection, Member of the State Great Hural (Parliament) of Mongolia

Aubakir Tileukhan began his career as Deputy Director of Selenge Taria LLC in Selenge province from 2000 to 2005, later serving as Director of Tarian Tsatsal LLC from 2006 to 2015. From 2015 to 2016, he was Director of Internal Audit and Monitoring at the General Customs Administration, and from 2017 to 2019, served as Deputy Head of Buyant-Ukhua Customs Office under the same agency.

He led the Bayn-Ulgii branch of the Social Democratic Youth Union from 2008 to 2015, and since 2020 has been elected twice as a Member of the State Great Hural (Parliament). In 2025, he was appointed Minister of Family, Labour and Social Protection.

Aubakir graduated from Otgontenger University with a degree in International Law.



ПАНЕЛИСТ

ВИСЕНТЕ ПОНС

Frontera Capital Group-ийн
Гүйцэтгэх захирал, хувь эзэмшигч

Висенте Понс 2004 оноос хойш Африкийн улс орнуудын санхүүгийн зах зээлд төвлөрөн ажиллаж ирсэн. Тэрээр АНУ-ын Йэлийн Их сургуульд санхүүгийн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан. Citigroup-д, Африкийн үндэсний валют болон зээлийн деривативын арилжааны ширээг байгуулж, 4.5 тэрбум ам.доллар хүртэлх портфолио сантай болж тухайн үед салбартаа хамгийн том Африкийн үндэсний валютын багц болж байжээ. Мөн 2007 онд Renaissance Capital-д Африкийн тогтмол орлогын арилжааг хариуцсан дарга, 2008 онд Exotix Limited-д эх үүсвэр болон бүтэцлэлийн газрын дарга, 2011-2014 онд Ecobank-ийн Валют ба Африкийн хөрөнгийн хуваарилалтын ширээний (CAAD) даргаар ажиллаж байв.



PANELIST

VINCENTE PONS

Managing Director and Shareholder of
Frontera Capital Group

Vicente has focused on African financial markets since 2004. After completing his PhD in Finance at Yale, Vicente joined Citigroup, where he set up the Africa local currency and credit derivatives desk. He grew the Desk's portfolio to being the largest Africa local currency book on the Street with assets of c. USD 4.5 billion. Vicente also worked at Renaissance Capital in 2007 as head of fixed income trading for Africa, Exotix Limited as head of origination and structuring in 2008 and as head of Ecobank's Currency & African Asset Distribution (CAAD) desk from 2011-2014.



ПАНЕЛИСТ

БАЯРААГИЙН ТЭМҮҮЛЭН

Чингис хаан Үндэсний баялгийн сан
Гүйцэтгэх захирал

Монголын Бизнесийн Зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүн, банк, санхүү, төслийн удирдлага, төр-хувийн хэвшлийн түншлэл, цахим хөгжил, өгөгдөл шинжилгээний чиглэлээр ажилласан туршлагатай. Тэрээр 2022–2025 онд Монгол Улсын Олон улс дахь мэдээлэл, сурталчилгааны Үндэсний хорооны Ажлын албаны дарга, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Дэлхийн банкны "Ухаалаг засаглал II" төслийн зөвлөхөөр ажилласан. 2024 оноос Монголын Бизнесийн Зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байна. Сингапурын Үндэсний Их Сургуулийн Нийтийн бодлогын магистрын зэрэгтэй (Төгсөгчдийн төлөөлөгч, Деканы манлайлын шагналт). Монгол Улсын Их Сургуулийн Олон улсын харилцааны сургуулийг төгссөн.



PANELIST

TEMUULEN BAYARAA

Chief Executive Officer, Chinggis Khaan
National Wealth Fund

Temuulen Bayaraa serves as Chief Executive Officer of the Chinggis Khaan National Wealth Fund and is a Board Member of the Business Council of Mongolia. He brings experience across banking, finance, project management, public-private partnerships, digital development, and data analytics.

From 2022 to 2025, he was Head of the Secretariat for Mongolia's National Committee on International Promotion and Information, an Advisor to the Minister of Digital Development and Communications, and a consultant for the World Bank's "Smart Governance II" project. Since 2024, he has served on the Board of the Business Council of Mongolia.

Temuulen holds a Master's in Public Policy from the National University of Singapore, where he was elected class representative and awarded the Dean's Leadership Award. He earned his undergraduate degree from the School of International Relations at the National University of Mongolia.



ПАНЕЛИСТ

ШОН МА

GTN группийн Хойд Азийг хариуцсан
Борлуулалтын захирал

Шон Ма нь GTN группийн Хойд Азийг хариуцсан Борлуулалтын захирлаар ажиллаж, бүс нутагт бизнесийн үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Тэрээр хөрөнгө оруулалтын болон хөрөнгийн удирдлагын зах зээлийн байгууллагуудад чиглэсэн GTN-ийн цогц үйлчилгээ, технологийн шийдлийг хүргэх ажлыг удирдан явуулдаг.

Энэ нь Хойд Азийн санхүүгийн дэд бүтцийг сайжруулж, хөрөнгө удирдлагын болон wealth-tech салбарын шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэхэд түлхэц болж байна.

Шон нь Saxo Bank группийн бүрэлдэхүүнд багтдаг Saxo Institutional-ийн Их Хятадыг хариуцсан захирлаар ажиллаж, стратеги, түншлэлийн төслүүдийг удирдаж байсан. Мөн Fuji Commodities Hong Kong компанид Гүйцэтгэх захирал, JS Financial (HK)-д Ерөнхий менежерээр ажиллаж байсан туршлагатай бөгөөд арилжаа, эрсдэлийн удирдлага, зөвлөх үйлчилгээний чиглэлээр арвин туршлагатай.

Шон Ма нь Хонг Конгийн Сити Их Сургуулийн Бизнесийн удирдлагын магистр, БНХАУ-ын Норт Их Сургуулийн Эдийн засгийн бакалаврын зэрэгтэй.



PANELIST

**SEAN
MA**

Head of Sales, North Asia, GTN Group

Sean Ma serves as Head of Sales for North Asia at GTN Group, where he leads business expansion efforts across the region. In this role, he drives the delivery of GTN's comprehensive one-stop solutions to both buy-side and sell-side institutions, with a strong focus on the wealth management and wealth-tech sectors. His work contributes to strengthening financial infrastructure and advancing innovative investment services in North Asia's dynamic markets.

Prior to joining GTN, Sean was Head of Greater China at Saxo Institutional, part of the Saxo Bank Group, where he oversaw strategic growth initiatives and partnerships. He also held leadership roles as Managing Director at Fuji Commodities Hong Kong and General Manager at JS Financial (HK), gaining extensive experience in trading, risk management, and client advisory.

Sean holds an MBA from the City University of Hong Kong and a Bachelor's degree in Economics from North University of China. Through his leadership across major financial institutions, Sean continues to promote robust financial ecosystems and enable institutional clients to navigate evolving market landscapes.

Салбар хуралдаан 6:

ШИНЭ БОЛОМЖ БА ЭРСДЭЛ: БЛОКЧЕЙН БА ХИЙМЭЛ ОЮУН УХААН

Сэдвийг онцлохын ач холбогдол

Сүүлийн жилүүдэд технологийн дэвшил асар хурдацтай явагдсанаар виртуал хөрөнгийн зах зээл тэлж, улс орнуудын санхүүгийн салбарт нөлөөлөх боллоо. Тодруулбал, PayPal, Visa зэрэг компаниуд криптовалютыг дэмжсэнээр гадаад гүйлгээний зардлыг 40–70%-иар бууруулж, хэрэглэгчдэд үр ашигтай сонголтыг бий болгож байна. Мөн криптовалют нь банкны үйлчилгээ хүртээмжгүй бүс нутаг, иргэдэд данс нээх, мөнгөн гүйлгээ хийх, хөрөнгө хадгалах зэрэг үндсэн санхүүгийн үйлчилгээг хялбаршуулж, 24/7 нээлттэй, ил тод, зардал багатай шинэ боломжийг нээж байна. Цаашлаад криптовалютыг уламжлалт санхүүгийн системтэй уялдуулан хөгжүүлэх шинэ санаачлагууд ч гарч эхлээд байна.

Гэвч криптовалют нь төвлөрсөн бус бүтэцтэй, нууцлал өндөр тул мөнгө угаах, татвараас зайлсхийх, кибер халдлага зэрэг гэмт хэрэгт ашиглагдах эрсдэлийг нэмэгдүүлдэг. Криптовалютын үнийн огцом хэлбэлздэг байдал нь зах зээлийг зориудаар удирдах, хөөсрөлт үүсгэх аюултай юм. Түүнчлэн, криптовалютын хэрэглээ өсөх нь Төв банкны бодлогын хүү, мөнгөний бодлогын шилжих суваг, үр нөлөөг бууруулах эрсдэлийг дагуулдаг тул олон улсын төв банкууд төв банкны цахим мөнгө гаргах талаар идэвхтэй судалж байна.

Харин Монгол Улсын хувьд, 2021 оноос Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг баталж, олон улсын ФАТФ-ын зөвлөмжид нийцүүлэн крипто орчныг зохицуулах алхмыг хийсэн хэдий ч зохицуулалтгүй олон тооны дотоодын койнуудын үнэ 90 гаруй хувиар унаж, 2024 оны байдлаар 578 сая ам.доллар буюу гадаад валютын албан нөөцийн 10%-тай тэнцэхүйц, сүүлийн дөрвөн жилийн хугацаанд нийт 1,325 сая ам.долларыг криптовалюттай холбоотой гадагш шилжүүлэг хийгдсэн нь эрсдэлийг бодитоор илэрхийлж байна. Энэ нөхцөлд бодлого боловсруулалт, олон нийтэд зөв ойлголт өгөх зорилгоор энэ сэдвийг онцлон авч хэлэлцэх нь улс орны эдийн засгийн аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, хариуцлагатай инновацийн хөгжлийг хангахад чухал хувь нэмэр оруулах юм.

Хэлэлцүүлгийн зорилго

Хэлэлцүүлгийн гол зорилго нь криптовалютын өнөөгийн нөхцөл байдлыг хэлэлцэж, Монгол Улсын критовалютаас хүртэх үр өгөөж, түүнийг хэрэгжүүлэх боломж, учирч болох эрсдэлийг тодорхойлоход оршино. Энэ хүрээнд дараах сэдвийн дагуу хэлэлцүүлэг өрнөх юм. Үүнд: Криптовалютаас хүртэх үр өгөөж, эрсдэл: Дэлхийн улс орнууд криптовалютыг ашигласнаар иргэдийн санхүүгийн хүртээмж сайжрах, мөнгөн гүйвүүлгын үйлчилгээг зардал багатай, түргэн

шуурхай болгох, ил тод байдал дээшлэх зэрэг үр өгөөжтэй хэдий ч нөгөөтээгүүр криптовалютын үнийн хэлбэлзэл маш өндөр бөгөөд эрчим хүч ихээр шаарддагаас зарим бүс нутагт эрчим хүчний хязгаарлалт хийгдэх, тасалдал үүсэхэд хүргэж байна.

Монгол Улсын криптовалютаас хүртэх үр өгөөж, эрсдэл: Монгол Улс нь хүйтэн уур амьсгал, өргөн уудам газар нутагтай бөгөөд үүнийгээ ашиглан өгөгдлийн төвийн аюулгүй бүсүүдийг байгуулах боломжтой. Ингэснээр олон улсын олборлолтын компаниудын анхааралд орж, хөрөнгө оруулалт татах боломж үүсэх ач холбогдолтой хэдий ч нөгөө талаас, эрчим хүчний сорилттой нүүр тулаад буй манай улсын эрчим хүчний салбарын дарамтыг нэмэгдүүлэх магадлалтай.

Монгол Улс дахь криптовалютын эрх зүйн зохицуулалт: Криптовалютын гол онцлог нь төвлөрсөн бүс шинж чанар бөгөөд аливаа улсын засгийн газар, төв банкны хяналтгүйгээр гүйлгээ хийгдэх боломжтой байдаг. Үүнээс шалтгаалан мөнгө угаах, цахим гэмт хэрэг гэх мэт эрсдэлүүд үүсдэг байна.

Санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх криптовалютын нөлөө: Аливаа төв банк криптовалютын хэрэглээнд нөлөөлөх боломжгүй тул криптовалютын хэрэглээ нэмэгдэхэд тухайн улсын мөнгөний бодлогын хэрэгжилт саарч, үр нөлөө буурах эрсдэлтэй байдаг.

Төв банкны цахим мөнгө (CBDC): Төв банкууд криптовалютын технологид суурилсан шинэ төрлийн цахим мөнгийг судалж, өөрсдийн төвлөрсөн CBDC-ийг гаргах талаар идэвхтэй судалж байна. Одоогоор хамгийн өргөн хүрээг хамарсан CBDC нь БНХАУ-ын e-CNY бөгөөд АНУ болон Европын Төв Банкууд нь гүйлгээний үр ашиг, мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор туршилтыг үргэлжлүүлж байна.

Хүлээгдэж буй үр дүн

Б.Мөнгөнхишиг нь одоогоор IBF болон DT Global ХХК-ийн консорциумын Багийн ахлагчаар ажиллаж байна. Үүнээс өмнө тэрээр "Пипл ин Нийд" (ПИН) ОУТББ-ын Монгол дахь Суурин төлөөлөгчөөр ажиллаж, улс даяарх хөгжлийн болон яаралтай тусламжийн хөтөлбөрүүдийг удирдаж байсан. ПИН-д ажиллахаасаа өмнө Бангкок хот дахь НҮБ-ын Хүүхдийн Сангийн Зүүн Ази, Номхон далайн бүсийн төлөөлөгчийн газарт Боловсрол болон уур амьсгалын асуудлаар бүс нутгийн 27 улсыг хамарсан 13 салбарыг дэмжин Мэдлэгийн менежментийн мэргэжилтнээр ажиллаж байв. Мөн тэрээр НҮБ-ын Хүүхдийн Сангийн Монгол дахь салбарт 5 гаруй жил Мэдлэгийн менежментийн ажилтан, зөвлөхөөр ажилласан. Түүний ажлын туршлага нь мөн Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн яам, Азийн хөгжлийн банк (ADB), Сайн дурын үйлчилгээний байгууллага (VSO), болон RTI International зэрэг олон улсын байгууллагуудыг хамардаг. Азийн болон Номхон далайн бүс нутагт олон улсын хамтын ажиллагаа, тогтвортой хөгжил, засгийн газрын төлөөлөл, олон талт түншлэлүүдийг уялдуулах чиглэлээр 15 гаруй жилийн туршлагатай.

Б.Мөнгөнхишиг нь Швейцарийн Женев хот дахь Олон улсын харилцаа, хөгжлийн эрдмийн сургуулийн Хөгжлийн бодлого, практикийн чиглэлийн магистр, Филиппиний Лос Банос хот дахь Филиппиний Их Сургуулийн Хөгжлийн мэдээлэл харилцааны бакалавр.

*Together
for tomorrow*



MODERATOR

MUNGUNKHISHIG BATBAATAR

Team Leader, IBF and DT Global LLC
Consortium

Mungunkhishig Batbaatar currently serves as the Team Leader for the consortium of IBF and DT Global LLCs. Prior to this, he was the Country Director for People in Need (PIN) Mongolia, where he led development and emergency response programming across the country. Before joining PIN, Mr. Batbaatar worked as a Knowledge Management Specialist at UNICEF's East Asia and Pacific Regional Office in Bangkok, supporting 13 Country Offices in 27 countries on education and climate initiatives. He also served over five years with UNICEF Mongolia as a Knowledge Management Officer and consultant. His earlier career includes roles at the National Center for Public Health, the Ministry of Health of Mongolia, and international organizations such as the Asian Development Bank (ADB), Voluntary Service Overseas (VSO), and RTI International.

Batbaatar holds an MSc in Development Policies and Practices from the Graduate Institute in Geneva, Switzerland, and a BS in Development Communication from the University of the Philippines Los Baños. He brings over 15 years of experience in sustainable development, international cooperation, government liaison, and multi-stakeholder engagement across Asia and the Pacific.



ПАНЕЛИСТ

БАТТОГТОХЫН ЧОЙЖИЛСҮРЭН

Улсын Их Хурлын гишүүн,
Эрчим Хүчний сайд

Б.Чойжилсүрэн нь Сангийн сайд, Төсвийн байнгын хорооны дарга, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргаар тус тус ажиллаж байсан.

“СП-КАМАН” Орос-Монголын хамтарсан компанийн захирал, “Хурд групп” ХХК үүсгэн байгуулагч юм. ОХУ-ын Екатеринбург хотын Уралын Политехникийн Дээд сургуулийг Автоматикч-телемеханикч инженерийн мэргэжлээр төгссөн.



PANELIST

CHOIJILSUREN BATTOGTOKH

Minister of Energy, Member of the State
Great Hural (Parliament) of Mongolia

Choijilsuren Battogtokh is currently serving as Minister of Energy and a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia. He previously held key positions as Minister of Finance, Chairman of the Standing Committee on Budget, and Chairman of the Standing Committee on Industrial Policy. In the private sector, he founded Khurd Group LLC and served as Director of SP-KAMAN, a Russian-Mongolian joint venture. Choijilsuren holds a degree in Automation and Telemechanics Engineering from Ural Polytechnic Institute in Yekaterinburg, Russia.



ПАНЕЛИСТ

МӨНХЧУЛУУНЫ ЭНХЦЭЦЭГ

Улсын Их Хурлын гишүүн

М.Энхцэцэг нь 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон. Тэрээр эрчим хүчний салбарт 24 жил ажилласан туршлагатай. Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ компаний хэд хэдэн салбарт 14 жил ажилласан, сүүлийн 4 жил Австрали улсын эрчим хүчний зөвлөх үйлчилгээний компанид инженер, ахлах инженерээр ажиллаж байсан туршлагатай. Эрчим хүчний салбарт ажилласан туршлагаараа өдгөө Монголын эрчим хүчний хуулиудыг шинэчлэх Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байна. М.Энхцэцэг нь Австрали улсын RMIT Их сургуулийг цахилгааны инженерийн магистр, эрчим хүчний тогтворжилтоор доктор зэрэгтэй төгссөн.



PANELIST

**ENKHTSETSEG
MUNKHCHULUUN**

Member of the State Great Hural
(Parliament) of Mongolia

Enkhtsetseg Munkhchuluun has been serving as a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia since 2024. She has 24 years of experience in the energy sector, including 14 years in various divisions of the National Power Transmission Grid Company of Mongolia. For the past four years, she worked in Australia as an engineer and senior engineer at an energy consulting firm.

Drawing on her extensive background in the energy sector, she currently serves as the head of the parliamentary working group established to revise Mongolia's energy laws. Enkhtsetseg holds a master's degree in electrical engineering and a doctorate in energy stability from RMIT University in Australia.



ПАНЕЛИСТ

**МАТЬЮ
ЛЕ БЛАН**

ОУСК -ийн Монгол дахь Суурин
төлөөлөгч (Олон улсын санхүүгийн
корпорац, Дэлхийн Банк групп)

Матью Ле Блан нь Төв Европ, Кавказ, Төв Азийн улсууд болон Монголд хувийн хэвшил, дэд бүтцийн хөгжлийн санхүүжилтийн чиглэлээр 25 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр 2001 онд Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны Тогтвортой дэд бүтцийн багийн гишүүн болж, 2017 он хүртэл төрөл бүрийн албан тушаал хаших хугацаандаа Тбилисийн нисэх онгоцны буудлын концессын гэрээ, мөн Гүрж, Армени, Монгол улсуудад усан болон салхин цахилгаан станц зэрэг олон төслийг боловсруулж хэрэгжүүлсэн. 2007 онд тэрээр ЕСБХБ-ны Тажикистан дахь Суурин төлөөлөгчөөр томилогдож, дараа нь Узбекистанд энэ албыг үргэлжлүүлэн хашсан. 2011 онд ЕСБХБ-ын Төв Ази болон Монголыг хариуцсан бүсийн төвийг Истанбул хотод үүсгэн байгуулсан. 2013 онд ЕСБХБ-ны Монгол дахь Суурин төлөөлөгчөөр томилогдож, тус улсад ажиллах хугацаандаа томоохон хөрөнгө оруулалтын багцыг удирдсан бөгөөд стратегийн ач холбогдол бүхий Оюу Толгой төслийг ОУСК-тай хамтран санхүүжүүлсэн.

2017 онд Матью Ле Блан Монголын хамгийн том салхин цахилгаан станцын ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон. Тэрээр сүүлд Дэлхийн ногоон өсөлтийн олон улсын хүрээлэн (GGGI)-гийн Монгол дахь Суурин төлөөлөгчөөр ажиллаж, нарны халаалт болон эрчим хүчний хэмнэлттэй төслүүдийг хөгжүүлэн хэрэгжүүлсэн. Дэлхийн ногоон өсөлтийн олон улсын хүрээлэнд орохоосоо өмнө Матъё Ле Блан НҮБ-ын Төслийн үйлчилгээний алба (UNOPS)-нд Төв Азийг хариуцсан Түншлэлийн ахлах зөвлөхөөр ажиллаж байсан.

Тэрээр Парисын Улс төрийн шинжлэх ухааны хүрээлэн (Sciences Po Paris)-ийн эдийн засаг болон төрийн удирдлагын магистрын зэрэгтэй.



PANELIST

MATTHIEU LE BLAN

Resident Representative for IFC in Mongolia (International Finance Corporation of the World Bank Group)

Matthieu Le Blan has over 25 years of experience in private sector and infrastructure development financing across Central Europe, the Caucasus, Central Asia and Mongolia. Le Blan joined the EBRD Sustainable Infrastructure team in 2001, and held various positions until 2017, where he developed projects such as the BOT Tbilisi airport, hydro and wind power projects in Georgia, Armenia and Mongolia.

In 2007, he became EBRD Country Representative in Tajikistan, and then in Uzbekistan. He developed the EBRD Hub for Central Asia and Mongolia based in Istanbul in 2011. In 2013, he was appointed EBRD Country Representative in Mongolia. There, he managed a large portfolio, including the Oyu Tolgoi landmark project co-financed with the IFC.

In 2017, Le Blan became Board Director of the largest Wind Farm of the country. He recently worked for the Global Green Growth Institute as Country Representative in Mongolia, developing solar heating and energy efficiency projects. Prior to joining GGGI, he worked in UNOPS as Senior Partnerships Advisor for Central Asia.

He holds a master's degree in economy and public management from Sciences-Po Paris.



ПАНЕЛИСТ

БОЛДБААТАРЫН БААТАРМӨНХ

Ньюком (Newcom) группийн Гүйцэтгэх захирал

Б.Баатармөнх нь эрчим хүч, дэд бүтцийн тэргүүлэх компани болох Ньюком группийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тэрээр Монгол, АНУ, Япон, Сингапур зэрэг улсуудад 20 гаруй жил олон улсын багуудыг удирдан ажилласан туршлагатай.

Ньюком групп нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлт, бүс нутгийн эрчим хүчний экспорт, ногоон шилжилт, тогтвортой эрчим хүчний шийдлүүдийг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Б.Баатармөнх нь мэргэшсэн нисгэгч бөгөөд АНУ-ын Баруун Мичиганы Их сургуулийг Нисэхийн Шинжлэх Ухааны бакалавр, Бизнесийн удирдлагын магистрын зэргийг тус тус дүүргэсэн.



PANELIST
**БААТАРМУНКХ
БОЛДБААТАР**

Chief Executive Officer of Newcom Group

Baatarmunkh Boldbaatar is Chief Executive Officer of Newcom Group, a leading energy and infrastructure company in Mongolia. With over 20 years of experience managing international teams across Mongolia, the United States, Japan, and Singapore, he brings extensive expertise to driving the group's mission. Newcom plays a key role in supporting Mongolia's sustainable economic growth, advancing regional energy exports, and developing green transition and sustainable energy solutions.

Baatarmunkh is a certified pilot and holds a Bachelor's degree in Aviation Science and a Master's in Business Administration from Western Michigan University, USA.



ПАНЕЛИСТ
**ХАННЕС А.
ТАКАЧ**

Европын Сэргээн Босголт Хөгжлийн
Банкны Монгол дахь суурин төлөөлөгч
(EBRD)

Ханнес Такач нь 2020 оноос хойш Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны (ЕСБХБ) Монгол дахь үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг удирдан ажиллаж байна. ЕСБХБ нь уул уурхайгаас бусад салбарт үйл ажиллагаа явуулдаг хамгийн том гадаадын хөрөнгө оруулалтын байгууллага бөгөөд нийт Монгол Улсад 2.4 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.

Мөн тэрээр Лондонд дотоодын валют ба хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх санаачилгын хүрээнд 38 орныг хамарсан багийг удирдаж байсан.



PANELIST

**HANNES A.
TAKACS**

Head of European Bank for
Reconstruction and Development
Mongolia (EBRD)

Hannes Takacs has served as Head of EBRD Mongolia since 2020, overseeing the Bank's operations and investments in the country. The EBRD is the largest non-mining private sector investor in Mongolia with total investments of USD 2.45 billion.

Before his assignment in Mongolia, he led the Bank's equity and capital markets infrastructure team in London, working across 38 countries under EBRD's Local Currency and Capital Markets Development initiative.

Салбар хуралдаан

ДИЖИТАЛ ЭРИН: ХИЙМЭЛ ОЮУН УХААН БА ДАТА ДЭД БҮТЭЦ

Сэдвийг онцлохын ач холбогдол

Монгол Улс дижитал шилжилтийг эрчимжүүлэх, хиймэл оюун (AI) болон дата дэд бүтцийн хөгжлийг урагшлуулах стратегийн зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Хурдтай хөгжиж буй технологийн шинэ эрин үед дата аюулгүй байдал, дата төвүүдийн хүртээмжтэй байдал, үндэсний хэмжээний тоон экосистемийг бий болгох асуудал тулгамдсан хэвээр байна. AI хөгжүүлэлт, дата удирдлага нь төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хууль эрх зүйн зохицуулалт, хүний нөөцийн чадавх зэрэг олон хүчин зүйлд түшиглэнэ. Иймд энэ сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлэх нь Монгол Улсыг бүс нутгийн дата хаб болгох урт хугацааны зорилгод том түлхэцийг өгөх юм.

Хэлэлцүүлгийн зорилго

Энэхүү хэлэлцүүлгийн зорилго нь үндэсний хэмжээнд дата дэд бүтцийг хөгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, шийдлийг тодорхойлж, хиймэл оюун ухааны хэрэглээ, дата эдийн засгийн үнэ цэнийг бодит жишээгээр харуулах, хүний нөөцийн чадавхыг хөгжүүлэх бодлогыг уялдуулах, хөрөнгө оруулалт, олон улсын түншлэлд итгэл төрүүлэх, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах санал, шийдлийг нэгтгэхэд оршино.

Хүлээгдэж буй үр дүн

Монгол Улсын дата дэд бүтэц, хиймэл оюун ухааны хөгжлийн одоогийн нөхцөл байдлыг бодитоор үнэлж, цаашдын бодлогын уялдааг сайжруулах.

Хиймэл оюун ухаан ба том дата ашиглалтыг өргөжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн болон техникийн зохицуулалтын саналуудыг нэгтгэх.

Хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд бэлтгэх, чадавхжуулах шаардлага, арга замыг тодорхойлж санал дэвшүүлэх.

Хөрөнгө оруулагч, технологийн түншүүдтэй хамтран ажиллах боломжийг тодорхойлох.

Монгол Улсыг дата дэд бүтцийн бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх боломжийг оролцогч талуудад ойлгуулах.

Sub-Session

DIGITAL AGE: AI & DATA INFRASTRUCTURE

Importance of the topic

Mongolia is at a critical turning point to accelerate its digital transformation by advancing artificial intelligence (AI) and modernizing national data infrastructure. In today's fast-evolving technological landscape, issues such as data security, availability of data centers, and building a robust nationwide digital ecosystem remain pressing. The development and use of AI depend not only on technical capacity but also on clear legal frameworks, strong public-private partnerships, and skilled human resources. A focused discussion on this topic will help define how Mongolia can position itself as a regional data hub and unlock the value of a data-driven economy.

Purpose of discussion

The purpose of this panel discussion is to identify key challenges and practical solutions for strengthening Mongolia's data infrastructure and promoting the use of artificial intelligence. It aims to highlight the economic and social value of data, align policies to develop a digitally capable workforce, and build trust among investors and international partners. The discussion will also seek concrete ideas to enhance collaboration between the government and the private sector to unlock Mongolia's potential in the digital era.

Expected outcome from the discussion

Provide a realistic assessment of Mongolia's current AI and data infrastructure landscape and identify policy gaps.

Consolidate proposals for necessary legal and technical regulations to expand the use of AI and big data.

Define concrete directions to develop human resource capacity to international standards, ensuring a skilled workforce for the digital economy.

Identify opportunities to attract investment and foster partnerships with technology leaders.

Build a shared understanding among stakeholders on how Mongolia can become a regional hub for data infrastructure and AI-driven innovation.

*Together
for tomorrow*



МОДЕРАТОР ВАНЧИГИЙН ГАНЗОРИГ

Бат Солжуншн Партнерсын
УЗ-ийн дарга

В.Ганзориг нь стратеги ба олон нийтийн харилцааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Бат Солжуншн Партнерс брэндинг агентлаг, зөвлөх компанийн үүсгэн байгуулагч бөгөөд өмнө нь банк санхүү, хэвлэл мэдээлэл, олон талт үйл ажиллагаа явуулдаг Монголын тэргүүлэх групп компаниудад удирдах ажил эрхэлж байсан. Тэрбээр цахим бизнес болон бизнесийн удирдлагын чиглэлээр мастерийн зэргүүдээ Австрали болон Япон улсуудад хамгаалсан. Түүнийг 2014 онд Дэлхийн эдийн засгийн форумаас Дэлхийн залуу манлайлагчаар шалгаруулсан. Жил бүр дэлхийн шилдэг багшийг шалгаруулан 1 сая ам.доллараар шагнадаг Global Teach Prize байгууллагын академийн гишүүн, шүүгчээр ажилладаг.

2017 оноос хойш CEO клуб, МҮХАҮТ зэрэг Монголын тэргүүлэх компаниудын гишүүнчлэлтэй олон нийтийн байгууллагуудын тэргүүн, дэд тэргүүнээр сонгогдон ажиллаж байсан туршлагатай бөгөөд хувийн хэвшлийн эрх ашгийг хамгаалах, төр ба олон нийтийн байгууллага хооронд гүүр болох, олон нийттэй харилцах ажлуудыг хийж байв. Тэрбээр Монголын Тусгай Олимпын хорооны удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд Ази, номхон далайн дауны холбооны удирдах хороонд ажилладаг бөгөөд Монголын дауны холбоо болон Тусгай олимпын хороог үүсгэн байгуулагч.

Одоогоос 10 жилийн өмнө Монголын хамгийн анхны менторшип хөтөлбөр болох Young Professionals' Group-ийг үүсгэн байгуулсан бөгөөд залуучуудад хөрөнгө оруулах, тэднийг туршлагатай хүмүүстэй холбох замаар ирээдүйн карьер төлөвлөлт, академик төлөвлөгөөг нь амжилттай хэрэгжүүлэхэд туслах зорилготой ажилладаг. Хэвлэл мэдээллийн салбарт идэвхтэй ажиллахын сацуу Syndicate Talk нэвтрүүлгийн хөтөлгөч бөгөөд шилдэг нийтлэлчдийн клубын гишүүн бөгөөд НҮБ-ын Нью Йорк, Женев хотууд дахь төв оффис болон Парис хотноо байрлах ЮНЕСКО-гийн төвд продюсерээр нь ажилласан ТРИО киног толилуулж, хүний эрх, дауны хам шинж, хүртээмжтэй нийгмийн асуудлыг хөндөн гаргасан олон улсын цуврал хэлэлцүүлгийг өндөр түвшинд амжилттай зохион байгуулсан туршлагатай.

*Together
for tomorrow*



МОДЕРАТОР GANZORIG VANCHIG

Chairman, Bat Solution Partners

Ganzorig Vanchig is a founder of Bat Solution Partners, a strategy and communications business consulting firm and the nation's leading branding agency. Prior to Bat Solution Partners, Ganzorig held leadership positions in media and financial groups of companies. He earned his Masters' degrees in E- Business and business administration in Australia and Japan. Ganzorig was selected as a Young Global Leader, Class of 2014, by the World Economic Forum. He serves as an academy member of the Global Teacher Prize which is an annual award presented by the Varkey Foundation, in collaboration with UNESCO and Dubai Cares. The prize includes a \$1 million award and aims to highlight the importance of educators and their impact on students and communities.

Since 2017, he had held the position of President of the CEO Club Mongolia as well as Vice President of the Mongolian National Chamber of Commerce, which are leading and the most respected and reputable business advocacy associations representing top Mongolia based business groups and companies. Currently, he is a member of the executive committee of the Asia Pacific Down Syndrome Federation and founding board member at Special Olympics Mongolia. As part of his social responsibility, Ganzorig is a founder of Down Syndrome Association and Special Olympics Mongolia a decade ago.

Ganzorig established the Young Professionals' Group, the first ever mentorship program in Mongolia 10 years ago. This NGO aims to provide mentorship support, guidance, and advice to young professionals in various fields such as politics, economics, banking and finance, law, media, health, mining, transportation logistics, marketing, public relations, and non-governmental organizations. Furthermore, he is a columnist at the leading news portal sites as well as a host of Syndicate Talk multi-format TV talk show. Recently, he made his debut as a film producer with the movie Trio, which has won dozens of awards internationally as well as screened at the UN's headquarters in New York and Geneva, plus UNESCO's head office in Paris.

*Together
for tomorrow*



ПАНЕЛИСТ ЖАРГАЛСАЙХАНЫ ЗОЛЖАРГАЛ

Улсын Их Хурлын гишүүн, Инновац,
Цахим Бодлогын байнгын хорооны
дарга

Ж.Золжаргал нь түлшний технологиор мэргэшсэн. МАК, ЭТТ, ДДНХБ, НҮБХХ гэх мэт байгууллагуудын аж үйлдвэр, ногоон хөгжлийн төслүүдийг хэрэгжүүлэхэд оролцсон. Санкт-Петербургийн Уул уурхайн дээд сургуулийг Нефтийн инженер мэргэжлээр төгссөн. Токио хотын Технологийн их сургуулийн Магистр.

*Together
for tomorrow*



PANELIST

ZOLJARGAL JARGALSAIKHAN

Member of the State Great Hural (Parliament) of Mongolia, Chair of the Standing Committee on Innovation and Digital Policy

Zoljargal is specialized in fuel technology. Involved in various industrial and green development projects of MAK, ETT, GGGI, UNDP and other organizations. Holds Petroleum Engineering degree from Saint-Petersburg State Mining Institute and Master in Engineering from Tokyo Institute of Technology.



ПАНЕЛИСТ

ЭНХБАЯРЫН БАТШУГАР

Улсын Их Хурлын гишүүн, Цахим Хөгжил, Инновац, Харилцаа Холбооны сайд

Э.Батшугар нь Монголбанкны дэд ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргаар ажилласан туршлагатай. Мөн МАН-ын дэргэдэх Нийгмийн ардчилал Монголын залуучуудын холбооны Дэд Ерөнхийлөгч, Лондон хот дахь J.P.Morgan хөрөнгө оруулалтын банканд банкир, "Медиа холдинг" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан.

АНУ-ын Массачусетс мужийн Валтхам хотын Бентлигийн Их сургуулийг Эдийн засагч, санхүүч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.



PANELIST

BATSHUGAR ENKHBAYAR

Minister of Digital Development, Innovation, and Communications, Member of the State Great Hural (Parliament) of Mongolia

Batshugar Enkhbayar began his career as an investment banker at J.P.Morgan (2008–2011). He then served as Secretary for Foreign Relations of the Mongolian People's Revolutionary Party (2011–2012), followed by his appointment as Deputy Governor of the Bank of Mongolia (2012–2016). From 2016 to 2021, he was a Board Member of Mediaholding LLC.

He was first elected to the State Great Hural in 2021 and is now serving his second term. From 2022 to 2024, he chaired the Standing Committee on Innovation and Digital Policy. In June 2025, he was appointed Minister of Digital Development, Innovation, and Communications.

Batshugar holds a degree in Economics and Finance from Bentley University in the United States.



ПАНЕЛИСТ

ЖЕННИФЕР ЧАН

Meta компанийн Ази Номхон Далайн контентын эрх зүйн асуудал хариуцсан захирал, Хятад болон Өмнөд, Төв Азийн хуулийн газрын захирал Ази Номхон Далайн бүсийн Ахлах ерөнхий зөвлөх

Женнифер Чан нь Ази, Номхон Далайн бүс нутагт хөрөнгө оруулалт хийх, үйл ажиллагаа явуулахад үүсдэг эрх зүйн орчинг сайжруулах чиглэлээр мэргэшсэн хуульч юм. Газрын тос, хийн олборлолт, анагаахын тоног төхөөрөмж, химийн салбараас эхлээд технологийн томоохон төслүүдийг удирдаж, хөгжиж буй зах зээлүүдэд үнэ цэнэ бий болгоход тууштай ажиллаж ирсэн.

Meta-д тэрээр Хятад, Өмнөд болон Төв Азийн бүсийн хуулийн газрын захирал, түүнчлэн Ази Номхон Далайн бүсийн онлайн контенттой холбоотой эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийг хариуцдаг. Бүс нутаг хариуцсан удирдлагын хувиар тэрээр бизнесийн бодлогод шаардлагатай, хөрөнгө оруулалт, төслүүдийг удирдан ажиллаж байна.



PANELIST

JENNIFER CHAN

Head of Legal, APAC Content, Greater China and South and Central Asia
Senior Director and Associate General Counsel, Asia Pacific Meta

Jennifer Chan is a seasoned legal expert who has spent her career helping corporations navigate the regulatory and cultural complexities of investing and operating across the Asia-Pacific. From advising oil & gas, medical devices, and chemical industries to now guiding major tech initiatives.

At Meta, Jennifer serves as Head of Legal for Greater China and South and Central Asia, and is also Meta's inaugural Head of Content Legal for Asia Pacific, overseeing regulatory and enforcement matters tied to online content. As a key member of the regional leadership team, she helps shape business strategy and drives critical growth initiatives.



ПАНЕЛИСТ

САЛМАН ХАН

Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал, The Gideon Group

Салман Хан нь стратегийн зөвлөх, Арабын Нэгдсэн Эмират Улс (АНЭУ)-ын Засгийн газартай хамтарсан Монгол Улсад хиймэл оюун ухаанд суурилсан дата төв байгуулах дэд бүтцийн томоохон төслийг удирдан ажиллаж байна. Уг төсөл нь Хятад, ОХУ-ын өсөн нэмэгдэж буй дижитал хэрэгцээг хангахын зэрэгцээ тогтвортой хөгжлийн зорилтуудтай уялдаж байгаа билээ.

Тэрээр The Gideon Group-ийн Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирлаар ажиллаж, хөрөнгийн зах зээл, бүтцийн санхүүгийн үйл ажиллагаа, арилжаа, төрийн зөвлөх үйлчилгээ зэргээр 20 гаруй жил ажилласан туршлагатай.

Өмнө нь 4 тэрбум ам.долларын үнэлгээтэй Энэтхэгийн Sharoorji Pallonji группын гадаад хөрөнгө оруулалт хариуцсан захирал, мөн Кувейтын хоёр дахь үндэсний агаарын тээврийн Jazeera Airways-ийн нээлтийн ажилд чухал үүрэг гүйцэтгэж байв. Салман Хан нь Харвардын Их Сургуулийн Extension Сургуулийн Чөлөөт Урлаг, менежментийн мэргэжлээр бакалавр болон магистрын зэрэг хамгаалсан.



PANELIST

SALMAN KHAN

President and Chief Executive Officer of
The Gideon Group

Salman Z. Khan is the President and CEO of The Gideon Group, a capital advisory firm based in Arizona, actively engaged in advising corporates & governments, raising institutional capital, and structuring sovereign-scale solutions across the Middle East, Asia, Africa, and the United States. From strategic infrastructure to digital transformation, Khan and his team have consistently enabled high-impact outcomes for public and private sector's worldwide.

He is also Managing Member at Argyrion Capital, a New York-founded private capital platform focused on bespoke financing for SMEs and innovative ventures. In parallel, Khan is the strategic architect behind, a cognitive operating system that functions as a real-time advisor for governments, corporations, MSMEs, NGOs, and not-for-profits, offering intelligence and execution support consulting—with instant, actionable results.

Salman holds a PhD in Business Management and sits on the boards of multiple companies around the world. Notably, he is a board member at Transient.AI, an advanced artificial intelligence company specializing in decision support systems for banks and financial institutions with next-generation technology.

With over 15 years of experience operating at the intersection of capital, innovation, and policy, Khan is recognized as a trusted partner to leadership teams navigating complexity, growth, and global scale.

*Together
for tomorrow*



ПАНЕЛИСТ

НОБУАКИ ЯСУНОГА

Зүүн Хойд Ази болон Монгол Улсыг
хариуцсан Төрийн бодлого ба Засгийн
газрын харилцаа хариуцсан Захирал,
TikTok

Нобуаки Ясунога нь TikTok компанийн Зүүн Хойд Ази, Монгол Улс дахь Олон Улсын Төрийн Бодлого, Засгийн Газрын Харилцаа хариуцсан Захирал юм. Японд төвлөрөн ажилладаг тэрээр TikTok-ийн хамгийн идэвхтэй бүс нутгуудын нэг болох Зүүн Хойд Ази дахь компанийн төрийн бодлогыг хариуцан, эрх зүйн зохицуулалтын, засгийн газрын харилцаа, засгийн газруудтай хамтын ажиллагааг удирдан зохион байгуулдаг. Түүний ажил нь TikTok-ийн үйл ажиллагаанд тогтвортой орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулж, Японы контент бүтээгчдийн дижитал сурталчилгааг дэмжихэд чиглэгддэг.

Нобуаки Ясунога TikTok-д ажиллахаасаа өмнө хэд хэдэн томоохон олон улсын компаниудад төрийн бодлого болон бизнес стратегийн чиглэлээр ажилласан туршлагатай. Тэрээр Google Japan-д Засгийн газрын харилцаа, төрийн бодлогын газрын менежер, American Express-д Засгийн газрын харилцаа, төрийн бодлогын газрын захирал, Via компанид Улс хариуцсан төлөөлөгчөөр ажиллаж байжээ. Мөн Uber Japan-д Засгийн газрын харилцааны хэлтсийн даргаар, хожим нь Стратегийн бизнесийн түншлэлийн хэлтсийн даргаар ажилласан байна.

Өмнө нь тэрээр Вашингтон хотод АНУ-Японы Судалгааны Хүрээлэнд таван жил ажилласны дараа Токио дахь АНУ-Японы Зөвлөлд Гадаад харилцааны захирлаар ажиллаж байсан. Нобуаки Ясунога нь Японы Васэда Бизнесийн Сургуулиас Бизнесийн Удирдлагын Магистрын зэрэг хамгаалсан бөгөөд Лондонгийн Эдийн Засгийн Сургуульд гүйцэтгэх түвшний сургалтад хамрагджээ.

*Together
for tomorrow*



PANELIST

NOBUAKI YASUNAGA

Executive Officer, Director, Head of Global Public Policy and Government Affairs for Northeast Asia & Mongolia

Nobuaki Yasunaga is Executive Officer and Head of Global Public Policy and Government Affairs for Northeast Asia and Mongolia at TikTok. Based in Japan, he oversees the company's public policy strategy in one of TikTok's most active regions, covering regulatory engagement, government relations, and collaboration with public sector stakeholders. His work contributes to maintaining a stable environment for TikTok's operations and supports the platform's role in Japan's creator economy and digital advertising sector.

Before joining TikTok in 2024, Yasunaga worked at several global companies in public policy and business strategy roles. He was Manager for Government Affairs and Public Policy at Google Japan (2021–2024), Director and Head of Government Affairs & Public Policy at American Express (2019–2021), and Country Representative at Via (2019). At Uber Japan, he served as Head of Government Relations and later as Head of Strategic Business Partnerships (2017–2019).

Earlier, he worked as Director of External Affairs at the U.S.-Japan Council in Tokyo after five years in Washington, D.C. with the U.S.-Japan Research Institute. Yasunaga holds an MBA from Waseda Business School and completed executive coursework at the London School of Economics.



ПАНЕЛИСТ

ПОЛ КАЛАТАЮД

Archipelo компанийн мэдээллийн аюулгүй байдлын захирал, хамтран үүсгэн байгуулагч

Пол Калатаюд нь Archipelo компанийн мэдээллийн аюулгүй байдлын захирал (CISO), хамтран үүсгэн байгуулагч бөгөөд компанийн стратегийг удирдан Developer Security Posture Management (DevSPM)-ийг хөгжүүлэн ажиллаж байна. Тэрээр кибер аюулгүй байдлын салбарт 20 гаруй жилийн туршлагатай, долоон удаагийн компанийн мэдээллийн аюулгүй байдлаар (CISO) мэргэшсэн бөгөөд өмнө нь Palo Alto Networks компанид Олон улсын CSO, Aqua Security компанид мөн CISO-оор ажиллаж байсан.

Пол нь үүлэн технологид суурилсан аюулгүй байдал, DevSecOps, хиймэл оюун ухаан ба машин сургалт (AI/ML), дэд бүтэц зэрэг чиглэлд кибер аюулгүй байдал болон шинэ бүтээгдэхүүн гаргах, шинэ зах зээлд гарах тал дээр арвин туршлагатай.

Тэрээр криптографын чиглэлээр докторын зэрэгтэй бөгөөд АНУ-ын армид үндэсний аюулгүй байдлын кибер аюулгүй байдлын чиглэлээр ажиллаж байсан.

Пол мөн Palantir-ийн Жо Лонсдейлтай ONDA-г хамтран үүсгэн байгуулж, 50 сая ам.долларын хөрөнгө босгосон бөгөөд AMPZ компанийг мөн хамтран байгуулж, 100 сая ам.долларын хөрөнгө амжилттай босгож байжээ. AMPZ нь Bitcoin олборлолтын аргачлалыг ашиглан AI дэд бүтцийн өгөгдлийн санг хөгжүүлж, саяхан Carlyle-д 300 сая ам.доллараар зарагдсан юм.



PANELIST

**PAUL
CALATAYUD**

CISO & Cofounder, Archipelo

Paul Calatayud is CISO and Cofounder of Archipelo, where he drives the company's strategy pioneering Developer Security Posture Management (DevSPM). With over 20 years of cybersecurity leadership, Paul is a 7-time CISO. He previously served as Global CSO at Palo Alto Networks, reporting directly to CTO Nir Zuk, and as CISO at Aqua Security.

Paul brings deep expertise in cybersecurity and go-to-market execution across cloud-native security, DevSecOps, AI/ML, and infrastructure. He holds a PhD in cryptography and formerly served in the U.S. Army in national security cybersecurity roles.

Paul also co-founded ONDA with Joe Lonsdale (Palantir Cofounder), raising \$50M, and co-founded AMPZ, raising \$100M. AMPZ pioneered AI infrastructure datasets by leveraging Bitcoin mining methods and was recently sold to Carlyle for \$300M.

Салбар хуралдаан МАРГААШИЙН АЖИЛЛАХ ХҮЧИН

Сэдвийг онцлохын ач холбогдол

Монгол Улсад ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр алдагдаж, ажиллах хүчний хомсдол үүсэж байна. Хүн амын зорилтот бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж ажиллах хүчний бодлогыг хөдөлмөрийн зах зээлийн нөхцөлтэй уялдуулах шаардлагатай байна. Нэг талаас манай улсад ажиллах хүчний эрэлт эрэлт хэрэгцээ нэмэгдэх хандлагатай байгаа ч нөгөө талдаа нийгэм, эдийн засаг, хүн ам зүй зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай ажиллах хүчний хомсдол тулгарч байна. Энэхүү нөхцөл байдлыг шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, ирээдүйн ажиллах хүчний нөөцийг оновчтой төлөвлөх, ажиллах хүчний нөөцийг ашиглах бодлогыг хэрэгжүүлж ажилгүйдэл, ядуурлыг бууруулах талаар танилцуулж, хэлэлцүүлэг өрнүүлэх нь цаг үеэ олсон чухал арга хэмжээ юм.

Хэлэлцүүлгийн зорилго

Одоо болон ирээдүйд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдалд нөлөөлж буй хүчин зүйлс, тэдгээрийг шийдвэрлэх гарцуудыг тодорхойлох зорилготой. Үүнд Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрт байдлыг хангах тогтолцооны асуудлыг хэлэлцэх;

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчны шинэчлэл, ажлын байранд тавигдаж буй үр чадварын зөрүүтэй шаардлага, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хангагдахгүй байгаа шалтгаан нөхцөлийн талаар мэдээлэл өгөх;

Ажиллах хүчний хомсдол, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөнд тулгарч буй асуудал, шийдлийг хэлэлцэх;

Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж буй бодлого, үйл ажиллагаанд тулгарч буй асуудал, ирээдүйн ажиллах хүчнийг бэлтгэх, хөгжүүлэх боломжийн талаар хэлэлцэх.

Хэлэлцүүлгээс хүлээгдэж буй үр дүн

Хэлэлцүүлгээр Монгол Улсын хөдөлмөрийн зах зээл, ажиллах хүчний нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, эрх зүйн орчин, бодлогын шинэчлэлийн зорилтын талаар оролцогч талуудтай хэлэлцэж, цаашид хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний бодлогыг оновчтой, үр өгөөжтэй зохицуулах боломжит шийдлүүдийг тодорхойлно.

Sub-Session

THE WORKFORCE OF TOMORROW

Importance of the topic

In Mongolia, the balance between labor supply and demand is being disrupted, and a labor shortage is emerging. It is necessary to increase employment of target groups especially, and to align employment and labor policies along with the market situation. On the one hand, the demand for labor in the country tends to increase, but on the other hand, there is a shortage of labor which depends on social, economic, and demographic factors. It is important to introduce and discuss the work being done in a timely manner to create a system to solve this current situation, rationally plan future labor resources, and implement policies to fully utilize existing resources, making progress in reducing unemployment and poverty.

Purpose of discussion

This panel discussion aims to identify the factors that affect the balance of supply and demand in the current and future labor market, and the ways to solve them.

- Discuss the issues of the system to ensure the balance between supply and demand in the labor market
- Provide information on issues and situations such as the reform of the legal framework to support employment, the gap in skills available in jobs, and unmet demand in the labor market
- Discuss the problems and solutions faced by labor shortages and labor migration
- Discuss the problems faced in the policies and activities of training skilled personnel, and the possibility of training and developing the future workforce

Expected outcome from the discussion

The discussion will discuss with stakeholders the labor market and labor force situation, pressing problems, current legal framework, and policy reform objectives of Mongolia, and will aim to identify possible solutions for rational and beneficial regulation of employment and labor force policies in the future.



МОДЕРАТОР БЯМБАДОРЖИЙН АРИУНЦЭЦЭГ

Тэнгэр телевиз продюсер

2021 оноос өнөөдрийг хүртэл ажил хэрэгч мэдээ мэдээллийн Тэнгэр тв-ийн Мэдээний албаны ахлах продюсер. Тэрээр 2005 оноос МҮОНТВ-ийн Монголын Мэдээ агентлагт сурвалжлагч, ахлах редактор, Өглөөний мэдээ хөтөлбөрийн продюсер, Эрэн сурвалжлах албаны ерөнхий продюсер, Монголын мэдээ сүвгийн Ерөнхий продюсероор ажиллаж байв. Улс төр, нийгэм, эдийн засгийн мэдээ мэдээллийн чиглэлээр мэргэшсэн сэтгүүлч Б.Ариунцэцэг 2016 онд Балдоржийн нэрэмжит сэтгүүлзүйн шагнал хүртэж байв. МУИС Хэл шинжээч, СЭЗИС Банк, санхүүгийн мэргэжлээр тус тус суралцсан. Хэвлэлийн хүрээлэн, ХБНГУ-ын DW академид сэтгүүлчийн мэргэжил дээшлүүлэн суралцсан.



MODERATOR

ARIUNTSETSEG BYAMBADORJ

Producer, TenGer TV

Ariuntsetseg Byambadorj is a senior producer in the News Department at TenGer TV, overseeing business and current affairs programming since 2021. She began her journalism career in 2005 as a reporter and later senior editor at the Mongolian National Broadcaster's (MNB) Mongolian News Agency. She went on to serve as producer of the Morning News program, chief producer of MNB's Investigative Journalism Division, and general producer of the Mongolian News Channel.

Specializing in political, social, and economic reporting, Ariuntsetseg was awarded the Baldorj Journalism Prize in 2016. She studied linguistics at the National University of Mongolia and banking and finance at the University of Finance and Economics. Additionally, she completed professional journalism training at the Press Institute of Mongolia and Germany's DW Akademie.



ПАНЕЛИСТ

ЧИНБАТЫН УНДРАМ

Улсын Их Хурлын гишүүн, Соёл, Спорт,
Аялал жуулчлал, Залуучуудын сайд

Ч.Ундрам нь Япон Улсын Нагоя Их сургуулийн зочин судлаач, Харвардын Их сургуулийн Бизнесийн сургуулийн дэргэдэх Өрсөлдөөний макро-экономикийн институтын Монгол Улс дахь кординатороор ажиллаж байв.

Монгол Улсын Их сургуулийн Эдийн Засгийн сургуулийн Менежментийн тэнхимд багш, тэнхимийн эрхлэгч, профессороос тус сургуулийн Проректор хүртэл ажилласан. Ерөнхий сайдын Эдийн Засгийн бодлогын зөвлөлийн гишүүн байсан.

2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр хоёр дахь удаагаа сонгогдоод байна.

2024 оноос БСШУСБХ-ны даргаар ажиллаж байгаад 2025 оны зургаадугаар сараас Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын сайдаар томилогдоод байна.

Ч.Ундрам нь Лондон хотын Олон улсын Америкийн Их сургуулийн бизнесийн сургуулийг бакалавр, магистр, Япон Улсын Нагоя Их сургуулийн Эдийн Засгийн сургуульд докторын зэрэг тус тус хамгаалсан.



PANELIST

UNDRAM CHINBAT

Minister for Culture, Sports, Tourism, and Youth, Member of the State Great Hural (Parliament) of Mongolia

Undram Chinbat holds a bachelor's and master's degree in business from the American International University in London, and a doctorate in economics from Nagoya University in Japan.

She has served as a visiting researcher at Nagoya University and as Mongolia's coordinator for the Institute for Strategy and Competitiveness at Harvard Business School. Undram also taught at the National University of Mongolia's School of Economics, where she was Head of the Department of Management and later served as a Professor and Vice President of the university. Additionally, she was a member of the Prime Minister's Economic Policy Council.

Since 2020, she has been serving her second term as a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia. From 2024, she chaired the Standing Committee on Education, Culture, Science, and Sports, before being appointed Minister for Culture, Sports, Tourism, and Youth in June 2025.



ПАНЕЛИСТ

САРХАДЫН ЗУЛПХАР

Улсын Их Хурлын гишүүн

С.Зулпхар нь Удирдлагын академид багшаас захирал хүртэл ажилласан хорь гаруй жилийн туршлагатай.

2020 оноос Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Дэд сайдаар ажиллаж байгаад 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон.

Түрк Улсын Мимар Синаны Их сургуулийн социологи, бакалавр, Монгол Улсын Их сургуулийг социологи, магистр, Удирдлагын академийн Төрийн захиргаа, докторын зэргээр тус тус дүүргэсэн.



PANELIST

ZULPKHAR SARKHAD

Member of the State Great Hural
(Parliament) of Mongolia

Zulpkhar Sarkhad served in various academic roles at the National Academy of Governance from 1998 to 2016, advancing from lecturer to program director, and later became Director of the Academy from 2016 to 2020. He then served as Deputy Minister of Labor and Social Protection from 2020 to 2024. Since 2024, he has been serving as a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia.

He holds a bachelor's degree in sociology from Mimar Sinan University in Turkey, a master's degree in sociology from the National University of Mongolia, and a doctorate in public administration from the National Academy of Governance.



ПАНЕЛИСТ

ЛИ ГЮ ХОН

Солонгосын Шилжилт хөдөлгөөний
судалгаа, сургалтын төвийн Дэд дарга

Ли Гю Хон нь хорь гаруй жил цагаачлалын бодлого, удирдлагын чиглэлээр ажилласан бөгөөд Инчон, Жэжү, Сөүл хот дахь цагаачлалын албаны дарга, Ерөнхий байцаагчаар ажилласан. Мөн БНСУ-ын Хууль зүйн яаманд гадаад иргэдийн оршин суух бодлого хариуцсан хэлтсийн дарга, ОХУ-д суугаа Элчин сайдын яаманд Нэгдүгээр нарийн бичгийн даргаар ажиллаж байв.

Ли Гю Хон нь Чоннамын Үндэсний Их сургуулийг Герман хэлний чиглэлээр бакалавр, Чун Ан Их сургуулийг бодлогын шинжилгээний ухааны чиглэлээр магистрын зэрэгтэй төгссөн. Тэрээр одоогоор Монгол Улсад хэрэгжиж буй цагаачлалын цогц үйлчилгээний удирдлагыг бэхжүүлэх КОЙКА-ийн төслийн зөвлөхөөр ажиллаж байна.



PANELIST

**LEE GYU
HONG**

Deputy Director, Migration Research & Training Centre (MRTC)

Lee Gyu Hong has more than two decades of experience in immigration policy and administration, he has held senior roles including Commissioner and Chief of various Korean immigration offices in Incheon, Jeju, and Seoul. He also served as Director at the Ministry of Justice, managing visa and residence policies, and as First Secretary at the Korean Embassy in Russia.

Lee holds a Bachelor's degree in German Language Education from Chonnam National University and a Master's in Policy Science from Chung-Ang University. He currently contributes as an advisor on KOICA's project to strengthen comprehensive immigration service management in Mongolia.



ПАНЕЛИСТ

**ЭНДРЮ
ЧАН**

Группын Гүйцэтгэх Захирал, PRG Holdings Berhad

Эндрю нь Ази, Хойд Америкт гарааны бизнес болон зөвлөх үйлчилгээний салбарт 20 гаруй жилийн туршлагатай бизнесмэн юм. Тэрээр одоо Малайзын хөрөнгийн биржд бүртгэлтэй, жилдээ 68 сая ам.долларын эргэлттэй PRG Holdings Berhad компанийн Группын Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна. Түүний удирдлага дор тус компани нь Малайз, Сингапур, Вьетнамын хөдөө аж ахуй, үл хөдлөх хөрөнгө, эрчим хүч, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж, нийгэмд эрүүл амьдрах орчин бүрдүүлэхийг зорьж байна.

Тэрээр өмнө нь Зүүн Өмнөд Азийн тэргүүлэгч "Grab" үйлчилгээний платформын GrabExpress-ийн 8 улсын салбар хариуцсан захирал, Сингапурт тээвэр, хүргэлтийн салбар компанийг, эхэн үеийн стартапаас, нээлттэй компани болох хүртэл нь амжилттай удирдаж байсан. Accenture-д ажиллаж байхдаа Fortune 100-д багтдаг байгууллагуудад ханган нийлүүлэлт, компанийн бүтцийн шинэчлэх гэх мэт чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан.

Эндрю нь Нью-Йоркийн Их Сургуулийн Стерний Бизнесийн Сургуулийг бизнесийн удирдлагаар төгссөн.



PANELIST

**ANDREW
CHAN**

Group Managing Director of PRG
Holdings Berhad

Andrew is a seasoned business leader with over 20 years of experience in start-ups and consulting across Asia and North America. He is currently Group Managing Director and Executive Director at PRG Holdings Berhad, a Bursa Malaysia-listed company with an annual turnover of 68 million USD, operating in agriculture, property development, energy efficiency, and specialty manufacturing across Malaysia, Singapore, and Vietnam. Under his leadership, PRG is transforming local communities into better, healthier places to live, work, and play.

Earlier, Andrew spent over six years at Grab, Southeast Asia's leading super app, where he led GrabExpress across eight countries and managed Singapore's passenger mobility business, steering them from start-up phase to profitable growth and public listing. At Accenture, he advised Fortune 100 companies on operational strategy and transformation across supply chains and organizational design.

Andrew holds a Bachelor of Science in Business Administration from NYU's Stern School of Business.



ПАНЕЛИСТ

**БАТБОЛЫН
БАТТУШИГ**

ОУОХ-ын гишүүн, МҮОХ-ын
Ерөнхийлөгч

Б.Баттушиг нь Монголын Үндэсний Олимпын Хорооны Ерөнхийлөгчөөр ажиллаж, Олон Улсын Олимпын Хорооны гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Тэрээр олимпын үнэт зүйлсийг түгээн дэлгэрүүлэх, залуучуудын хөгжил, спортын олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх үйл хэрэгт оролцож ирсэн.

Спортын ажил үүргээс гадна тэрээр Монголын тэргүүлэх бизнесүүд болох Altai Holding, Emart Hypermarket Mongolia-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж, хэд хэдэн салбарт шинэчлэл, стратегийн түншлэлийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Мөн өмнө нь Skytel болон Skymedia LLC-ийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байсан туршлагатай.

2016–2018 онд Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны гишүүнээр ажиллаж байсан бөгөөд ажлын гараагаа Лондон хот дахь Morgan Stanley хөрөнгө оруулалтын банкинд металл, уул уурхайн шинжээчээр эхлүүлж байв.

Тэрээр АНУ-ын Чикагогийн Их сургуулиас Эдийн засгийн бакалавр, Харвардын Бизнесийн Сургуулиас бизнесийн удирдлагын магистрын зэрэг тус тус хамгаалсан.



PANELIST

BATTUSHIG BATBOLD

President, Mongolian National Olympic
Committee Member, International
Olympic Committee

Battushig serves as the President of the Mongolian National Olympic Committee and is a Member of the International Olympic Committee (IOC). He plays a leading role in promoting Olympic values, youth development, and international cooperation through sport.

In addition to his work in sports governance, Mr. Batbold is an accomplished business leader. He chairs several of Mongolia's leading conglomerates, including Altai Holding and Emart Hypermarket Mongolia, and has been instrumental in driving innovation and strategic partnerships across multiple sectors. He previously served as Chair of Skytel and Skymedia LLC.

From 2016 to 2018, Mr. Batbold was a member of the Monetary Policy Committee of the Central Bank of Mongolia. Earlier in his career, he worked in London as a metals and mining analyst at Morgan Stanley Investment Bank.

He holds an MBA from Harvard Business School and a BA in Economics from the University of Chicago.

Салбар хуралдаан

СТРАТЕГИЙН НӨӨЦ, ОЛОН УЛСЫН НИЙЛҮҮЛЭЛТИЙН ГИНЖИН ХЭЛХЭЭ

Сэдвийг онцлохын ач холбогдол

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр өгөөжийг Монгол Улсын иргэнд тэгш, шударга хүртээх зарчимд нийцүүлэн Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийг 2024 онд Улсын Их Хурлаас баталж, Засгийн газар хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн түүнчлэн Бүгд Найрамдах Франц Улсын төрийн өмчит Орано майнинг С.А.С компанитай Монгол Улсын Засгийн газар "Хөрөнгө оруулалтын гэрээ"-г 2025 оны Нэгдүгээр сарын 17-ны өдөр байгуулсан бөгөөд Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнээс хойш хийгдэж буй анхны томоохон гэрээ болсон юм.

Монгол Улсад тогтвортой төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар харилцан ашигтай урт хугацааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж эрдэс баялгийн салбарт гадааддын хөрөнгө оруулалтыг татах боломжтой.

Иймээс "Монголын эдийн засгийн форум 2025" чуулганы үндсэн хэлэлцүүлгээр "Стратегийн нөөц, олон улсын нийлүүлэлтийн гинжин хэлхээ" сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлж төр, хувийн хэвшлийнхэн, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, эрдэмтэн судлаачдын санал, шүүмжийг тусган үйл ажиллагаандаа хэрэгжүүлж хөрөнгө оруулалт татах олон улсын туршлага солилцох бодлого, стратегийг тодорхойлох юм.

Хэлэлцүүлгийн зорилго

Үндэсний баялгийн сангийн хуулийн хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлэх, төр, хувийн хэвшлийнхэн болон гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, эрдэмтэн судлаачдын санал санаачлагыг өрнүүлэх, хайгуул судалгаа, олборлолт, боловсруулалтын чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх, олон улсын туршлагыг судалж тэдгээрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх явдал юм.

Хүлээгдэж буй үр дүн

Хэлэлцүүлгийн хүлээгдэж буй үр дүн нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын үр ашгийг нэмэгдүүлэх хайгуул судалгаа, олборлолт, боловсруулалтын чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагчдыг бодит мэдээллээр хангах замаар эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.

Sub-Session

STRATEGIC RESOURCES & ENERGY

Importance of the topic

In accordance with the principle of ensuring fair and equal distribution of the benefits from the strategically significant mineral deposits to every current and future citizen of Mongolia, Parliament of Mongolia passed the Sovereign Wealth Fund Law in 2024. And the Government of Mongolia is working to ensure its implementation.

The Government of Mongolia signed an Investment Agreement with Orano Mining, a state-owned company of the French Republic on January 17, 2025, which is the second major agreement since the Oyu Tolgoi Investment Agreement.

It is crucial to implement long-term, mutually beneficial projects and programs in Mongolia through public-private partnerships to attract foreign investment in the mineral resources sector.

One part of our cooperation is today's event, the "Mongolian Economic Forum 2025", where the main session will focus on the topic of "Strategic Resources and the International Supply Chain." The discussions will incorporate feedback and opinions from government representatives, the private sector, domestic and international investors, and academic researchers, which will be reflected in their future activities.

Purpose of discussion

The main objective of the discussion of "Strategic Resources and Global Supply Chain" is to ensure stakeholders' participation in the implementation of the Sovereign Wealth Fund Law, provide input and feedback from the government and private sector representatives, domestic and international investors, and academic researchers, deliver information to investors with interests in cooperating in exploration, extraction, and processing, and to learn international best practices in order to integrate in their future operations.

Expected outcome from the discussion

The expected outcome of the discussion is to create a shared understanding of strategically significant mineral deposits, attract foreign investment by providing accurate information to investors with interests in cooperating in exploration, extraction, and processing areas to enhance the benefits of strategic deposits, and formulate policies and strategies through the exchange of international best practices.

Together
for tomorrow



МОДЕРАТОР

АНХБАЯРЫН БИЛГҮҮН

Гүйцэтгэх Захирал,
"Эрдэнэ Монгол" ХХК

А.Билгүүн нь Торонтогийн хөрөнгийн биржид төвлөрөн үйл ажиллагаа эрхэлдэг "Толл Кросс Секюритис"-ийн хөрөнгө оруулалтын банкны хэлтсээс ажлын гараагаа эхлүүлсэн. Монгол Улсын төдийгүй Хойд Америкийн хөрөнгийн зах зээл дээр ажиллаж байсан. "Эм Ай Би Жи ҮЦК" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллахдаа олон улсын хөрөнгө оруулагчдад Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зөвлөгөө өгөхийн сацуу дотоодын үйлчлүүлэгчдээ олон улсын хөрөнгийн зах зээлд оролцох боломжоор ханган ажиллаж байсан. 2023 оноос Эрдэнэ Монгол ХХК, Гүйцэтгэх захирал, Монгол Улс, Улаанбаатар хот

Тэрээр Сэнт Мэригийн Их сургуулийн санхүүгийн бакалавр зэрэгтэй итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээч юм.

Together
for tomorrow



MODERATOR

**BILGUUN
ANKHBAYAR**

Chief Executive Officer of
Erdene Mongol LLC

Bilguun Ankhbayar began his career in the investment banking division of Toll Cross Securities, a firm operating on the Toronto Stock Exchange. He has worked in the capital markets of both Mongolia and North America. As CEO of MIBG Securities LLC, he provided advisory services to international investors entering the Mongolian capital market and facilitated opportunities for domestic clients to access international capital markets. Bilguun holds a Bachelor's degree in Finance from Saint Mary's University and is a Chartered Financial Analyst (CFA).



ПАНЕЛИСТ

**БӨХЧУЛУУНЫ
ПҮРЭВДОРЖ**

Улсын Их Хурлын
дэд дарга

Б.Пүрэвдорж нь Гаалийн Ерөнхий газрын харьяа байгууллагуудад байцаагч, албаны дарга, Ховд аймгийн АН-ын дарга, Гадаадын Иргэн, Харьяатын асуудал эрхлэх газрын дарга, Иргэний харьяалал шилжилт хөдөлгөөний ерөнхий газрын даргаар ажиллаж байсан.

2016 оноос хойш Улсын Их Хурлын гишүүнээр гурав дахь удаагаа сонгогдон, 2024 оноос Улсын Их Хурлын дэд даргаар томилогдсон ажиллаж байна.

Тэрээр Монгол Улсын Их сургуулийн Олон улсын харилцааны дээд сургуулийг гадаад харилцаа, англи хэлний багш, орчуулагч мэргэжлээр дүүргэсэн.



PANELIST

PUREVDORJ BUKHCHULUUN

Deputy Chairman, Member of the State
Great Hural (Parliament) of Mongolia

Purevdorj Bukhchuluun is the Deputy Chairman of the State Great Hural (Parliament) of Mongolia and a three-time elected Member of Parliament since 2016.

He previously served as Head of the General Authority for Citizenship and Migration (2012–2015) and as Chairman of the Democratic Party in Khovd Province (2009–2012). From 1995 to 2009, he worked at the Mongolian Customs General Administration in various capacities, including as inspector and department head at customs offices in Bayan-Ulgii, Buyant-Ukhaa, and Ulaanbaatar.

He holds a degree in English language teaching and translation from the School of International Relations of the National University of Mongolia.



ПАНЕЛИСТ

ГОНГОРЫН ДАМДИННЯМ

Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр,
эрдэс баялгийн сайд

Г.Дамдинням нь Байгаль Орчны сайдын зөвлөх, БСШУ-ны сайдын зөвлөх, ШУТИС-ийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн проректор, Канад Улс Бритишийн Колумбын Их сургуулийн судлаач, "Прокон Майнинг Монголиа" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.

Тэрбээр 2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр хоёр дахь удаагаа сонгогдон ажиллаж байна.

2021-2022 онд Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын Байнгын хорооны дарга, 2024 оноос Улсын Их Хурал дахь МАН-ын Бүлгийн дэд даргаар ажиллаж байгаад Аж үйлдвэр, Эрдэс баялгийн сайдаар томилогдсон.

Г.Дамдинням нь Монгол Улсын Боловсролын Их сургуулийг Нийгэм судлал, эрх зүйн багш бакалавр, Улс төр судлалын магистр, Бритиш Колумбын Их сургуулийг Уул уурхайн засаглал, бодлого судлалын магистрийн зэргээр тус тус дүүргэсэн.



PANELIST

DAMDINNYAM GONGOR

Minister of Industry and Mineral Resources, Member of the State Great Hural (Parliament) of Mongolia

Damdinnyam Gongor has been working as a Member of Parliament of Mongolia and Deputy Chairman of Mongolian People's Party Caucus at Parliament of Mongolia since 2000. He has an extensive experience in Chairman of the Standing Committee on Education, Culture, Science and Sports, Advisor to Minister of Environment of Mongolia, Advisor to Minister of Education, Culture and Sciences of Mongolia, Dean of Social Development and Economy of the Mongolian University of Science and Technology (MUST), Researcher of the University of British Columbia of Canada, Chief Executive Officer of "Procon Mining Mongolia" Co.,Ltd, Member of Board of Directors and Vice President of Mongolian Democratic Socialist Student Union at the Mongolian People's Party.

Specialized in Mining governance, social study and law. He has a Master Degree in Mining governance and policy studies from the University of British Columbia of Canada, and Master of Art in Political Sciences from the Mongolian State University of Education.



ПАНЕЛИСТ

ОЛИВЬЕ ТУМИР

Orano Asia компанийн захирал

Оливье Тумир нь Бээжин хотод төвтэй Orano Asia компанийг удирдан ажиллаж байгаа бөгөөд стратегийн эрчим хүч, олон улсын бизнес, цөмийн эрчим хүчний салбарт 25 гаруй жил удирдлагаар ажилласан туршлагатай. Тэрээр НЕС Paris сургуулийг төгссөн бөгөөд Orano компанийн Ази дахь үйл ажиллагааг өргөжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн.

Тэрээр Монгол Улсын Засгийн газар болон Orano Маининг компанийн хамтарсан түүхэн ач холбогдолтой хамтарсан төсөл/ компани буюу, Дорноговь аймгийн Зөөвч-Овоогийн ураны ордыг "Badrakh Energy"-ийн хөрөнгө оруулалтын гэрээг амжилттай хэлэлцэж, хэрэгжүүлснээрээ танигдсан нэгэн билээ. 2025 оны нэгдүгээр сард байгуулсан энэхүү хөрөнгө оруулалтын гэрээ нь Монголын уул уурхайн салбарт сүүлийн жилүүдэд орж ирсэн хамгийн том гадаадын хөрөнгө оруулалт болж, улмаар Монгол Улсыг дэлхийн ураны нийлүүлэлтийн сүлжээнд шинэ тэргүүлэгч орнуудын нэг болох боломжийг нээж байна.



PANELIST

**OLIVIER
THOUMYR**

Head of Orano Asia

Olivier Thoumyr is the Head of Orano Asia, based in Beijing, and brings over 25 years of experience in strategic energy development, international business, and leadership in the nuclear sector. A graduate of HEC Paris, Olivier has played a pivotal role in advancing Orano's presence in Asia.

He is best known in Mongolia for leading the successful negotiation and launch of the landmark joint venture between Orano Mining and the Mongolian government — Badrakh Energy — to develop the Zuuvch-Ovoo uranium deposit in Dornogovi province. Signed in January 2025, the Investment agreement marked Mongolia's most significant foreign investment in the mining sector in recent years and positions the country to become a leading new player in the global uranium supply chain.



ПАНЕЛИСТ

**САНЖААГИЙН
НАРАНЦОГТ**

"Эрдэнэс-Монгол" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж үнэ цэн, үр өгөөж бий болгоход төрийн төлөөллийг хэрэгжүүлэх зорилготой "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Наранцогт нь ажлын гараагаа Төрийн захиргааны төв байгууллагуудад мэргэжилтнээс эхэлж ахлах мэргэжилтэн, хэлтсийн дарга, газрын дарга, Төрийн нарийн бичгийн дарга зэрэг албан тушаалыг төрийн албаны мерит зарчмаар хийж гүйцэтгэж байв.

2022 оны 12 сард "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдохоос өмнө Эдийн засаг, хөгжлийн дэд сайд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хөдөлмөрийн яам болон Боловсрол, шинжлэх ухааны яаманд удирдах албанд ажиллаж байсан туршлагатай.

Тэрээр төрийн өмчит "Эрдэнэс Монгол" компанид Монгол Улсын хүнд аж үйлдвэрийн сэргэлтэд манлайлах үүрэг гүйцэтгэж аж үйлдвэрийн гинжин хэлхээг оновчтой бий болгох замаар эрдэс баялгийн үнэ цэнийг нэмэгдүүлэх, нэгдлийн компаниудаа нэгдсэн бодлого, стратегиар манлайлан удирдаж байна.

Түүнчлэн, эрдэс баялгийн үнэ цэнийг нэмэгдүүлж, өнөө болон ирээдүйд үр өгөөж хүртээх тогтолцоог бий болгох Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг боловсруулж батлуулах болон Монгол Улсын гуравдагч хөрштэй байгуулсан хоёр дахь том хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах ажлыг манлайлан гүйцэтгэсэн.



PANELIST

NARANTSOGT SANJAA

Chief Executive Officer,
Erdenes Mongol LLC

Narantsogt Sanjaa is Chief Executive Officer of Erdenes Mongol LLC, the state-owned enterprise tasked with bringing Mongolia's strategically important mineral deposits into economic circulation to create value and returns for the nation.

He began his career in Mongolia's central government agencies, advancing through the ranks from specialist to senior specialist, department head, division head, and State Secretary, under the principles of a merit-based civil service. Prior to his appointment as CEO of Erdenes Mongol in December 2022, he served as Deputy Minister of Economy and Development, State Secretary of the Ministry of Finance, and held senior roles in the Ministries of Labor and Education & Science.

At Erdenes Mongol, Narantsogt leads efforts to revitalize Mongolia's heavy industry, optimize industrial value chains, and maximize mineral wealth, steering the group's companies under a unified strategy. He also spearheaded the drafting and adoption of Mongolia's Sovereign Wealth Fund Law to ensure long-term benefits from mineral resources, and led the signing of Mongolia's second major investment agreement with a third neighbor country.



ПАНЕЛИСТ

ТЭЦҮЯ ВАТНАБЭ

АСЕАН, Зүүн Азийн Эдийн засгийн
судалгааны хүрээлэн (ERIA)
Ерөнхийлөгч

Тэцүя Ватанабэ нь АСЕАН, Зүүн Азийн Эдийн засгийн судалгааны хүрээлэн (ERIA)-ийн Ерөнхийлөгчөөр ажилладаг ба уг байгууллага нь бодлогын зөвлөмж боловсруулахад чиглэсэн үйл ажиллагаа эрхэлдэг. Тэрээр АСЕАН болон Зүүн Азийн бүс нутгийн Засгийн газрууд, АСЕАН-ы Нарийн бичгийн дарга нарын газар, их дээд сургууль, хувийн хэвшил, нийгмийн байгууллагуудтай нягт хамтран ажилладаг.

Түүний бодлогын зөвлөмж боловсруулах судалгааны гол чиглэлд нийлүүлэлтийн сүлжээ, нүүрстөрөгчийг бууруулах бодлого, хиймэл оюун ухаан, дижитал эдийн засаг, стартап, эрүүл мэнд, хүний нөөцийн хөгжил зэрэг асуудлууд багтдаг. Тэрээр 2023 онд ERIA-д ажиллахаасаа өмнө, Японы Эдийн засаг, Худалдаа, Аж Үйлдвэрийн Сайдын зөвлөхөөр ажиллаж байсан.



PANELIST

**TETSUYA
WATANABE**

President of ERIA (Economic Research
Institute for ASEAN and East Asia)

Tetsuya Watanabe is the President of ERIA (Economic Research Institute for ASEAN and East Asia), an international organization based in Jakarta that provides a multi stakeholder platform for policy dialogue. He works closely with the ASEAN Secretariat, governments, academia, businesses, and civil society in ASEAN and East Asia. His work on policy research focuses on key areas such as supply chains, decarbonization, AI, digital economy, startups, public health and human resource development. Prior to joining ERIA in 2023, he was the Special Advisor to the Japanese Minister of Economy, Trade, and Industry.



ПАНЕЛИСТ

**ГОТОВЫН
БАТЦЭНГЭЛ**

Монголын Уул Уурхайн Үндэсний
Ассоциаци

Г.Батцэнгэл нь Коменюс Их сургуульд багшилж ажлын гараагаа эхэлсэн ба М-Си-Эс группын охин компаниудад удирдах албан тушаал хашиж байсан. Энэ хугацаанд Ухаа худаг уурхайг аж үйлдвэрийн томоохон цогцолбор болгон хөгжүүлэх, компанийг олон улсын тавцанд таниулахад чухал үүрэгтэйгээр өнөөг хүртэл ажиллаж ирсэн.

2008-2024 онд Энержи Ресурс компанийн Гүйцэтгэх захирлаар, 2024 оны 1-р сараас хойш толгой компани болох Mongolian Mining Corporation группын Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Тэрээр Бүгд Найрамдах Словак Улсын Коменюс Их сургуулийг дүүргэсэн. Органик химийн ухааны докторын зэрэгтэй.

Г.Батцэнгэл нь Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци, Монголын Эрдэс баялгийн бодлогын зөвлөл гэх мэт төрийн бус байгууллагуудын удирдах зөвлөлийн гишүүн юм. Тэрчлэн 2022 оноос Монголын Сагсан Бөмбөгийн Холбооны Ерөнхийлөгчөөр сонгогдон ажиллаж байна.



PANELIST

BATTSENDEL GOTOV

Board Member, Mongolian National
Mining Association

Battengel Gotov began his career as a lecturer at Comenius University in Slovakia before holding senior management positions within subsidiaries of the MCS Group. During this time, he played a key role in transforming the Ukhaa Khudag mine into a major industrial complex and in elevating the company's international profile.

From 2008 to 2024, he served as Chief Executive Officer of Energy Resources, and since January 2024 has been the CEO of Mongolian Mining Corporation, the group's parent company.

Dr. Battengel earned his Ph.D. in Organic Chemistry from Comenius University. He serves on the boards of several organizations, including the Mongolian National Mining Association and the Mineral Resources Policy Council. Since 2022, he has also been President of the Mongolian Basketball Association.

Салбар хуралдаан ТОГТВОРТОЙ ОЛБОРЛОЛТ

Сэдвийг онцлохын ач холбогдол

Монгол Улсын Засгийн газраас уул уурхайн гаралтай түүхий эд, эрдсийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг ахиулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Уул уурхайн үйлдвэрлэлийг тогтвортой бодлогоор дэмжих, үйл ажиллагаанд нь учирч буй саад бэрхшээлийг арилгаж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бүрдүүлэхэд чухал үүрэгтэй юм. Энэ удаагийн "Монголын эдийн засгийн форум 2025" чуулганы салбар хуралдаанаар "Тогтвортой олборлолт" хэлэлцүүлэгийг өрнүүлж төр, хувийн хэвшлийнхэн, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, эрдэмтэн судлаачдын санал, шүүмжийг үйл ажиллагаандаа тусган төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар харилцан ашигтай урт хугацааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх боломж шийдлийг тодорхойлно.

Хэлэлцүүлгийн зорилго

Уул уурхайн салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгох, эрдэс баялгийн салбарын талаарх зөрүүтэй, буруу ойлголтыг засах, тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай дэмжлэг, эрх зүйн орчны өөрчлөлтийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийнхэн, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, эрдэмтэн судлаачдын санал, шүүмжийг өрнүүлэх, хайгуул судалгаа, олборлолт, боловсруулалтын чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх, энэ талаарх олон улсын туршлагыг судлах, тэдгээрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх явдал юм.

Хүлээгдэж буй үр дүн

Хайгуул судалгаа, олборлолт, боловсруулалтын чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагчдыг бодит мэдээллээр хангах, эрдэс баялгийн салбарт ашигт малтмалын төрлөөр бодлогын стратегийг төлөвлөх шийдлийг боловсруулна.

Sub-Session

SUSTAINABLE EXTRACTION

Importance of the topic

The Government of Mongolia is working with the aim of improving the level of processing of mining raw materials and minerals, increasing the production of value-added products. Supporting the mining industry through stable state policy, removing challenges and obstacles and promoting value-added manufacturing are crucial steps that will greatly contribute to increasing the revenue for both the national and local budgets. In this context, the Ministry of Industry and Mineral Resources is committed to improve the legal environment, correct misconceptions and misunderstandings on the mineral resources sector among the communities, and support the necessary legal reforms for investors to operate in a stable way with their special licences. This will establish a solid legal foundation for implementing mutually beneficial, long-term projects and programs based on the principle of public-private partnership.

As part of our collaboration “Mongolian Economic Forum 2025”, and sub session of “Sustainable Mining” will serve as a platform where the opinions and feedback of government and private sector representatives, domestic and international investors, as well as academic researchers will be reflected in their future activities.

Purpose of discussion

The main objective of the discussion on “Sustainable Extraction” is to improve the legal environment, address misconceptions and misunderstandings about the mineral resources sector within communities, and support the development of necessary legal reforms that enable investors to operate securely under their special licenses.

The discussion also aims to gather feedback from government and private sector stakeholders, domestic and international investors, and academic researchers. Furthermore, it seeks to inform investors interested in cooperation in exploration, extraction, and processing, to study international best practices, and to integrate those practices into practical operations.

Expected outcome from the discussion

The expected outcome of the discussion is to improve legal environment of the mining sector, correct misconceptions and misunderstandings on mineral resources sector among the communities, ensure the investors for their stable operation under the special licenses, attract foreign investment by providing accurate information to the investors with interests in cooperating in exploration, extraction, and processing areas, and formulate policies and strategies for critical minerals through the exchange of international best practices.



МОДЕРАТОР ЭРДЭНЭБИЛЭГИЙН ЭНХЦЭЦЭГ

Монголын уул уурхай, эрчим хүч, эдийн засгийн сэтгүүлч клуб, ТУЗ-ийн дарга

Уул уурхайн салбарт хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцааны чиглэлээр 18 дахь жилдээ сэтгүүлч, харилцааны зөвлөхөөр ажиллаж байна. Монгол Улсад хэрэгжиж байгаа нүүрс, зэс, уран, газрын ховор элементийн томоохон төслүүдэд хэвлэл мэдээлэл, орон нутгийн харилцааны зөвлөх үйлчилгээ үзүүлж ирсэн арвин туршлагатай. Уул уурхайн мэргэшсэн сэтгүүлчдийг бий болгоход анхааран Монголын уул уурхай, эрчим хүч, эдийн засгийн сэтгүүлчдийг клуб байгуулан ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Хэвлэл мэдээлэл, сошиал орчинд уул уурхайн талаар зөв ойлголт, мэдлэг олгоход чиглэсэн хэлэлцүүлэг өрнүүлдэг, бие даасан, хараат бус мэргэжлийн сэтгүүлч юм.



MODERATOR

**ENKHTSETSEG
ERDENEBILEG**

Chairwoman of the Board, Mongolian
Mining, Energy, and Economic Journalists'
Club

Enkhtsetseg Erdenebileg is a journalist and communications advisor with 18 years of experience in media and public relations in the mining sector. She has extensive expertise providing media and community relations advisory services for major coal, copper, uranium, and rare earth projects implemented in Mongolia.

Dedicated to advancing specialized journalism in mining, she founded the Mongolian Mining, Energy, and Economic Journalists' Club and serves as Chairwoman of its Board. Enkhtsetseg is an independent, impartial professional journalist who actively facilitates discussions in the media and social platforms to foster accurate understanding and knowledge about mining.



ПАНЕЛИСТ

**ОТГОНШАРЫН
БАТНАЙРАМДАЛ**

Улсын Их Хурлын гишүүн

О.Батнайрамдал нь "Ориго партнерс Монголиа" ХХК-д Уул уурхайн хөрөнгө оруулалт хариуцсан дэд ерөнхийлөгч, АНУ-ын "Банк оф Америка"-ийн Нью-Йорк болон Сидней дэх салбарт Уул уурхайн хөрөнгө оруулалтын банкир, "Эрдэнэс Тавантолгой" ХК-д IPO, хувьцаа хариуцсан дэд захирал, Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газрын даргын зөвлөхөөр ажиллаж байсан. Тэрээр Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Дэд сайдаар ажиллаж байсан. 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон.

О.Батнайрамдал нь Норвеги Улсын Нордикийн дэлхийн нэгдсэн коллеж, АНУ-ын Макалестерийн коллежид эдийн засгийн бакалавр, Харвардын Бизнесийн сургуульд бизнесийн удирдлагын магистрын зэргээр дүүргэсэн.



PANELIST

BATNAIRAMDAL OTGONSHAR

Member of the State Great Hural
(Parliament) of Mongolia

Batnairamdal Otgonsnar has served as Vice President for Mining Investments at Origo Partners Mongolia LLC, as an investment banker for mining at Bank of America in New York and Sydney, and as Deputy CEO for IPO and equity at Erdenes Tavan Tolgoi JSC.

He also worked as an Advisor to the Chief Cabinet Secretary and previously held the position of Deputy Minister of Mining and Heavy Industry. Since 2024, he has been serving as a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia.

He earned his Bachelor's degree in Economics from Macalester College in the United States and attended UWC Red Cross Nordic in Norway. He also holds an MBA from Harvard Business School.



ПАНЕЛИСТ

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ

Монгол Улсын Их Хурлын даргын
орон тооны бус зөвлөх

Монгол Улсын арилжааны банкнаас ажлын гараагаа эхэлж, НҮБ-ын Уур амьсгалын ногоон санд ахлах хуульчаар ажиллаж байсан. Тэрээр одоо Өмгөөллийн "Дашням Партнерс" ХХК (хуучнаар ДиБиэндЖитиЭс ХХК)-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Д.Золжаргал нь санхүү, банк, эрчим хүч, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт, бизнесийн эрхзүйгээр мэргэшсэн, туршлагатай хуульч юм.

Монголын эрчим хүч, уул уурхай, дэд бүтцийн салбарын хууль тогтоомжийн хүрээнд арвин туршлагатай, тэргүүлэх мэргэжилтэн юм. Д.Золжаргалын харилцагч нарт эрчим хүчний компаниуд, үндэстэн дамнасан корпорац, ашигт малтмал, газрын тосны компани, арилжааны банк, хөрөнгө оруулалтын банк, хөрөнгө оруулалтын сан зэрэг багтана. Тэрээр Монгол Улсын хууль эрх зүйн холбоотой фирмийн байгуулсан гэрээ хэлцэлд тэргүүлж, гар биеэр оролцсон олон жилийн туршлагатай. Д.Золжаргал нь долоон жилийн хугацаанд Монголын томоохон арилжааны банкинд хуулийн зөвлөхөөр ажилласан туршлагатай. 2007 оноос хойш уул уурхай, эрчим хүч, дэд бүтцийн гэрээ хэлцэлд тасралтгүй зөвлөж, ажиллаж ирсэн туршлагатай. Энэ хугацаанд ДЦС5-ын төсөлд гадаадын хөрөнгө оруулагч спонсорыг төлөөлж ажилласан. Тэрээр мөн "Green Climate Fund" ногоон санхүүжилтийн олон улсын санхүүгийн байгууллагад ахлах хуульчаар ажиллаж туршлага хуримтлуулсан.

2010-2025 оны хугацаанд Chambers and Partners Asia Pacific-ээс шалгаруулдаг бизнесийн салбарын тэргүүлэх хуульчид шалгарахын зэрэгцээ The Legal500 ч мөн Д.Золжаргалыг тэргүүлэх хуульчаар тодруулаад байна. 2019 онд Монголын Хуульчдын Холбооны Шилдэг хуульчаар шалгарч, Фемида шагнал хүртсэн.

Д.Золжаргал нь Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн бөгөөд шүүхэд төлөөлөх эрхтэй өмгөөлөгч, үнэт цаасны зах зээлд ажиллах эрхтэй хуульч. Мөн EuroMoney Training байгууллагаас зохион байгуулдаг Advanced Loan Documentation, Syndicated Loan Documentation сургалтанд 2004 онд, Public, private partnership сургалтанд 2013 онд тус тус суралцсан. Тэрээр МУИС-ийн Хууль зүйн сургуулийг олон улсын эрх зүйн бакалавраар, АНУ-ын Оклахомагийн их сургуулийг бизнесийн удирдлагын магистраар, АНУ-ын Харвардын хуулийн сургуулийг хууль зүйн магистраар тус тус төгссөн.



PANELIST

ZOLJARGAL DASHNYAM

Non-staff Advisor to the Deputy
Chairman of the State Great Hural (Parliament) of Mongolia

Zoljargal Dashnyam started his career at a commercial bank in Mongolia and later worked as Senior Legal Counsel at the Green Climate Fund under the United Nations. He is now the CEO of Dashnyam Partners LLC (formerly DB>S LLC), a law firm based in Mongolia. Zoljargal is an experienced lawyer specializing in investment and business law for the finance, banking, energy, and mining sectors. He has extensive expertise in Mongolia's laws on energy, mining, and infrastructure. His clients include energy companies, multinational corporations, mining and oil companies, commercial and investment banks, and investment funds. He has over seven years of experience as a legal advisor at a major Mongolian commercial bank and has continuously advised on mining, energy, and infrastructure agreements since 2007, including representing foreign sponsors in the CHP5 project.

Zoljargal was also recognized as a leading lawyer by Chambers and Partners Asia Pacific and The Legal 500 between 2010 and 2025, and was named Best Lawyer by the Mongolian Bar Association in 2019.

He is a member of the Mongolian Bar Association and the Mongolian Advocates Association, licensed to represent clients in court and in the securities market. Zoljargal holds a bachelor's degree in international law from the National University of Mongolia, an MBA from the University of Oklahoma, and a Master of Laws from Harvard Law School.



ПАНЕЛИСТ

ГЭЛЭНГИЙН ЁНДОН

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын
Ерөнхий захирал

Г.Ёндон нь Уул уурхайн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, Монголросцветмет ТӨҮГ-ын Бор-Өндөрийн Уулын баяжуулах үйлдвэрт маркшейдер, ерөнхий маркшейдер, Үйлдвэрлэл техникийн хэлтсийн дарга, Хөгжлийн хэлтсийн дарга, Шижир-Алт уулын үйлдвэрийн захирал, Баргилтын уулын үйлдвэрийн ерөнхий инженер, Үйлдвэрлэл эрхэлсэн орлогч захирлаар ажиллаж байв. 2020-2022 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ажиллаж байгаад 2022 оноос "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлаар томилогдсон.

Тэрээр ОХУ-ын Иркутск хотын Техникийн Их сургуулийг Уулын инженер-маркшейдер мэргэжлээр, ОХУ-ын Геологи, минералогийн ухааны доктор (PhD)-ын зэргээр дүүргэсэн. Монгол улсын Зөвлөх инженер.



PANELIST

YONDON GELEN

Chief Executive Officer, Erdenet
Mining Corporation SOE

Yondon Gelen is the Chief Executive Officer of Erdenet Mining Corporation, Mongolia's largest state-owned industrial enterprise.

Yondon began his career as a researcher at the Mining Institute and went on to hold a range of technical and leadership positions at Bor-Undur Mining and Processing Plant of Mongolrostsvetmet SOE, including mine surveyor, chief surveyor, head of production technology, and head of development. He later served as Director of Shijir-Alt Mining Plant, Chief Engineer of Bargilt Mine, and Deputy Director for Production.

From 2020 to 2022, he was Mongolia's Minister of Mining and Heavy Industry, before being appointed as CEO of Erdenet Mining Corporation in 2022.

Yondon holds a degree in Mining Engineering and Mine Surveying from Irkutsk Technical University in Russia, as well as a PhD in Geology and Mineralogy. He is a certified Consulting Engineer of Mongolia.



ПАНЕЛИСТ

ЭЛЧИН САЙД АСАН КУРТ ТОНГ

Удирдах партнер, The Asia Group

Курт Тонг нь Ази бүс нутагт төвлөрсөн стратегийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг тэргүүлэгч The Asia Group компанийн удирдах партнер бөгөөд Зүүн Азийн бүс нутгийн бодлого, Япон, Хятад, Солонгосын зах зээлд чиглэсэн зөвлөх үйлчилгээний багуудыг удирдан ажиллаж байна. Зүүн Азийн дипломат харилцаа, эдийн засгийн асуудлаар мэргэшсэн тэрээр АНУ-ын Төрийн департаментад дипломатч, ахлах дипломат албаны гишүүнээр 30 жил ажилласан байна.

Тэрээр өмнө нь АНУ-аас Хонконг, Макао-д суугаа Элчин сайдаар томилогдож, Төрийн департаментын Эдийн засаг, бизнесийн асуудал хариуцсан орлогч туслах төрийн нарийн бичгийн даргаар, Токио дахь АНУ-ын Элчин сайдын яаманд орлогч элчин сайд, мөн Цагаан ордны дэргэдэх Азийн эдийн засгийн асуудал эрхэлсэн захирал, АРЕС-т АНУ-ын төлөөлөгчөөр тус тус ажиллаж байсан. Курт Тонг нь Энэтхэг-Номхон далайн бүсийн эдийн засгийн дипломат харилцааг гүнзгийрүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэж, Trans-Pacific Partnership болон АНУ-БНСУ-ын Чөлөөт худалдааны хэлэлцээрийг боловсруулахад хувь нэмрээ оруулсан бөгөөд 2011 онд АРЕС-ийг АНУ удирдаж байхад тэргүүнээр ажилласан.

Тэрээр Princeton School of Public and International Affairs-аас бакалаврын зэрэг эзэмшсэн бөгөөд Бээжин, Тайпей, Токио дахь сургуулиудад хэл, эдийн засгийн чиглэлээр ахисан түвшний сургалтууд дүүргэсэн.



PANELIST

**AMB.
KURT TONG**

Managing Partner,
The Asia Group

Kurt Tong is Managing Partner at The Asia Group, a leading strategic advisory firm focused on Asia, where he directs consulting teams covering Japan, Greater China, Korea, and regional East Asia policy. With more than 30 years of experience as a career Foreign Service Officer in the U.S. Department of State, he is a seasoned diplomat and economic strategist.

He previously served as U.S. Consul General and Chief of Mission in Hong Kong and Macau, Principal Deputy Assistant Secretary for Economic and Business Affairs at the U.S. Department of State, Deputy Chief of Mission and Chargé d'Affaires at the U.S. Embassy in Tokyo, and U.S. Ambassador for APEC and Director of Asian Economic Affairs at the White House. Ambassador Tong played a central role in advancing U.S. economic diplomacy in the Indo-Pacific, contributing to the Trans-Pacific Partnership and the U.S.-Korea Free Trade Agreement, and leading the U.S. chairmanship of APEC in 2011.

He holds a B.A. from the Princeton School of Public and International Affairs and completed graduate-level studies in language and economics in Beijing, Taipei, and Tokyo.



ПАНЕЛИСТ

**ГАНБОЛДЫН
ЭРДЭНЭТУЯА**

Монголын Уул Уурхайн Үндэсний
Ассоциацийн Гүйцэтгэх захирал

Г.Эрдэнэтуяа нь тогтвортой уул уурхай, байгаль орчны менежмент болон олон талт оролцогч талуудтай хамтын ажиллагааны чиглэлээр ажилласан 20 гаруй жилийн туршлагатай, өндөр чадвартай уул уурхайн мэргэжилтэн юм. Тэрээр Оюу Толгой (Рио Тинто), Бороогоулд, Аспайр Майнинг, Хан Алтай Ресурс зэрэг компаниудад ажиллаж байсан.

Тэрээр Монгол Улсын Их Сургуулийг Байгаль орчны химийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн бөгөөд Оксфордын Их Сургуулийн "Үндэсний хөгжилд Уул уурхай, газрын тос, хийн салбарын оруулах хувь нэмэр" хөтөлбөрийг амжилттай дүүргэсэн. Австралид олон улсын ISO аудитор, зөвлөхөөр магадлан итгэмжлэгдсэн бөгөөд Оюу Толгой болон Аспайр Майнингийн төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын ТЭЗҮ боловсруулахад хамтран ажилласан туршлагатай. Мөн Австрали-Монголын Эрдэс баялгийн салбарын хөгжлийн хөтөлбөрт (АМЕР) байгаль орчны асуудал хариуцсан зөвлөхөөр ажиллаж байсан. Тэрээр Монгол Улсын эрдэс баялгийн салбарт хариуцлагатай уул уурхайн зарчим, стандартыг нэвтрүүлэх ажлыг удирдан ажиллаж буй бөгөөд олон талт хамтын ажиллагаа, эрдэс баялгийн салбарын тогтвортой хөгжилд төвлөрөн ажиллаж байна. Энэ хүрээнд хийгдэж буй ажлуудын нэг нь "Ирээдүйн Инженерүүд" хөтөлбөр бөгөөд энэ нь Монголын уул уурхайн салбарын ирээдүй үеийг бэлтгэх, үр чадвар хөгжүүлэхэд чиглэж байна.

Мөн олон улсын ESG стандарт болох Канадын уул уурхайн ассоциациас гаргасан Тогтвортой уул уурхайн төлөө (ТУУТ/TSM) стандартыг албан ёсоор гэрээ байгуулан авч, Монгол Улсад нэвтрүүлэх ажлыг гардан хийж байгаа бөгөөд уг ажлын хүрээнд нутагшуулах, таниулах ажлыг хийж гүйцэтгэж байна.



PANELIST

ERDENETUYA GANBOLD

Chief Executive Officer of Mongolian
National Mining Association

Erdenetuya Ganbold is the Executive Director of the Mongolian National Mining Association. She is a highly experienced mining professional with over 20 years of expertise in sustainable mining, environmental management, and multi-stakeholder engagement. Throughout her career, she has worked with prominent companies such as Oyu Tolgoi (Rio Tinto), Boroo Gold, Aspire Mining, and Khaan Altai Resources.

Erdenetuya holds a bachelor's degree in Environmental Chemistry from the National University of Mongolia and completed the University of Oxford's program on the Role of Extractives for National Development. She is also an accredited international ISO auditor and consultant in Australia, with hands-on experience in environmental and social impact assessments (ESIA) and investment feasibility studies for projects at Oyu Tolgoi and Aspire Mining. Additionally, she served as an environmental consultant for the Australia-Mongolia Extractives Program (AMEP).

She currently leads efforts to integrate responsible mining principles and standards into Mongolia's mineral sector, focusing on multi-stakeholder collaboration and sustainable development. Among these initiatives is the "Future Engineers" program, which aims to build skills and prepare the next generation for Mongolia's mining industry. Erdenetuya also spearheads the formal adoption and localization of Canada's Towards Sustainable Mining (TSM) ESG standard in Mongolia, overseeing agreements, implementation, and awareness-raising activities.



ПАНЕЛИСТ

ЭНХТАЙВАНЫ МЭНДТҮВШИН

Оюу Толгой ХХК-ийн
ТУЗ-ийн гишүүн

Э.Мэндтүвшин нь олон улсын хэлцэл, компанийн засаглал болон хөрөнгийн зах зээлийн чиглэлээр мэргэшсэн хууль болон санхүүгийн зөвлөх юм. Тэрээр дэлхийн зэс, алтны хамгийн том төслүүдийн нэг болох Оюу Толгой ХХК-д Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр мөн компанийн Хүний нөөц, сургалтын хорооны гишүүнээр ажиллаж байна. Э.Мэндтүвшин нь компанийн засаглал, санхүүгийн сахилга бат болон хүний нөөцийн стратегид илүү төвлөрдөг.

Мэргэжлийн замналаа Davis Polk & Wardwell хуулийн фирмд эхлүүлж, дараа нь Morgan Stanley хөрөнгө оруулалтын банканд ажиллах хугацаандаа олон улсын IPO, үнэт цаас гаргах, компани худалдан авах, нэгтгэх (M&A), санхүүгийн бүтцийн шийдлүүд зэрэг хэлцлүүдэд зөвлөгөө өгч ажилласан туршлагатай. Тэрээр эрдэс баялаг (зэс, үнэт метал, шатах ашигт малтмал), үл хөдлөх хөрөнгө, технологи болон санхүүгийн үйлчилгээ зэрэг салбарын компаниудад зөвлөж ажиллаж, шийдвэрлэх үе шатуудад нь хууль эрх зүйн зохицуулалтын ярвигтай сорилтуудыг даван туулахад нь чиглүүлсэн.

Э.Мэндтүвшин нь Харвардын Хуулийн сургуулийн Хууль зүйн ухааны магистр, Бээжингийн их сургуулийн Хууль зүйн бакалаврын зэрэгтэй бөгөөд Нью-Йорк мужийн Хуульчдын холбооны гишүүн юм.



PANELIST

MENDTUVSHIN ENKHTAIVAN

Member of the Board of Directors of
Oyu Tolgoi LLC

Mendtuvshin is a seasoned legal and financial advisor with deep expertise in cross-border transactions, corporate governance, and capital markets. He currently serves on the Board of Directors of Oyu Tolgoi LLC, one of the world's largest copper and gold mining projects, and is a member of its Human Resources and Training Committee. His work at OT focuses on governance, corporate finance, and human capital strategy.

Mendtuvshin began his career at Davis Polk & Wardwell and later worked at Morgan Stanley in Hong Kong, where he advised on complex IPOs, debt offerings, M&A, and structured financings across the Asia Pacific region. He has worked with companies across a range of industries—including natural resources (copper, precious metals, and fossil fuels), real estate, technology, and financial services—guiding them through critical milestones and regulatory complexities.

Mendtuvshin holds a Master of Laws degree from Harvard Law School and a Bachelor of Laws degree from Peking University. He is admitted to the New York State Bar Association.

Салбар хуралдаан ХҮНСНИЙ ХАНГАМЖ

Сэдвийг онцлохын ач холбогдол

Хүнсний хангамж нь үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой өсөлт, хүн амын эрүүл амьдралын үндэс суурь билээ.

Хүнсний аюулгүй байдал, хангамж, иргэдийн эрүүл, зөв амьдрал, хүний бие махбодын хэрэгцээ шаардлагад нийцсэн дотоодын хүнсний бүтээгдэхүүнээр хүн амыг жигд, тогтвортой, хүртээмжтэй, бүрэн хангах, экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, эко системийн тэнцвэрт байдлын доройтол, цөлжилтийн сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Хүнсний хувьсгал" үндэсний хөдөлгөөний хүрээнд гол нэрийн хүнсний 19 бүтээгдэхүүний хангамжийн түвшинг нэмэгдүүлж, сүүлийн 2 жилийн хугацаанд мах, махан бүтээгдэхүүний орлого 600 сая гаруй ам. долларт хүрч, цаашлаад мах, махан бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, зах зээлийг тэлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Цаашид хүнсний хангамжийг тогтвортой нэмэгдүүлэхийн тулд гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлд чиглэсэн хөрөнгө оруулалтыг дэмжих, хүртээмжтэй, үр ашигтай санхүүжилтийн механизмыг бүрдүүлж, хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Хэлэлцүүлгийн зорилго

Хүнс, хөдөө аж ахуйн салбарт биднээс үл хамааран байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлт, олон улсын харилцаа, эдийн засгийн ээдрээтэй бөгөөд таамаглашгүй нөхцөл байдал тулгардаг. КОВИД цар тахлын сорилтууд бидэнд бие даасан, тогтвортой, тэсвэртэй даван туулах хүчин чадалтай байх сургамж өгсөн нь саяхан. Түүнчлэн, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний импортын хараат байдлаас ангижрах бодлогыг цаг ямагт хэрэгжүүлэх нь Үндэсний эрх ашигийг хангах тусгаар улсын үүрэг юм.

Хүлээгдэж буй үр дүн

- Бодлогын шинэчлэл хийхэд чиглэсэн тодорхой санал гаргах
- Хүнсний нөөц, үйлдвэрлэл, логистик-ийн тогтолцоог сайжруулах арга замыг тодорхойлох
- Хувийн хэвшил, төр, олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэж, ногоон хөгжлийг дэмжсэн, дэвшилтэт технологи, инновацид суурилсан хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэх

Sub-Session FOOD SUPPLY

Importance of the topic

Food security is the foundation of national security, economic stability, sustainable development, and human health and well-being.

It encompasses food safety, supply, citizens' health and well-being, fulfillment of physiological needs, and the capacity to sustain life through a reliable food production system. Ensuring a stable, continuous supply chain—from domestic production to reduced dependence on food imports and increased food exports—is critical. It also involves developing resilient production systems, adapting to climate change, preventing ecosystem degradation, and reducing inflationary pressures through cross-sector cooperation.

Under the President of Mongolia's national initiative "Food Revolution", one of the major objectives is to supply the domestic market with 19 essential food items through domestic production. Over the past two years, domestic meat production has increased, meat exports resumed, and over 600 million MNT worth of products have been exported. Additionally, the variety and quantity of domestically produced food has increased, while dependency on imports has decreased.

To further ensure food system resilience and stability, it is essential to support key food product producers, improve access to finance, and strengthen logistics, distribution, and storage infrastructure.

These aspects are vital for long-term sustainability and food security.

Purpose of discussion

Mongolia's food and agricultural sector faces challenges due to geographical constraints, climate change, international relations, and economic fluctuations. The COVID-19 pandemic exposed the vulnerabilities of the sector, highlighting the need for resilience and readiness to handle similar crises. Moreover, reducing the dependency on imported food products and shifting toward national food self-sufficiency is becoming an increasingly important national policy goal. This is also aligned with the objective of strengthening national sovereignty.

Expected outcome from the discussion

Generate clear policy recommendations and refined insights through policy dialogue;

Identify solutions to improve food resources, production, and logistics systems;

Promote collaborative efforts between the private sector, government, and international organizations;

Propose technological advancements and innovation in production to respond to climate change and promote green development.



МОДЕРАТОР БАТТӨМӨРИЙН БОЛОР

МҮОНРТ-ийн Монголын мэдээ сувгийн
ахлах редактор

Б.Баттөмөр МҮОНРТ-ийн ММ агентлагаас бэлтгэн хүргэдэг байсан англи хэл дээрх "MM today" мэдээллийн хөтөлбөрт 2005 оноос эхлэн ажиллаж, одоо Цагийн Хүрд, Тойм тайлбар, Гадаад харилцааны Сэргэлт зэрэг нэвтрүүлгийг бэлтгэн ажиллаж байна. Олон улсын харилцааны магистрын зэргээр Будапештын бизнесийн их сургууль, Герман хэл орон судлалаар МУИС-ийг тус тус төгссөн.

Давосын Эдийн засгийн чуулган, COP16 бэлтгэл ажил нэвтрүүлэг, Хангайн бүсийн чуулган, Гэгээн ширээт улсын төрийн тэргүүн, Бүгд Найрамдах Франц улсын ерөнхийлөгч, Бүгд Найрамдах Австри улсын төрийн тэргүүн, Япон улсын цог жавхлантай эзэн хааны Монгол дахь төрийн айлчлал зэрэг үйл явдлын шууд дамжуулалт болон нэвтрүүлгүүдэд редактороор ажиллан, хөтлөн хүргэж байна.



MODERATOR

BOLOR BATTUMUR

Senior Editor, Mongolian National Broad-
caster (MNB)

Bolor Battumu began her career in 2005 with "MM Today," an English-language news program produced by the MNB News Agency, and currently works on major programs including Tsagiin Khurd (Time Wheel), Toim Tailbar (Commentary Review), and Revival of Foreign Relations.

Bolor holds a master's degree in International Relations from the Budapest Business School and a bachelor's degree in German Studies from the National University of Mongolia. Over her career, she has served as editor and anchor for high-profile broadcasts such as the World Economic Forum in Davos, COP16 preparatory coverage, the Khangai Regional Forum, and the state visits to Mongolia by the Sovereign of the Vatican, the Presidents of France and Austria, and the Emperor of Japan.



МОДЕРАТОР

МЭНДБАЯРЫН МАНДХАЙ

Улсын Их Хурлын гишүүн

М.Мандхай нь "Социал Демократ Монголын Эмэгтэйчүүдийн Холбоо"-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, "Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр"-ийн "Бизнес ба Хүний эрх" төслийн Үндэсний зөвлөх, "Сүү" ХК-ний Гүйцэтгэх захирал, "Монголжин Стратегийн зөвлөх компани"-д Зөвлөх, "Оюу Толгой" ХХК-д Нийгмийн төслүүд хариуцсан төслийн менежерээр ажиллаж байсан. Тэрээр Их Британи улсын "Office of Fair Trading"-д Хэрэглэгчийн зөвшөөрөл, комплайнс хариуцсан мэргэжилтэн, "Ази Номхон Далайн Хөрөнгө Оруулалтын Партнерс" ХХК-д Маркетинг, төслүүд хариуцсан менежер, онд "Нортонсек" ХХК-д Бизнес хөгжил хариуцсан захирал, зэрэг ажлын туршлагатай. 2024 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон.

1988 онд Монгол Улсын Их сургуулийн дэргэдэх хэл бичгээр гүнзгийрүүлсэн лицей, Аялал жуулчлалын удирдлагын дээд сургуулийг Эко-аялал жуулчлалын менежмент бакалавр, Их Британийн Вест Лондон коллеж Аялал жуулчлалын менежмент, Их Британийн Олон Улсын Их сургуулийг Санхүүгийн менежмент, Бизнесийн Удирдлагын чиглэлээр магистр зэргийг тус тус эзэмшсэн.



MODERATOR

MANDKHAI MENDBAYAR

Member of the State Great Hural
(Parliament) of Mongolia

Mandkhai Mendbayar was elected as a Member of the State Great Hural (Parliament) in 2024. She previously served as Secretary General of the Social Democratic Mongolian Women's Association and as a national consultant for the UNDP Business and Human Rights Project, where she led Mongolia's national baseline study. Mandkhai also served as CEO of Suu JSC, managing over 400 employees and overseeing strategic initiatives.

Earlier, she worked as a project manager for community projects at Oyu Tolgoi, a consultant at Monjoljin Strategic Consulting, a specialist in consumer consent and compliance at the UK's Office of Fair Trading, a marketing and projects manager at Asia Pacific Investment Partners, and business development director at Nortonsak LLC.

Mandkhai holds an MBA in Financial Management from the International University of America (UK), a Diploma in Travel Agency Management from West London College, and a BA (Hons) in Eco-Tourism & Hotel Management from ITM Mongolia. She completed her secondary education at the language-focused lyceum of the National University of Mongolia.



ПАНЕЛИСТ

ЧИМИДДОРЖИЙН ДАВААБАЯР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
Үйлдвэр, үйлчилгээний бодлогын
зөвлөх

Ч.Даваабаяр нь “Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо”-ны тэргүүн, Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, доктор (Ph.D), профессор. Монгол Улсад баялаг бүтээгчдийг дэмжих талаар тууштай ажилладаг.

Тэрээр ETV HD телевизийн захирал, МҮОНТ-ийн захирал, Аж үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэрийн үндэсний зөвлөлийн гишүүн, “Баялаг бүтээгчдийг дэмжих Холбоо” ТББ-ын Ерөнхийлөгч, Хөдөлмөрийн Сайдын зөвлөх, Баялаг бүтээгчдийг дэмжих багц бодлого, хуулийн төслийн ажлын хэсгийн дэд дарга, Засгийн Газрын дэргэдэх Төр, хувийн хэвшлийн зөвлөлдөх хорооны гишүүн, Улсын Онцгой Комиссын дэргэдэх “Бизнесийн зөвлөх зөвлөл”-ийн гишүүнээр ажиллаж байсан туршлагатай. Улсын Их Хурлын “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” 36-р тогтоолын хэрэгжилтэд үндэслэн дүгнэлт, зөвлөмж гаргах ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байна.

Тэрээр Мэдээллийн техникийн сургууль, Хан-Уул дээд сургууль Бизнесийн удирдлага, бакалавр, Хүмүүнлэгийн Ухааны Их сургууль сэтгүүл зүй, магистр, Эрдмийн Их сургууль Бизнесийн удирдлагын доктор /Ph.D/, Бизнесийн удирдлагын дэд профессор, Бизнесийн удирдлагын профессор.



PANELIST

DAVAABAYAR CHIMIDDORJ

Advisor to the President of Mongolia on
Industrial and Service Policy

Davaabayar Chimiddorj is the President of the Wealth Creators Support Association, a Merited Cultural Worker of Mongolia, and holds a Ph.D. in Business Administration. He is also a professor, actively dedicated to promoting wealth creators in Mongolia.

He has extensive experience, having served as Director of ETV HD Television and Director of the Mongolian National Broadcaster (MNB). He was a member of the National Council for Small and Medium Enterprises under the Ministry of Industry, President of the Wealth Creators Support Association NGO, Advisor to the Minister of Labor, Deputy Head of the working group on policies and draft laws to support wealth creators, a member of the Government's Public-Private Consultation Council, and member of the "Business Advisory Council" under the State Emergency Commission.

He is currently serving as the head of the working group tasked with issuing conclusions and recommendations on the implementation of Parliamentary Resolution No. 36 on measures to ensure food supply and safety.

Davaabayar holds a bachelor's degree in Business Administration from the Information Technology School and Khaan-Uul College, a master's degree in Journalism from the University of Humanities, and a Ph.D. in Business Administration from Erdem University.

He holds the ranks of Associate Professor and Professor in Business Administration.



ПАНЕЛИСТ

ТӨМӨР-УЯАГИЙН ЖАМБАЛЦЭРЭН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн Төрийн нарийн бичгийн
дарга

Т.Жамбалцэрэн нь Жижиг, дунд үйлдвэрийн газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Улсын Их Хурлын Тамгын газар зэрэг байгууллагуудад мэргэжилтэн, хэлтсийн дарга, зөвлөх зэрэг албан тушаал хашиж байсан. Мөн Үндэсний хөгжлийн бүс болох "Халх гол" бүсийн захирал, МАН-ын Бүсийн зохицуулагч, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Төрийн захиргааны удирдлагын газрын даргаар ажиллаж байсан. 2019 оноос Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэж, 2020 оноос хойш жинхлэн томилогдон ажиллаж байна.

Тэрээр Монгол Улсын Их сургуулийн Нийгмийн ухааны бакалавр, Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. Австралийн Ньюкаслын Их сургуульд нийгмийн өөрчлөлт, хөгжлийн чиглэлээр, олон улсын болон хөгжлийн эдийн засгийн нарийн мэргэшлээр хоёр дахь магистрын зэргээ хамгаалсан.



PANELIST

JAMBALTSEREN TUMUR-UYA

State Secretary, Ministry of Food,
Agriculture and Light Industry

Jambaltseren Tumor-Uya is the State Secretary of Mongolia's Ministry of Food, Agriculture and Light Industry. He previously held key roles in the General Agency for Specialized Inspection, the Agency for Small and Medium Enterprises, and the Secretariat of the State Great Hural (Parliament), serving as specialist, department head, and advisor. He also led the "Khalkh Gol" National Development Zone as Director, served as Regional Coordinator for the Mongolian People's Party, and headed the Administrative Management Department of the Ministry.

He was appointed Acting State Secretary in 2019 and has served in this role permanently since 2020.

Jambaltseren holds a Bachelor's degree in Social Sciences and a Master's in Business Administration from the National University of Mongolia. He also earned a second Master's degree in Social Change and Development with a specialization in International and Development Economics from the University of Newcastle in Australia.



ПАНЕЛИСТ

ГАЛСУМЪЯАГИЙН БАЯРМАГНАЙ

Гүйцэтгэх захирал, АПУ Дэйри ХХК

Г.Баярмагнай нь Монголын тэргүүлэх сүү, сүүн бүтээгдэхүүний компани болох "АПУ Дэйри ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Тэрээр тус компанийн стратеги, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, зах зээлээ тэлэх, шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, түншийн харилцаагаа бэхжүүлэх замаар тогтвортой өсөлтийг ханган ажиллаж байна. Түүний удирдлага дор АПУ Dairy олон шинэ брэндийг зах зээлд амжилттай нэвтрүүлж, лактозгүй бүтээгдэхүүн болон бяслагны үйлдвэр зэрэг томоохон төслүүдийг хэрэгжүүлж, АDB ба EBRD-тай хамтран 40 сая ам.долларын хөрөнгө оруулалтын санхүүжилтийг амжилттай удирдаж байсан. Түүнчлэн Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын (MNCCI) Удирдах зөвлөлийн гишүүний хувиар Монгол улсад бизнесийн орчныг хөгжүүлэхэд идэвхтэй хувь нэмэр оруулж байна.

Г.Баярмагнай нь өмнө нь АПУ JSC-ийн Борлуулалт хариуцсан захирал, Корпорац хоорондын харилцаан захирлаар ажиллаж, компанийн брэнд шинэчлэл, байгууллагын нийгмийн хариуцлагын хүрээнд олон төсөл хэрэгжүүлж, Монголын шар айраг, архины зах зээлд тэргүүлэх байр суурийг бататгасан билээ. Мөн АПУ Trading компанид Борлуулалт, маркетингийн захирал, түүнээс өмнө Маркетингийн албаны захирлаар ажиллаж, олон шинэ бүтээгдэхүүн амжилттай зах зээлд нэвтрүүлж байсан туршлагатай.

Тэрээр Санхүү, Эдийн Засгийн дээд сургуулиас Бизнесийн удирдлагын магистр, Хүмүүнлэгийн Ухааны Их сургуулиас Эдийн засаг, Япон хэлний орчуулагчийн давхар бакалаврын зэрэг эзэмшсэн.



PANELIST
**BAYARMAGNAI
GALSUMIYA**

Chief Executive Officer,
APU Dairy LLC

Bayarmagnai Galsumiya is the Chief Executive Officer of APU Dairy LLC, Mongolia's leading dairy company. In this role, he oversees all strategic operations, driving growth through market expansion, new product launches, and robust stakeholder engagement. Under his leadership, APU Dairy introduced multiple successful brands and managed significant projects including lactose-free and cheese product lines, securing major investment partnerships with ADB and EBRD valued at \$40 million. As a Board Member of the Mongolian National Chamber of Commerce and Industry, he actively shapes the country's business landscape.

Bayarmagnai's earlier roles include serving as Chief Sales Officer and Corporate Affairs Director at APU JSC, where he led brand transformations, implemented impactful CSR initiatives, and expanded market dominance in beer and vodka. Previously, he was Sales and Marketing Director at APU Trading Company, achieving substantial product launches and sales growth, and began his leadership path as Head of Marketing at the same company.

He holds a Master of Business Administration from the Institute of Finance and Economics and a dual bachelor's degree in Economics and Japanese Translation from the University of Humanities.



ПАНЕЛИСТ
**РЭНЦЭНБАТЫН
МӨНХТУЯА**

Хаан Банк ХК-ийн Гүйцэтгэх захирал

ХААН Банкны Гүйцэтгэх захирал Р.Мөнхтуяа нь банкны салбарт 34 жилийн турш ажиллаж байгаа ба ерөнхий нягтлан бодогч, Санхүү хариуцсан дэд захирал, Гүйцэтгэх захирлын орлогч, банк хариуцсан дэд захирал, Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогчоор тус тус ажилласан. 2020 оноос ХААН Банкны Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.

Санхүү Эдийн Засгийн Их сургуулийг Нягтлан бодох бүртгэл, Монгол Улсын Их сургуулийг Эдийн засаг, банк, БНСУ-ын Хандонг Глобал Их сургуулийг Бизнесийн удирдлагын магистрын зэргээр дүүргэсэн.



PANELIST

MUNKHTUYA RENTSENBAT

Chief Executive Officer, Khan Bank

Munkhtuya Rentsenbat is the Chief Executive Officer of Khan Bank, one of Mongolia's leading commercial banks. With over 34 years of experience in the banking sector, she has held a range of senior positions including Chief Accountant, Deputy CEO for Finance, Deputy CEO for Banking, and First Deputy CEO before being appointed CEO in 2020.

She holds degrees in Accounting from the Financial and Economic University of Mongolia and in Economics and Banking from the National University of Mongolia, as well as an MBA from Handong Global University in South Korea.



ПАНЕЛИСТ

ГОМБЫН НЯМЖАРГАЛ

НҮБ-ын ХХААБ-ын
Шадар суурин төлөөлөгч

НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын Монгол дахь Шадар суурин төлөөлөгч, Хөтөлбөр хариуцсан ажилтан, Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Төвд Хүнсний стандартчилалын техникийн хорооны нарийн бичгийн дарга, Чанарын удирдлагын тогтолцооны стандарт хариуцсан мэргэжилтэнээр ажилласан туршлагатай.

Бельгийн хаант улсын Гентийн Их сургуульд Хүнсний технологич, Шим судлалын ухааны магистрын зэрэг хамгаалсан.



PANELIST

NYAMJARGAL GOMBO

Assistant FAO Representative in
Mongolia, Food and Agriculture
Organization of the United Nations

Has experience working as Assistant Resident Representative and Program Officer of the Food and Agriculture Organization of the United Nations (FAO) in Mongolia; Secretary of the Food Standardization Technical Committee at the National Center for Standardization and Metrology; and Specialist responsible for standards of Quality Management Systems.

Holds a Master's degree in Food Technology and Nutrition Science from Ghent University in the Kingdom of Belgium.

Салбар хуралдаан

ЧУХАЛ АШИГТ МАЛТМАЛ, НИЙЛҮҮЛЭЛТИЙН ГИНЖИН ХЭЛХЭЭ

Сэдвийг онцлохын ач холбогдол

Монгол Улсын Засгийн газраас уул уурхайн гаралтай түүхий эд, эрдсийн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг ахиулах, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна. Монголын уул уурхайн салбарын хөгжлийг дараагийн шатанд гаргахын тулд дэлхий нийтийн чиг хандлага болоод байгаа чухал ашигт малтмалын бодлого, стратегийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ хүрээнд уул уурхайн салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах, боловсронгуй болгох ажлууд хийгдэж байна. Ингэснээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар харилцан ашигтай урт хугацааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэнэ. Бид бүхний хамтын ажиллагааны нэг хэсэг нь өнөөдөр болж буй "Монголын эдийн засгийн форум 2025" арга хэмжээ бөгөөд чуулганы салбар хэлэлцүүлгээр "Монголын чухал ашигт малтмал, нийлүүлэлтийн гинжин хэлхээ" салбар хуралдааны хэлэлцүүлэгийг өрнүүлж төр, хувийн хэвшлийнхэн, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, эрдэмтэн судлаачдын санал, шүүмжийг тусган үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх юм.

Хэлэлцүүлгийн зорилго

"Чухал ашигт малтмал, нийлүүлэлтийн гинжин хэлхээ" нээлттэй хэлэлцүүлгийн гол зорилго нь дэлхий нийтийн чиг хандлага болоод байгаа чухал ашигт малтмалын бодлого, стратегийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийнхэн, гадаад дотоодын хөрөнгө оруулагчид, эрдэмтэн судлаачдын санал, шүүмжийг өрнүүлэх, чухал ашигт малтмалын хайгуул судалгаа, олборлолт, боловсруулалтын чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагчдад мэдээлэл хүргэх, энэ талаарх олон улсын туршлагыг судлах, тэдгээрийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх явдал юм.

Хэлэлцүүлгээс хүлээгдэж буй үр дүн

Хэлэлцүүлгийн хүлээгдэж буй үр дүн нь чухал ашигт малтмалын талаарх нэгдсэн ойлголттой болох, чухал ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлэх хайгуул судалгаа, олборлолт, боловсруулалтын чиглэлээр хамтран ажиллах сонирхолтой хөрөнгө оруулагчдыг бодит мэдээллээр хангах замаар хөрөнгө оруулалт татах, олон улсын туршлага солилцох замаар чухал ашигт малтмалын бодлого, стратегийг боловсруулах

Sub-Session

CRITICAL RESOURCES & SUPPLY CHAIN

Importance of the topic

The Government of Mongolia is working with the aim of improving the level of processing of mining raw materials and minerals and increasing the production of value-added products. In order to advance the development of Mongolia's mining sector to the next stage, it is essential to develop and implement policies and strategies of critical resources, which is becoming a global priority. In this context, efforts are underway to improve the legal framework of the mining industry. This will help establish a solid legal foundation for implementing mutually beneficial, long-term projects and programs through public-private partnerships.

One of our collaborative efforts is "Mongolian Economic Forum 2025". As part of the plenary session, the side session of "Critical Resources and Supply Chain" will incorporate insights and feedback from government and private sector representatives, domestic and international investors, and academic researchers to reflect gathered ideas in the future operations of the sector.

Purpose of discussion

The main objective of the discussion "Critical Resources and Supply Chains" is to gather input and feedback from government and private sector representatives, domestic and international investors, and academic researchers to develop policies and strategies for critical resources which is becoming a global priority. Additionally, it will provide information to investors with interests of cooperating in exploration, extraction, and processing of critical resources, and learn international best experiences to integrate them into the operations.

Expected outcome from the discussion

The expected outcomes of the discussion is to create a shared understanding on critical resources, attract foreign investment by providing accurate information to investors with interests of cooperating in exploration, extraction, and processing in order to increase critical resources, and formulate policies and strategies for critical resources through the exchange of international experiences.



ПАНЕЛИСТ БАЯРМАГНАЙН БАТМАНЛАЙ

Сайн Моторс ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Баярмагнайн Батманлай нь хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах чиглэлээр 15 жил ажилласан туршлагатай. Энэ дундаа санхүү, бизнесийн мэдээ мэдээллээр төрөлжсөн Bloomberg TV Mongolia телевизэд 10 жил сэтгүүлчээр ажилласан. Энэ хугацаандаа уул уурхай, таваарын зах зээлийн мэдээ мэдээллээр мэргэшсэнээс гадна дотоодод болон олон улсад өрнөж буй чухал үйл явдлууд, томоохон арга хэмжээнүүдийг олонтаа сурвалжилж байсан. Мөн Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийг удирдлагаар хангаж, Үндсэн хуульд өөрчлөлт оруулах, парламентын засаглалыг бэхжүүлэх чиглэлээр хийгдсэн томоохон ажлуудад гар бие оролцсон. Тэрээр Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. Өдгөө олон улсад нэр хүндтэй автомашины брендүүдийг албан ёсны эрхтэйгээр төлөөлж буй Сайн Моторс ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



MODERATOR

BATMANLAI BAYARMAGNAI

Chief Executive Officer of
Sain Motors LLC.

Batmanlai Bayarmagnai possesses over 15 years of professional experience in the fields of media and public relations. Of these, he dedicated a decade to Bloomberg TV Mongolia, a leading broadcaster specializing in financial and business news, where he served as a journalist. During his tenure, he developed expertise in reporting on the mining and commodities markets, and frequently covered major domestic and international events of political and economic significance.

In addition to his media career, Bayarmagnai held the position of Head of the Media and Public Relations Department at the Secretariat of the State Great Hural (Parliament of Mongolia). In this capacity, he played an active role in several key national initiatives, including constitutional amendments and efforts to strengthen parliamentary governance.

He holds a Master's degree in Business Administration, and currently serves as the Chief Executive Officer of Sain Motors LLC, the official representative and distributor of several globally recognized automotive brands in Mongolia.



ПАНЕЛИСТ

ЦЭВЭГДОРЖИЙН ТУВААН

УИХ-ын гишүүн, Аж Үйлдвэр, Эрдэс
Баялгийн сайд

Ц.Тувсан нь Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын яамны газрын дарга, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын дарга, Үйлдвэр, Хөдөө Аж Ахуйн дэд сайд, АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга, дэд даргаар тус тус ажиллаж байсан. 2017–2020 онд АН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж, намын үйл ажиллагааны бодлогыг удирдан чиглүүлж байв.

2024 онд Улсын Их Хурлын гишүүнээр хоёр дахь удаагаа сонгогдож, Аж Үйлдвэр, Эрдэс Баялгийн сайдаар томилогдон ажиллаж байсан.

Тэрээр Анагаах Ухааны Их сургуулийг хүний их эмч мэргэжлээр бакалавр зэргээр дүүргэсэн.



PANELIST

TUVAAN TSEVEGDORJ

Minister for Industry and Mineral Resources, Member of the State Great Hural (Parliament) of Mongolia

Tuvaan Tsevegdorj previously served as Director-General of the Social Welfare Service Agency, Director at the Ministry of Population Development and Social Protection, Deputy Minister of Industry and Agriculture, Secretary General and Deputy Chairman of the Democratic Party. From 2017 to 2020, he served as Secretary General of the Democratic Party, leading and directing the party's policy activities.

In 2024, he was elected for a second term as a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia and appointed as Minister for Industry and Mineral Resources.

He holds a bachelor's degree in general medicine from the Mongolian National University of Medical Sciences.



ПАНЕЛИСТ

ДУЛАМДОРЖИЙН ТОГТОХСҮРЭН

"Эрдэнэс Критикал минералс"
ТӨҮГ-ын захирал

"Эрдэнэс Критикал минералс" ТӨҮГ-ын захирал Д.Тогтохсүрэн нь Өвөрхангай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, мөн аймгийн Засаг дарга, Монгол улсын Их хурлын гишүүн, Улсын их хурал дахь Монгол ардын намын бүлгийн даргаар ажиллаж байсан туршлагатай.

Цагдаагийн дээд сургуульд эрх зүйч, Удирдлагын академид Төрийн удирдлагын магистрын зэрэг хамгаалсан.



PANELIST TOGTOKHSUREN DULAMDORJ

Director of Erdenes Critical Minerals SOE

Togtokhsuren Dulamdorj is the Director of Erdenes Critical Minerals SOE. He previously served as Speaker of the Citizens' Representatives Hural of Uvurkhangaï Province and as Governor of the province. He was also elected as a Member of the State Great Hural (Parliament) of Mongolia, where he served as Head of the Mongolian People's Party caucus.

Togtokhsuren holds a degree in law from the Police Academy and a master's degree in public administration from the Academy of Management.



ПАНЕЛИСТ КРИСТОФЕР АЛЛУМ

Их Британийн Экспортын
Санхүүжилтийн Газрын (UKEF) Ахлах
Бизнес Хөгжүүлэлтийн Ахлах Ажилтан

Кристофер Аллум нь Их Британийн Экспортын Санхүүжилтийн Газар (UKEF)-т Ахлах Бизнес Хөгжүүлэлтийн Ахлах ажилтнаар ажилладаг бөгөөд тус байгууллагын олон улсын бизнесийн хөгжлийн үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүргийг гүйцэтгэдэг. Тэрбээр голчлон Зүүн Европ, Төв Азийн бүс нутаг (EECAN) болон Ойрхи Дорнодын орнуудыг хариуцан ажилладаг.

UKEF нь Их Британийн экспортын зээлийн агентлаг бөгөөд тус улс дахь компаниудын бараа, үйлчилгээг олон улсад экспортлохыг дэмжих зорилгоор санхүүжилт болон даатгалын үйлчилгээ үзүүлдэг. Энэ хүрээнд UKEF нь Британийн бизнесүүдийн өсөлтийг дэмжээд зогсохгүй, ногоон салбарын манлайлагч байршлыг бататгах, хурдацтай хөгжиж буй орнуудтай худалдаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг өргөн цар хүрээтэй нөлөөг үзүүлж ажилладаг.

UKEF-д ажиллахаасаа өмнө Крис нь хувийн хэвшилд эрчим хүчний салбарт бизнес хөгжүүлэлтийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай бөгөөд уламжлалт шатахуун болон сэргээгдэх эрчим хүчний салбарт ажилласан туршлага бий.



PANELIST

CHRISTOPHER ALLUM

Senior Business Origination Officer at UK
Export Finance

Chris Allum is a Senior Business Origination Officer at UK Export Finance (UKEF), helping coordinate UKEF's international business development activities. In this role Chris works across 2 areas of focus, Eastern Europe and Central Asia (EECAN) & the Middle East.

UKEF is the UK's export credit agency which provides finance and insurance to support long term economic growth for British businesses and their counterparts overseas. UKEF supports UK exports while delivering wider impacts, including bolstering the UK's leadership in green industries and building commercial partnerships with fast growing developing markets. Prior to his role at UKEF, Chris worked in business development across the energy market in the private sector, with experience in both fossil fuels and renewable energy.



ПАНЕЛИСТ

ПҮРЭВЖАРГАЛЫН БАТБАЯР

Азийн хөгжлийн банкны Хувийн
хэвшлийн үйл ажиллагааны газрын
Ахлах олон улсын зөвлөх

Пүрэвжаргалын Батбаяр нь банк, санхүү, уул уурхай, газрын тосны салбарт 25 гаруй жилийн туршлага хуримтлуулсан санхүүгийн мэргэжилтэн юм. Тэрээр Азийн Хөгжлийн Банкны Хувийн хэвшлийн үйл ажиллагааны хэлтэст олон улсын зөвлөхөөр ажиллаж, дэд бүтэц, ногоон санхүүжилтийн чиглэлээр Монгол Улсад 120 гаруй сая ам.долларын хөрөнгө татах ажлыг удирдаж байна. П.Батбаяр нь Resilience Mining Mongolia компанийн ТУЗ-ийн гишүүн бөгөөд Ard Financial Group ХК зэрэг компанид, Монголын анхны криптовалютыг нэвтрүүлэх, даатгал болон ББСБ-ын IPO-г зарлах ажилд оролцож байв. Тэрээр өмнө нь Лондон дахь Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкинд 10 орчим жил ажиллаж, Европ, Азийн улс орнуудад төслийн болон компанийн санхүүжилтийн хэлцлүүдийг удирдсаж байсан туршлагатай.

Санхүүгийн салбараас гадна П.Батбаяр нь Монголын Рагбигийн Холбооны Ерөнхийлөгч, Азийн Рагбигийн Зөвлөлийн гишүүн, Монголын Үндэсний Олимпын Хорооны гишүүнээр ажиллаж байна. Тэрээр Лондонгийн Бизнесийн Сургуулийн санхүүгийн магистр, Уэльсийн Свонсигийн Их Сургуулийн эдийн засгийн бакалаврын зэрэгтэй.



PANELIST

BATBAYAR PUREVJARGAL

Senior International Advisor, Private Sector Operations Department of Asian Development Bank

Batbayar Purevjargal is a board leader and finance professional with over 25 years of experience across banking, finance, mining, oil, and gas. He currently serves as a Senior International Consultant in the Private Sector Operations Department of the Asian Development Bank, where he has helped mobilize over \$120 million for projects in Mongolia, focusing on infrastructure and green finance. Batbayar also serves as a Non-Executive Director at Resilience Mining Mongolia and has held board roles in various companies, including Ard Financial Group JSC, where he helped pioneer Mongolia's first cryptocurrency and supported the IPOs of insurance and non-bank finance subsidiaries. His earlier career includes nearly a decade at the European Bank for Reconstruction and Development in London, closing project and corporate finance deals across Europe and Asia.

Batbayar's leadership extends beyond finance. He is President of the Mongolian Rugby Football Union, a council member at Asia Rugby, and part of the Mongolian National Olympic Committee. Batbayar holds a Master's in Finance from London Business School and a Bachelor's in Economics from the University of Wales Swansea. He has also contributed to community initiatives, including helping establish the Women Corporate Directors Mongolia Chapter.



ПАНЕЛИСТ

ЗУНДУЙСҮРЭНГИЙН ГАН-ОЧИР

Азийн Батарей Метал ХК-ийн
Гүйцэтгэх захирал

Азийн Батарей Метал ХК-ийн гүйцэтгэх захирал З.Ган-Очир нь уул уурхайн салбарт 25 жил хайгуул, олборлолт, хөрөнгө оруулалтын чиглэлээр ажилласан. АНУ-ын Нью-Йоркийн Их сургуулийг санхүүгийн магистр, Шинжлэх Ухаан Технологийн Их сургууль, Канадын Хэйлибуригийн Уул уурхайн сургуулийг тус тус дүүргэсэн. Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциацийн Удирдах Зөвлөлийн гишүүн.

БНСУ-ын Сөүлийн Үндэсний Их сургуульд инженер-эдийн засаг мэргэжлээр доктор /Ph.D/-ын зэрэг хамгаалсан. Түүнчлэн, АНУ-ын Харвардын Их сургуульд Төрийн санхүүгийн удирдлага, Жон Ф. Кеннедигийн Их Сургуульд Засаглалын шинэчлэл, БНСУ-ын Сөүлийн Үндэсний Их сургууль болон Сингапур Улсад Төрийн санхүүгийн удирдлагаар мэргэжил дээшлүүлсэн.



PANELIST

GAN-ОЧИР ZUNDUISUREN

Chief Executive Officer, Asian Battery
Metals JSC

Gan-Ochir Zunduisuren is the Chief Executive Officer of Asian Battery Metals JSC. He brings over 25 years of experience in the mining sector, spanning exploration, extraction, and investment. Gan-Ochir serves on the Board of Directors of the Mongolian National Mining Association.

He holds a Master's degree in Finance from New York University in the United States, and completed studies at the Mongolian University of Science and Technology and Canada's Haileybury School of Mines.

Gan-Ochir also enhanced his expertise through advanced programs in Public Financial Management at Harvard University, Governance Reform at the John F. Kennedy School of Government, and Public Financial Administration at Seoul National University and in Singapore. He earned his Ph.D. in Engineering Economics from Seoul National University in South Korea.



ПАНЕЛИСТ

СЭР-ОДЫН ГАН-ОЧИР

Ашигт малтмал, газрын тосны газрын
Хайгуул, ашиглалтын газрын дарга

С.Ган-Очир нь төрийн албанд Ашигт малтмалын хэрэг эрхлэх газарт мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, тасгийн дарга, Дорнод аймгийн Засаг Даргын Тамгын Газрын дарга, Уул уурхайн яаманд мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, "Монголросцветмет" ТӨҮГ-т ээлжийн мастер, мэргэжилтэн, ерөнхий инженер, цехийн дарга, үйлдвэрлэл эрхэлсэн орлогчоор нийт тус салбарт 21 дэх жилдээ ажиллаж байна. Мөн Баянхонгор, Дархан-Уул аймагт уул уурхайн хоёр төслийг удирдаж эхлүүлсэн.

Тэрээр Шинжлэх Ухаан Технологийн Их сургуульд Уул уурхайн ашиглалтын технологийн инженерээр магистрын зэргийг хамгаалсан.



PANELIST

GAN-OCHIR SER-OD

Director of Exploration and Mining
Department at Resources and Petroleum
Authority of Mongolia (MRPAM)

GAN-OCHIR Ser-Od, Director of Exploration and Mining Department has been working in the mining sector for 21 years. He previously took various roles, including Specialist, Senior specialist, Head of Division of the former Mineral Resources Authority, Head of the Governor's Office of Dornod province, Specialist, Senior specialist of the Ministry of Mining, Shift supervisor, Specialist, Chief Engineer, Head and Deputy Director for production of MONGOLROSTSVETMET SOE. Also he initiated 2 mining projects in Bayankhongor and Darkhan-Uul provinces.

He got Master's Degree in Mining technological engineering from the School of Mining Engineering of the Mongolian University of Science and Technology (MUST).



NAADAM FESTIVAL

“ДЭЭЛТЭЙ МОНГОЛ” АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улсын 819 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114 жил, Ардын хувьсгалын 104 жилийн ой, Үндэсний Их Баяр наадам, “Үндэсний хувцасны өдөр”-ийг тохиолдуулан 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11:00 -17:00 цагт жанжин Д.Сүхбаатарын талбайд “Дээлтэй Монгол - 2025” наадам зохион байгуулагдана.

Зорилго:Монголчуудын уламжлалт өв соёл, үндэсний хувцасны язгуур хэв шинж, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, Үндэсний хувцсаараа дамжуулан үр хойчдоо түүх, соёл, уламжлалаа өвлүүлэн үлдээх, Нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох зорилготой юм.

Ерөнхий зохион байгуулагч:

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
Нийслэлийн Аялал жуулчлалын газар
Хүүхэд, залуучуудын театр

Дэмжигч байгууллага:

Монгол Улсын Соёл, Спорт, Аялал жуулчлалын яам
Хамтран зохион байгуулагч:
Нийслэлийн Соёл Урлагийн газар
Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрууд
“Улаанбаатар театр” ОНӨТҮГ
Монголын Аялал жуулчлалын холбоо

Монгол Костюмс ХХК

Зохион байгуулагдах үйл ажиллагаанууд:

- Монгол үндэсний хувцастай иргэдийн баярын жагсаал
- Монгол туургатан улсуудын төлөөлөл
- Нийслэлийн 6 дүүргүүдийн үндэсний хувцастай иргэд
- Мэргэжлийн урлагийн байгууллагууд
- Байгууллага, аж ахуйн нэгжүүд
- Үндэсний хувцсаараа гоёсон бүх насны, гадаад дотоодын иргэд
- Ардын урлагийн тоглолт- Мэргэжлийн урлагийн байгууллагуудын мэндчилгээ
- Үндэсний хувцасны загварын үзүүлбэр
- Уралдаан, тэмцээн
- Шилдэг дээл урлаач
- Шилдэг үндэсний хувцастай оролцогч /эрэгтэй, эмэгтэй/
- Шилдэг үндэсний хувцастай гэр бүл
- Монгол үндэсний дээлтэй гадаадын шилдэг оролцогч /эрэгтэй, эмэгтэй/
- Хамгийн сайхан дээлтэй хүүхэд /эрэгтэй, эмэгтэй/
- Хамгийн сайхан дээлтэй гадаад хүүхэд /эрэгтэй, эмэгтэй/
- Сайн зохион байгуулалтай, идэвхтэй оролцсон дүүрэг, байгууллага
- Монгол зан заншлыг харуулсан гэр хотхон
- Үзэсгэлэн худалдаа
- Үндэсний тоглоом, наадгай, дээл, хувцас урлаачдын үзэсгэлэн худалдаа
- Тойрон бүжиг

“Дээлтэй Монгол” наадамд Монгол туургатан улсуудын төлөөлөл болон нийслэлийн

9 дүүрэг, 21 аймгийн нийт 10000 гаруй иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудын

төлөөлөл жагсаж 15000 гаруй хүн үзэж сонирхож оролцдог.

БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгар үндэстэн энэ жилийн наадамд хүрэлцэн ирж

өөрийн угсаатны хувцасны онцлогийг харуулахаар төлөвлөөд байна.

“DEELTEI MONGOL 2025” EVENT OVERVIEW

On the occasion of the 2234th anniversary of the establishment of Mongolian Statehood, the 819th anniversary of the Great Mongol Empire, the 114th anniversary of the Restoration of National Freedom and Independence, and the 104th anniversary of the People's Revolution, the National Naadam Festival and National Costume Day will be celebrated with the “Deeltei Mongol 2025” event on July 8, 2025, from 11:00 AM to 5:00 PM at Sukhbaatar Square.

Purpose:

The event aims to promote Mongolia's traditional cultural heritage, highlighting the significance and distinct features of national attire, the clothing and accessories of various ethnic groups, and both tangible and intangible elements of folk art. Through national dress, the event seeks to pass on history, culture, and tradition to future generations, promote Ulaanbaatar on the international stage, and develop innovative tourism products tailored to visitors' interests.

Main Organizers:

- Governor's Office of the Capital City
- Ulaanbaatar City Tourism Department
- Children's and Youth Theater

Supporting Organization:

- Ministry of Culture, Sports, Tourism and Youth of Mongolia

Co-organizers:

- Ulaanbaatar City Department of Culture and Arts
- District Governor's Offices
- “Ulaanbaatar Theatre”
- Mongolian Tourism Association
- Mongol Costumes LLC

Main Program Activities:

- Grand Parade in National Attire
 - o Delegates from Mongolic countries and regions
 - o Residents in national dress from Ulaanbaatar's six districts
 - o Professional performing arts organizations
 - o Companies and institutions
 - o Citizens of all ages, including locals and foreigners, dressed in national costumes
- Folk Art Performance
 - o Special performances and greetings from professional cultural organizations
- National Costume Fashion Show
- Competitions and Contests:
 - o Best Traditional Deel Designer
 - o Best Dressed Participant (Male and Female)
 - o Best Dressed Family
 - o Best Dressed Foreign Participant (Male and Female)
 - o Best Dressed Child (Male and Female)
 - o Best Dressed Foreign Child (Male and Female)
 - o Most Active and Well-Organized District or Organization
- Traditional Mongolian Ger Village
- o Exhibiting traditional lifestyle and customs
- Exhibition and Market
 - o Display and sale of national games, toys, and handmade traditional clothing
- Circle Dance

More than 10,000 participants from Ulaanbaatar's nine districts and Mongolia's 21 provinces, as well as representatives from businesses and organizations, will march in the parade. The event is expected to attract an audience of over 15,000 spectators. Delegations from the Inner Mongolia Autonomous Region and the Xinjiang Uyghur Autonomous Region of the People's Republic of China are expected to participate and showcase their unique ethnic costumes at this year's festival.

"МӨНХӨД ГЭРЭЛТЭХ МОНГОЛ" ГЭРЭЛ ЗУРГИЙН ҮЗЭСГЭЛЭН

Зорилго: "Мөнхөд гэрэлтэх монгол" сэдэв дор үндэсний бахархал болсон төрт ёс, түүхэн уламжлал, өв соёл, үзэсгэлэнт эх орноо гадаад, дотоодын зочид төлөөлөгчид, жуулчин, наадамчин олон монголчууддаа сурталчлах, таниулах, соён гэгээрүүлэх, үндэсний бахархлыг төрүүлэх зорилгоор гэрэл зургийн үзэсгэлэнг бэлтгэж 2025 оны 07 сарын 08-ны өдрөөс 07 сарын 20-ны өдрүүдэд Монголын уран зургийн галерейд дэлгэн үзүүлнэ.

Мөн үндэсний их баяр наадмын өдрүүдэд Япон улсын цог жавхлантай эзэн хаан, хатагтайн хамт айлчлахтай холбогдуулан хоёр орны найрсаг хамтын ажиллагааг харуулсан гэрэл зургуудыг үзэсгэлэнд тавина.

Үйл ажиллагааны хөтөлбөр

2025.07.06 09.00-16:00

Үзэсгэлэнг Монголын уран зургийн галерейд дэглэж, байршуулна.

2025.07.08 11:40-12:40

"Мөнхөд гэрэлтэх монгол" гэрэл зургийн үзэсгэлэнгийн нээлт

/Галерейн 3-р давхрын танхим В хэсэг/

Оролцох хүмүүс: Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яамны төлөөлөл / УУББГ-ын дарга Б.Сэргэлэн бусад төлөөлөгчид/, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл урлагийн газрын удирдлага, мэргэжилтнүүд, аялал жуулчлалын салбарын төлөөлөгчид, дипломат төлөөлөгчийн газрын төлөөлөгчид, Монголын Гэрэл зурагчдын нэгдсэн холбооны удирдлага, удирдах зөвлөл, гишүүд, уран бүтээлчид, гэрэл зурагчид, гэрэл зураг сонирхогчид наадамчин олон оролцоно.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд ирж мэдээ, сурвалжлага бэлтгэнэ.

/ТВ-9, ТВ-5, ТВ-25, МОНЦАМЭ, МПА, ГАММА агентлаг, сайтууд.

2025.07.08- 07.15

10.00-18.00 Гэрэл зургийн үзэсгэлэнг наадамчин олон, нийт иргэдэд нээлттэй

үзүүлнэ. Үзэсгэлэнг тайлбарлах болон хариуцсан 2 хүн галерейд ажиллана.

/МГЗНХ-ны ажлын алба, ГАММА, Бүсгүй мэлмий, Байгалийн гэрэл зургийн

нийгэмлэгүүд хамтран, ээлжлэн ажиллана./

PROGRAM OF THE PHOTO EXHIBITION "ETERNALLY RADIANT MONGOLIA" DEDICATED TO THE 2234TH ANNIVERSARY OF THE FIRST STATEHOOD, THE 819TH ANNIVERSARY OF THE FOUNDING OF THE GREAT MONGOL EMPIRE, AND THE 104TH ANNIVERSARY OF THE PEOPLE'S REVOLUTION AND NATIONAL NAADAM CELEBRATION

Purpose:

Under the theme "Eternally Radiant Mongolia," this photo exhibition aims to promote and raise awareness of Mongolia's national pride—its statehood, historical traditions, cultural heritage, and magnificent homeland—to both domestic and international guests, tourists, and Naadam attendees. The exhibition is also intended to educate and instill a sense of national pride. It will be displayed at the Mongolian National Art Gallery from July 8 to July 20, 2025.

Additionally, in honor of the upcoming state visit by His Majesty the Emperor of Japan and the Empress during the National Naadam Festival, the exhibition will feature photographs that highlight the friendly cooperation and diplomatic relations between Mongolia and Japan.

Program Schedule

July 6, 2025

09:00–16:00 – Exhibition setup and installation at the Mongolian National Art Gallery.

July 8, 2025

11:40–12:40 – Opening Ceremony of the "Eternally Radiant Mongolia" Photo Exhibition
Venue: Hall B, 3rd Floor, Mongolian National Art Gallery

Participants:

- Representatives from the Ministry of Culture, Sports, Tourism, and Youth (including Mr. Sergelen B., Head of the Department of Cultural Heritage and Creative Industry Development)
- Representatives from government implementing agencies and the Cultural and Art Authority
- Stakeholders from the tourism industry
- Diplomatic mission representatives
- Leadership, board members, and members of the Mongolian Photographers' National Union
- Photographers, artists, photography enthusiasts, and the general public

Media coverage will be provided by major outlets including TV-9, TV-5, TV-25, MONTSAME, MPA, GAMMA Agency, and various online platforms.

July 8–20, 2025

10:00–18:00 – The photo exhibition will be open to the public and Naadam festival visitors. Two designated staff members will be present in the gallery to guide and assist visitors throughout the exhibition.

Organizers on duty (rotating):

- Secretariat of the Mongolian Photographers' National Union (MPNU)
- GAMMA Agency
- Busgui Melmii Photography Club
- Society of Nature Photographers

*Together
for tomorrow*

**"МОНГОЛЫН САЙХАН ОРОН" УРАН БҮТЭЭЛИЙН
ҮЗЭСГЭЛЭН**

Монголын Урчуудын Эвлэл (МУЭ) нь дүрслэх урлагийн бүхий л төрлөөр уран бүтээл туурвидаг 700 гаруй мэргэжлийн уран бүтээлчдийг эгнээндээ нэгтгэсэн монголын дүрслэх урлагийн ууган байгууллага юм.

"МОНГОЛЫН САЙХАН ОРОН" үзэсгэлэн нь жил бүрийн Үндэсний их баяр наадмын хөтөлбөрийн соёл урлагийн арга хэмжээний салшгүй нэгэн хэсэг болсон бөгөөд МУЭ-ийн уран бүтээлчдийн шилдэг бүтээлүүдийг дэлгэн харуулдаг, дотоод, гадаадын үзэгчдийн хүсэн хүлээдэг үзэсгэлэнд зүй ёсоор багтсан билээ. Энэхүү үзэсгэлэнд монголчуудын эзэнт гүрнийг байгуулсан үеийн агуу түүх, аж байдал, уламжлал, ахуй заншил, хүн ард, уран байгал, дайчдын алдар гавьяаг магтан дуулсан, монгол хүнийг монгол орны үзэсгэлэнт байгалтай хослуулан гаргасан гүн утга санаа, бодрол өгүүлэгдэх уянга яруу уран зураг, гар урлалын бүтээлүүд тавигддаг.

Эх сайхан орны минь хүндэтгэн үздэг ёсон бүхэн уран бүтээлчдийн бүтээлээр дамжин та бүхний мэлмий оюуныг баясан байдаг нь тус үзэсгэлэнгийн онцлог билээ.

Монгол улсын Соёл, Спорт, Аялал жуулчлал, Залуучуудын яам тус үзэсгэлэнг дэмжин оролцож байгаа бөгөөд үзэсгэлэнгийн зорилго нь наадамчин олон болоод үндэсний баяр наадмыг үзэн сонирхохоор ирсэн жуулчдад Монголын дүрслэх урлагийн өв уламжлал, өнөөгийн чиг хандлага, үндэсний хэв маяг, монгол зураачдын үр чадварыг үзүүлэн таниулах, сурталчлах агуулгатай зохион байгуулагддаг юм.

"МОНГОЛЫН САЙХАН ОРОН" уран бүтээлийн үзэсгэлэн МУЭ-ийн АРТ ГАЛЕРЕЙ-д 2025.07.10-24 дуустал гарах тул үзэгч олон та бүхнийг урьж байна.

/МГЗНХ-ны ажлын алба, ГАММА, Бүсгүй мэлмий, Байгалийн гэрэл зургийн нийгэмлэгүүд хамтран, ээлжлэн ажиллана./

*Together
for tomorrow*

"BEAUTIFUL COUNTRY OF MONGOLIA" ART EXHIBITION

The Union of Mongolian Artists (UMA), the oldest professional organization in the field of visual arts in Mongolia, brings together more than 700 artists working across all genres of visual expression.

The annual exhibition "Beautiful Country of Mongolia" has become an integral part of the cultural and artistic program celebrating the National Naadam Festival. It showcases the finest works of UMA-affiliated artists and holds a prominent place among exhibitions eagerly anticipated by both domestic and international audiences.

This year's exhibition features paintings and handicrafts that poetically and symbolically convey the glory of the Mongol Empire, the traditional way of life, customs, people, majestic landscapes, and the valor of ancient warriors. Through the interplay of Mongolia's rich history and natural beauty, these works explore the deep philosophical and emotional relationship between the Mongolian people and their homeland. A defining feature of the exhibition is its ability to express the reverence for the homeland's heritage and values through the creative vision of artists—offering viewers a profound intellectual and visual experience.

Supported by the Ministry of Culture, Sports, Tourism, and Youth of Mongolia, the exhibition aims to promote the heritage, contemporary trends, and distinctive national aesthetics of Mongolian visual art. It offers local festival-goers and international visitors a meaningful encounter with the skill, creativity, and cultural identity of Mongolian artists. The "Beautiful Country of Mongolia" Art Exhibition will be held at the UMA Art Gallery from July 10 to July 24, 2025. We warmly invite the public to attend and experience the artistic celebration of Mongolia's beauty and spirit.

Together
for tomorrow

ТУЛГАР ТӨРИЙН 2234 ЖИЛ, ИХ МОНГОЛ УЛС БАЙГУУЛАГДСАНЫ 819 ЖИЛ, ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨ, ТУСГААР ТОГТНОЛОО СЭРГЭЭН МАНДУУЛСНЫ 114 ЖИЛ, АРДЫН ХУВЬСГАЛЫН 104 ЖИЛИЙН ОЙН ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН НЭЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Ерөнхий найруулагч, зохиолч: Н.Наранбаатар / ТС, УГЗ/
Ерөнхий продюсер: Г.Цоггэрэл /УГЗ/
Ерөнхий зураач: Т.Ганхуяг /УГЗ/
Ерөнхий бүжиг дэглээч, хөдөлгөөний найруулагч Г.Ган-Очир /СТА/
Гүйцэтгэх продюсер: С.Энхболд /СТА/
Ерөнхий хөгжмийн зохиолч: Б.Чинбат /УГЗ/
Зохиолч: Я.Баяраа

"МӨНХӨД ГЭРЭЛТЭХ МОНГОЛ"

(Эх орноо сэтгэлдээ багтаасан хэн бүхэнд зориулав)

УРИАЛГА: Эх орноо сэтгэлдээ багтаая!

ФИЛОСОФИ: Монгол Улс оршин тогтнохуйн тулганы гурван чулуу нь газар хийгээд ард түмэн, түүнээс сонгогдсон үндсэн хуульт төр юм.

ХИЙЦ, ХЭЛБЭР: "Арт перформэнс" (Үндэсний урлагийн өвийг орчин үеийн үзүүлэх урлагийн аргаар нээн үзүүлэхүй)

БҮТЭЦ: "Монгол нутаг", "Монгол төр", "Монголын ард түмэн" гэсэн гурван цөм утга бүхий үзэгдлүүдэд төвлөрч, Монгол Улс оршин тогтносон бүх цаг хугацаанд бүтэн бүрэлдсэн оюун санааны охь дээжийг харуулсан үзүүлбэрүүдээс бүтнэ.

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН НЭЭЛТ НЬ ДАРААХ ХЭСГЭЭС БҮТНЭ:

Албан ёсны хэсэг:

- МОНГОЛ ТӨРИЙН ЕСӨН ХӨЛТ ЦАГААН СҮЛДИЙГ ЗАЛАХ ЁСЛОЛ
- ТУЛГАНЫ ГАЛ БАДРААХ ЁСЛОЛ (Шинэ дэг найруулга)
- ЭЗЭН ЧИНГИС ХААНЫ ЭШ ХӨРГИЙГ ЗАЛАХ ЁСЛОЛ (Нэмэн шинэчилсэн найруулга)

Together
for tomorrow

Нэгдүгээр бүлэг: Монгол оршин тогтнол

- ПРОЛОГ. ЭГШИГТ МОНГОЛ
- НЭГДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ. ТУСГААР МОНГОЛ
- ХОЁРДУГААР ҮЗЭГДЭЛ. ГЭГЭЭН МОНГОЛ
- ГУРАВДУГААР ҮЗЭГДЭЛ. МАНДАХ МОНГОЛ
- ДӨРӨВДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ. ЭЖИЙ МОНГОЛ

Хоёрдугаар бүлэг: Шинэ Хархорин Шинэ эрин үе

- ТАВДУГААР ҮЗЭГДЭЛ. НАЙРЫН ХОЙМОР МОНГОЛ
- ЗУРГААДУГААР ҮЗЭГДЭЛ. ЭНХ МОНГОЛ
- ЭПИЛОГ. СЭТГЭЛДЭЭ БАГТААСАН МОНГОЛ

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН НЭЭЛТИЙН ХЭСЭГ, ҮЗЭГДЭЛ ТУС БҮРИЙН ТОВЧ АГУУЛГА

Албан ёсны хэсэг 1. МОНГОЛ ТӨРИЙН ЕСӨН ХӨЛТ ЦАГААН ТҮГИЙГ ЗАЛАХ ЁСЛОЛ
Монгол Улсын Үндсэн хуулийн арван хоёрдугаар зүйл болон Үндэсний их баяр наадмын тухай хуулийн зургаадугаар зүйлд заасны дагуу "Монгол төрийн есөн хөлт цагаан туг"-ийг Төв цэнгэлдэх хүрээлэнд залдаг. Есөн хөлт цагаан туг нь "Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг" бөгөөд "түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлэл" юм.
Эзэн Чингис хаан 1206 онд Их Монгол Улсыг байгуулахдаа Есөн хөлт цагаан түгийг залсан түүхтэй бөгөөд, түгийг залах уламжлал алтан ургийн ноёдод уламжилж, тусгай овгууд үеэс үе дамжин тахиж иржээ. Орчин үед 1990 оноос хойш Үндэсний их баяр наадмын нээлтийн эхэнд Есөн хөлт цагаан түгийг залах болсон ба ёслолын найруулгыг найруулагч Г.Доржсамбуу хийж, хөгжмийг Н.Жанцанноров бичжээ. Түгийг залах шарга агтнуудыг Их Монгол Улсыг байгуулах Их хуралдай хуралдсан түүхэн газар нутаг болох Хэрлэнгийн хөдөө арал дахь Төрийн торгон сүргээс сонгодог бол, төрийн түгийг Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Хүндэт харуулын цэргүүд залан авч ирж, баяр наадмын түрш хамгаалдаг билээ.

Албан ёсны хэсэг 2. ТӨРИЙН ТУЛГАНЫ ГАЛ БАДРААХ ЁСЛОЛ

Монголын нэн эртний уламжлалт гал тахилгаас сэдэвлэсэн Төрийн тулгыг бадраах ёслол нь Үндэсний их баяр наадмын нээлтийн чухал хэсэг юм. Монгол бэлгэдэл зүйд гал нь ариун гэгээнийг бэлгэддэг бөгөөд айл гэр, овог аймаг,улс үндэстэн өөдлөн бадрах утгыг агуулдаг. Төрийн тулганы гал бадраах ёслолыг найруулагч Н.Наранбаатарын найруулгаар 2016 оноос хойш хийх болсон юм.
Тулганы гал бадраах ёслолын өмнө Монгол Улсын Ерөнхийлөгч Үндэсний их баяр наадмыг албан ёсоор нээн үг хэлж, Төрийн дуулал эгшиглэдэг. Энэ жилийн баяр наадмын онцлог нь Ерөнхийлөгч У.Хүрэлсүх өөрийн биеэр төрийн тулгыг асаах юм.

Албан ёсны хэсэг 3: ЭЗЭН ЧИНГИС ХААНЫ ЭШ ХӨРГИЙГ ЗАЛАХ ЁСЛОЛ

Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гол тайзны дээр Монгол Үндэстний оройн дээд шүтээн, оюун санааны тусгаар тогтнолын бэлгэ тэмдэг болох Их эзэн хааны хөргийг залж, Үндэсний их баяр наадмын нээлтийн үеэр хөшгийг нь сөхдөг билээ. Энэхүү ёслолыг найруулагч Н.Наранбаатарын найруулга, зураач Т.Ганхуягийн загвараар 2022 оноос эхлэн уламжлал болгон хийх болсон юм.
Энэ жил мэндэлсний 810 жилийн ойн тохиож буй Их хаан Хубилай эш хөрөг залах ёслолын нэгэн чухал дүр болно. Мөн монголын домогт "Чингис хаан" рок хамтлагийн ижил нэртэй дуу ёслолын суурь болж, YUIT-ын ёслол хүндлэлийн бүжиг болон морьтонгуудын үзүүлбэр эш хөрөг залах ёслолын үеэр наадамчдын мэлмийг мялаана.

Пролог: ЭГШИГТ МОНГОЛ

Монгол наадам монгол төрийн уртын дуугаар эхэлдэг уламжлал ёсоор "Асарын өндөр" уртын дуу нээлтийн эхэнд эгшиглэнэ. Төрийн уртын дуунд "Эртний сайхан", "Түмэн эх", "Хуур магнай", "Дуртмал сайхан", "Хэрлэнгийн бараа" /баръяа/, "Их замбуутивийн наран", "Асарын өндөр", "Эрхэм төр", "Энх мэндийн баяр" зэрэг дуунууд багтдаг.

"Эгшигт монгол" хэмээх энэхүү оршил үзүүлбэрт монгол эгшиг аялгууны оргил, нэрийн хуудас болсон морин хуурыг 300 морин хуурч тоглоно. "Монголын нууц товчоон" хөлгөн сударт өгүүлсэнчлэн "монголчуудын жаргал нь бүжин наадах" бөгөөд морин хуур, уртын дууныхаа эгшиг аялгуу дор орчин цагийн монголчууд бүжин наадсанаар Үндэсний их баяр наадмын нээлтийн үндсэн хэсэг эхлэх болно. Энэхүү эхлэл хэсгийн дүрслэгдэхүүнийг Төрийн шагналт зураач Ядамсүрэнгийн Үржнээгийн үндэсний соёлын сэдэвт зургуудаас сэдэвлэсэн болно.

НЭГДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ. ТУСГААР МОНГОЛ

Монгол Улсын тогтнолын үндэс нь газар нутаг болон ард түмэн, ард түмнээс сонгогдсон төр юм гэсэн санааг энэхүү үзэгдэлд зангидан илэрхийлэх болно.

Үзэгдлийн эхэнд “Асарын өндөр” айзам уртын дууны өргөн царай бүхий эгшиглэлд таацуулан, монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Дашдоржийн Нацагдоржийн “Миний нутаг” шүлгийг цэнгэлдэх даяараа түрэн уншина. Монгол орны одоогийн газар нутаг болоод бүгд найрамдах засаглалын мөн чанарыг өгүүлсэн энэхүү шүлгийн агуулгыг монгол үндэстнийг бүрдүүлэгч язгуур угсаатнуудын соёлын онцлогийг харуулах 21 бичил тайзан дээрх бүжгийн үзүүлбэр дэмжинэ.

Яруу найргийн араас яруу найраг залгаж, Дэндэвийн Пүрэвдоржийн алдарт “Тусгаар тогтнол” шүлгээр бүтээсэн дуугаа дуучин Батсайханы Батчулуун дуулах үеэр монгол хүн мэндэлж, хүний хорвоод мөрөө гаргаж буй тухай үзүүлбэр тоглоно. Энэхүү үзэгдэлд Монгол Улсын тусгаар тогтнолын талаар уламжлал, орчин үе болон орон зайн урлагт тулгуурласан цогц, яруу өгүүлэмжийг амилуулахыг зорив.

ХОЁРДУГААР ҮЗЭГДЭЛ. ГЭГЭЭН МОНГОЛ

Монгол орон бол нүүдэлчний соёлын гал голомт, эдүгээ цаг хадгалан хөгжүүлж буй гол үндэстэн гэдгийг энэхүү үзүүлбэрт үзүүлнэ. Байгаль эхтэйгээ шүтэн барилдаж амьдрах монгол хүний сэтгэлгээний онцлог нь нүүдэлчний соёлын үндэс болохоос гадна гэгээрлийн мөн чанарыг агуулдаг.

Нүүдэлчний соёлын гол түлхүүр болсон адууны соёлыг сурталчилж, дэлхийн адууны өдрийг санаачилсан түүхэн үйл явдлыг морь цололгоо, морьтнуудын олон талт үзүүлбэрээр илэрхийлэх болно. Мөн даян дэлхийн бүх үндэстэнд эрх тэгш нээлттэй гадаад бодлогын өнө эртний уламжлалыг Үндэсний их баяр наадмын хүндэт зочин Японы эзэн хаан Нарүхитод зориулсан цэн тогорууны зохиомжит үзүүлбэрээр үзүүлэх юм. Хөгжмийн зохиолч Батсайханы Чинбатын “Бадралт монгол” бүтээл энэ үзүүлбэрийн гол суурь болно.

ГУРАВДУГААР ҮЗЭГДЭЛ: МАНДАХ МОНГОЛ

Өндөр гэгээн Занабазар монгол үндэстний мандал бадралыг бэлгэдэн бүтээсэн соёмбо үсэг, түүнд хураасан энэрэнгүй үзэл санааг илэрхийлэхэд энэхүү үзэгдэл зориулагдана.

Өндөр гэгээн Занабазарын онцгой оюун санааны ертөнцийг илэрхийлэхийн тулд хөгжмийн зохиолч Цогзолын Нацагдоржийн “Нүүдэл” бүжгэн жүжгийн шинэчилсэн хөгжмийн найруулга, хөгжмийн зохиолч Дашдаваагийн Баттөмөрийн аялгуу, яруу найрагч Пунцагийн Бадарчийн шүлэг “Есөн эрдэнийн орон” дуу үзэгдлийн турш эгшиглэнэ.

Үзэгдлийн турш орон зайн үзэмжит дүрслэгдэхүүн үүсгэх олныг хамарсан үзүүлбэрүүд, бүжгийн шинэ найруулгуудыг толилуулж, төсгөлд нь эрдэнийн соёмбо үсгийг тэнгэрт хөөргөх болно.

*Together
for tomorrow*

ДӨРӨВДҮГЭЭР ҮЗЭГДЭЛ: ЭЖИЙ МОНГОЛ

Эхийг шүтэх үзэл бол “Монголын нууц товчоон” зэрэг түүхэн сурвалжуудад чухалчлан тэмдэглэгдэж үлдсэн, монгол соёл, монгол хүний ёс суртахууны үнэлэмжид чухал үүрэгтэй сэтгэлгээ гэдгийг энэхүү үзэгдэлд толилуулна. “Монголын нууц товчоон” дахь Алунгоо эхийн домгоос сэдэвлэсэн Дагвын Лувсаншаравын хөгжим “Нарны домог” бүжгийн жүжгээр үзэгдэл эхэлж, Бямбасүрэнгийн Шаравын “Бөртэ хатан” аялгуугаар үргэлжилнэ.

“Одонтой ээжүүдийн холбоо”-ны ээжүүд болон мэргэжлийн бүжигчид, хүүхдүүд зэрэг олны хамарсан үзүүлбэрүүдээс гадна эхийн ачийг хариулах тухай жүжигчилсэн үзүүлбэр зэрэг олон тооны уялдаа холбоо бүхий үйлдлүүдээр дамжуулан эхийгээ хайрлах хайр нь хүнлэг үзлийн үндэс, хүн төрөлхтний нийтлэг хэл гэдгийг илэрхийлэх болно.

ТАВДУГААР ҮЗЭГДЭЛ. НАЙРЫН ХОЙМОР МОНГОЛ

Эртний баатарлагийн туульс, түүхэн сурвалжуудад монголчуудын найрыг ихэд онцолдог. Монголчуудын найр нь энх амгаланг бэлгэдэх бөгөөд, энх тайвныг тогтоох, түүнийгээ хамгаалах хүсэл эрмэлзлийн илэрхийлэл болдог. Энэхүү утга санааг орчин үеийн визуал дүрслэл, хөгжмийн найруулгаар илэрхийлэх болно. Үзэгдэл хөгжмийн зохиолч Нацагийн Жанцанноровын бүтээл, алдарт “Би чамд хайртай” киноны удиртгалд зохируулан, гэр бүлийн харилцаа, хайр сэтгэлийн мөн чанарыг өгүүлсэн үзүүлбэрүүдээр эхэлнэ. Ц.Нямдоржийн аялгуу, яруу найрагч Бавуугийн Лхагвасүрэнгийн үг “Хос багана” дуугаар үзэгдлийн дараагийн хэсэг эхэлж, монгол найрын хэмнэлийг илэрхийлэх ардын хөгжим, бүжиг, дайралцаан зэрэг биет бус өвүүдийн нийцэлд найруулгыг тоглоно. Үзэгдлийн турш төв цэнгэлдэхэд цугларсан наадамчид найрын зочид болж, дэлхий даяар нээлтийг үзэж буй хүмүүс хамтдаа найрлахад зориулсан хэмнэлтэй байна.

ЗУРГААДУГААР ҮЗЭГДЭЛ. ЭНХ МОНГОЛ

Монгол угсаатны байгуулсан эзэнт гүрнүүд дэлхийн түүхэнд хамгийн урт удаан үргэлжилсэн энх тайван цаг үеийг бий болгосон хийгээд, хэл, соёл, шашин, арьсны өнгө үл харгалзан нэгэн тэнгэрийн дор амар амгалан амьдрах тухай “Тэнгэр үзэл”-ийг энэхүү үзэгдэлд магтан дуулах болно.

Үзэгдэл хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Шаравын “Баяр уянга” аялгуунд тулгуурлан бүтээсэн шинэ дуунд суурилах бөгөөд Үндэсний их баяр наадмын нээлтэд оролцсон бүх орон бүтээлчид нийтийг хамарсан үзүүлбэр үзүүлнэ.

*Together
for tomorrow*

ЭПИЛОГ: СЭТГЭЛДЭЭ БАГТААСАН МОНГОЛ

Монгол наадам бол монгол угсаатны мөн чанар, монголчуудын бүтээсэн соёлын онцлогийн охь дээд илэрхийлэл гэдгийг үзүүлэхэд төгсгөлийн үзүүлбэр зориулагдана.

Монголын орчин үеийн хөгжмийн томоохон төлөөлөгч Хурд хамтлаг, дорнын их яруу найрагч Бэгзийн Явуухулангийн "Би хаана төрөө вэ" шүлэгт зохируулан бүтээсэн дуугаар Үндэсний их баяр наадмын нээлт өндөрлөнө.

NAADAM FESTIVAL 2025 – OFFICIAL OPENING CEREMONY PROGRAMME

Commemorating 2,234 Years of Statehood, 819 Years Since the Founding of the Great Mongol Empire, 114 Years Since the National Revival of Independence and Sovereignty, and the 104th Anniversary of the People's Revolution

TITLE: EVERLASTING MONGOLIA

Motto: Let Us Encompass the Homeland in Our Hearts

Philosophy: The three spiritual cornerstones of the Mongolian State are its sacred land, its people, and the constitutionally mandated democratic governance chosen by the people.

Form and style: Art Performance – a contemporary staging of traditional Mongolian cultural heritage.

Structure: The performance unfolds through three central themes: 'The Land of Mongolia,' 'The Mongolian State,' and 'The People of Mongolia,' each expressing the essence of the nation's eternal existence and profound cultural identity.

Official Segment of the Opening Ceremony:

- Ceremony of Elevating the Nine White Banners of State
- Ceremony of Lighting the Eternal State Hearth (New Staging)
- Ceremony of Unveiling the Portrait of Chinggis Khaan (Revised and Enhanced Edition)

Act I: Mongolia's Eternal Existence

- Prologue: Harmonious Mongolia
- Scene 1: Sovereign Mongolia
- Scene 2: Enlightened Mongolia
- Scene 3: Rising Mongolia
- Scene 4: Mother Mongolia

Act II: New Kharkhorin – A New Era

- Scene 5: Mongolia, the Heart of Festivity
- Scene 6: Peaceful Mongolia
- Epilogue: Mongolia Within Our Hearts

Detailed Content of the Opening Ceremony

Official part 1: Ceremony of Elevating the Nine White Banners of State

In accordance with Article 12 of the Constitution of Mongolia and Article 6 of the Law on the National Festival, the Nine White Banners of the State are ceremonially elevated at the Central Stadium. These banners symbolize the independence and sovereignty of

Mongolia, and represent the nation's aspirations, unity, justice, and eternal vitality. This tradition dates back to 1206, when Chinggis Khaan proclaimed the foundation of the Great Mongol Empire and elevated the nine white banners. Since then, the sacred banners have been passed down through noble lineages and safeguarded by dedicated tribes. Since the democratic transition in 1990, this ceremony has become a central element of the National Naadam Festival, as staged by director Dorjsambuu Gursed and composed by Jantsannorov Natsag.

The stallions carrying the banners are chosen from the elite herd residing at Khuduu Aral by the Kherlen River—the historical site of the founding of the Great Mongol State. The banners are escorted by the Honor Guard of the Armed Forces Unit No. 032 and remain under ceremonial protection throughout the festival.

Official part 2: Ceremony of Lighting the Eternal State Hearth

Inspired by ancient Mongolian fire rituals, this ceremonial lighting of the State Hearth has become a sacred moment in the opening of the Naadam Festival. In Mongolian symbolism, fire represents purity, vitality, and the prosperity of families, clans, and the nation.

This ceremony, directed by Naranbaatar Namnan since 2016, begins with the President of Mongolia formally opening the festival and delivering an address, followed by the national anthem. This year, President Ukhnaagiin Khurelsukh will personally ignite the ceremonial flame.

Official part 3: Unveiling the Portrait of Chinggis Khaan

At the heart of the Central Stadium's main stage, a revered portrait of the Great Chinggis Khaan is unveiled, symbolizing the spiritual sovereignty and supreme heritage of the Mongolian nation. This tradition, styled by director Naranbaatar Namnan and designer Gankhuyag Tumor....., has been observed annually since 2022.

In 2025, the ceremony will feature the portrait of Khubilai Khaan, marking the 810th anniversary of his birth. The legendary Mongolian rock band "Chinggis Khaan" will perform their iconic namesake song, accompanied by a state tribute dance by the Ulaanbaatar Ensemble and a horsemen's parade.

Prologue: Harmonious Mongolia

In keeping with tradition, the Naadam Festival opens with a long song, a revered genre of Mongolian folk music. This year's opening begins with the performance of "Asaryn

undur" a state long song. Other emblematic long songs include "Ertnii saikhan", "Enkh mendiin bayar", "Erkhem tur" "Khuur magnai", "Tumen ekh", "Kherlengiin bariya", "Durtmal saikhan" and "Uyakhan zambuutiivin naran".

In the prologue, 300 morin khuur (horsehead fiddle) players will perform in unison, symbolizing the spiritual harmony of Mongolia.

As described in "The Secret History of the Mongols", the Mongolian people's happiness is expressed in dance—thus, the people of modern Mongolia will celebrate through song and dance, heralding the beginning of the main ceremonial programme. The presentation draws inspiration from the national paintings of State Laureate artist Urjnee Yadamsüren.

Scene 1: Sovereign Mongolia

This scene conveys the core idea that the foundation of Mongolian statehood rests on its sacred land, people, and government chosen by the people. It begins with a collective recitation of the poem 'My Homeland' by Natsagdorj Dashdorj, a founding figure of modern Mongolian literature, accompanied by the melody of the long song "Asarin Undur". On 21 small stages of traditional dance performances will showcase the cultural identity of Mongolia's diverse ethnic groups. This is followed by a dramatized portrayal of birth and life, as singer Batchuluun Batsaikhan performs the powerful song adaptation of Purevdorj Dendeev's poem "Independence".

Scene 2: Enlightened Mongolia

This performance highlights Mongolia as the spiritual stronghold of nomadic civilization. It explores the worldview of the Mongolian people, whose reverence for nature is deeply rooted in the nomadic mindset—a philosophy of balance, harmony, and enlightenment. The cultural significance of horses and Mongolia's initiation of World Horse Day will be celebrated through a grand horse parade and accompanying performances. A choreographed crane dance will honor Emperor Naruhito of Japan, the festival's guest of honor, underscoring Mongolia's historic tradition of open and peaceful diplomacy. The background score is "Radiant Mongolia" composed by Chinbat Batsaikhan.

Scene 3: Rising Mongolia

This scene pays tribute to the enlightened vision of Undur Gegeen Zanabazar, who created the Soyombo script—a national symbol of prosperity, peace, and wisdom. The performance is accompanied by a new arrangement of the ballet "Nomadic migration" by Natsagdorj Tsogzol, alongside "Land of Nine Jewels" a poetic song composed by Battumur Dashdava with lyrics by Badarch Puntsag. The culmination will be a symbolic visual of the Soyombo sign rising into the sky, surrounded by large-scale visual presenta-

tions and choreographed mass movements.

Scene 4: Mother Mongolia

This scene reveres the cultural and moral ethos of honoring the mother—deeply embedded in Mongolian values and highlighted in sources like “The Secret History of the Mongols”. It begins with a dance based on the legend of Alungoo Ekh, set to Luvsansharav Dagva “Legend of the Sun”, and continues with “Queen Borte” composed by Sharav Byambasuren.

The performance includes mothers from the “Association of Mothers with Orders” professional dancers, and children, culminating in a dramatic scene about repaying a mother’s love. The message: love for one’s mother is the foundation of compassion and a universal human language.

Scene 5: Mongolia, the Heart of Festivity

Mongolian epics and chronicles emphasize the importance of feasting and celebration as symbols of peace and unity. This scene expresses those themes through modern visual storytelling and musical arrangements.

